

МАЛЧДЫН НИЙГЭМ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЗАН ҮЙЛИЙН СУДАЛГАА

Эцсийн тайлан



Улаанбаатар
2022

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
Дүрсийн жагсаалт	4
Хүснэгтийн жагсаалт	6
ХУРААНГУЙ.....	7
1. ҮНДЭСЛЭЛ.....	10
2. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ.....	12
2.1 Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахад нөлөөлөх хүчин зүйлс	12
2.2 Нүүдэлчин, хөдөө орон нутгийн хүн амын нийгмийн болон эрүүл мэндийг хамгаалах олон улсын туршлага.....	15
3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ХАМРАХ ХҮРЭЭ.....	23
3.1. Судалгааны зорилго.....	23
3.2. Судалгааны дизайн.....	24
3.3. Судалгаа болон туршилтын дизайн	25
4. МОНГОЛ: МАЛЧИД БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН СИСТЕМ.....	30
4.1. Монгол малчид	30
4.2. Малчдад зориулсан нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын харилцааны гол оролцогч талууд 37	
4.3. Хуулийн гол заалтууд ба одоогийн хамрагдалтын хэмжээ	39
4.4. Нийгмийн даатгалын хууль, бодлогын зохицуулалт дах зөрүү болон тулгамдсан асуудлууд 46	
4.5. Ололт, асуудлуудын хураангуй	49
5. НИЙГМИЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААРХ МАЛЧДЫН ЗАН ҮЙЛ	51
5.1. Оролцогчдын хувийн болон өрхийн хүн ам зүйн мэдээлэл ба нийгэм, эдийн засгийн шинж байдал51	
5.2. Малчдын амьдралын мөчлөгийн эрсдэлүүд	59
5.3. Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэг, ухамсар	61
5.4. Эрсдэл, цаг хугацаа, итгэлцэл мөн аливаа зүйлийн үндсэн шалтгааныг үзэх хувь хүний ойлголт	70
5.5. Нийгмийн даатгалд хамрагдах болон хамрагдахгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлс	72
5.6. Шийдвэр гаргах туршилт	74
6. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЗӨВЛӨМЖ	81
6.1. Эрэлтэй холбоотой сорилтууд	81
6.2. Нийлүүлэлт талын сорилтууд	82
6.3. Зөвлөмж	85
7. ДҮГНЭЛТҮҮД	89
Хавсралт	92

Товчилсон үгийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГМЯ	Голлох мэргэжилтний ярилцлага
ИРИМ	Хараат бус судалгааны хүрээлэн
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НД	Нийгмийн даатгал
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
ОУСС	Олон улсын сонголтын судалгаа
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
САТИ	Компьютерын тусламжтай утсан ярилцлагын аАрга
ТД	Тэтгэмжийн даатгал
ТДН	Туршилтын дундаж нөлөө
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБ	Хөгжлийн бэрхшээл
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

Дүрсийн жагсаалт

Дүрс 1. Судалгааны бүрэлдэхүүн хэсгүүд.....	24
Дүрс 2. Зорилтот газруудаас малчдын дэлгэрэнгүй мэдээллийг олж авахдаа ашигласан арга	29
Дүрс 3. Малчдын тоо, 2010-2020	30
Дүрс 4. Малчдын насны байдал бүтэц, 2011-2020.....	31
Дүрс 5. Малчин өрхийн малын тоо, хонин толгойд шилжүүлснээр	34
Дүрс 6. Малчин өрхийн зардлын байдал.....	36
Дүрс 7. 1994 оны Нийгмийн дДаатгалын тухай хуулийн дагуу олгогдох нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжүүд	40
Дүрс 8. Судалгаанд оролцогчид, насны бүлгээр.....	51
Дүрс 9. Судалгаанд оролцогчид, гэрлэлтийн байдлаар.....	51
Дүрс 10. Оролцогчдын боловсролын түвшин, хүйсээр.....	52
Дүрс 11. Оролцогчдын боловсролын түвшин, насны бүлгээр	52
Дүрс 12. Хүүхдийн тоо.....	52
Дүрс 13. Эцэг эхийг тань хэн асардаг вэ.....	52
Дүрс 14. Өрх тус бүрт одоогоор амьдарч буй хүний тоо.....	53
Дүрс 15. Өрх тус бүрт байгаа бүртгэлтэй малчдын тоо	53
Дүрс 16. Танай өрхийн сууц хаана байрладаг вэ?	53
Дүрс 17. Танд хэдэн сууц байгаа вэ?	53
Дүрс 18. Танай өрхөд доорх өмч хөрөнгө байдаг уу? (олон сонголттой).....	54
Дүрс 19. Танай гэр бүлийн дундаж орлого хэд вэ?	54
Дүрс 20. Та өөрийн болон гэр бүлийн орлогын нөхцөл байдлыг тодорхойлно уу,	55
Дүрс 21. Зээл болон хадгаламжийн байдал, орлогын түвшнээр	55
Дүрс 22. Танай өрх аливаа малчдын бүлгэм/хоршоо/холбоодод харьяалагддаг уу, байршлаар ..	56
Дүрс 23. Танай өрх аливаа малчдын бүлгэм/хоршоо/холбоодод харьяалагддаг уу, насны бүлгээр	56
Дүрс 24. Мал аж ахуйтай холбоотой чухал шийдвэр гаргахаасаа өмнө хэнтэй зөвлөлддөг вэ? ...	57
Дүрс 25. Та одоогийн байдлаар өөрийн малыг даатгалд хамруулсан уу? Өрхийн орлогын түвшингээр.....	57
Дүрс 26. Ямар шалтгааны улмаас та малаа даатгуулж байсан/байна вэ?	58
Дүрс 27. Эрүүл мэндийн байдал, насны бүлгээр	59
Дүрс 28. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо; Чанар болон иИтгэлийн үнэлгээ, эрүүл мэндийн байдлаар.....	59
Дүрс 29. Хөгжлийн бэрхшээлтэй оролцогчид, хувиар	60
Дүрс 30. Өрхөд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг оролцогчид, хувиар	60
Дүрс 31. Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан	60
Дүрс 32. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, хүйсээр	61
Дүрс 33. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлгээр	61
Дүрс 34. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, боловсролын түвшнээр	62
Дүрс 35. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, орлогоор	62
Дүрс 36. НДС-д нэгдэх, нөхөн даатгуулах боломжийн талаарх мэдлэг	64
Дүрс 37. НДС-ийн талаарх мэдлэг, насны бүлгээр	64
Дүрс 38. Нөхөн даатгуулах болон хэрхэн даатгуулах талаарх мэдлэг, насны бүлгээр	64
Дүрс 39. Малчдын НДШ төлж буй байдал	65
Дүрс 40. Одоогийн хамрагдсан байдал, боловсролын түвшинээр.....	65

Дүрс 41. Одоогийн хамрагдсан байдал, өрхийн орлогоор.....	65
Дүрс 42. Одоогийн хамрагдсан байдал, байршлаар	66
Дүрс 43. НДС-д хамрагдаагүй шалтгаан	68
Дүрс 44. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, одоогийн хамрагдалтын байдлаар	68
Дүрс 45. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, насны ангилалаар.....	68
Дүрс 46. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, өрхийн орлогоор	69
Дүрс 47. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, хадгаламжийн байдлаар	69
Дүрс 48. Хэн нэгэн таны нийгмийн даатгалд хамрагдах тухай санал болгож байсан уу?	70
Дүрс 49. Хэн нэгэн таны нийгмийн даатгалд хамрагдах тухай санал болгож байсан уу?, байршлаар	70

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Туршилт судалгааны хүрээнд ашиглагдах нөхцлүүд	26
Хүснэгт 2. Түүврийн хэмжээ.....	27
Хүснэгт 3. Түүвэрлэлтийн үе шатууд.....	27
Хүснэгт 4. Нас болон хүйсийн статистик.....	28
Хүснэгт 5. Малчдын гэрлэлтийн байдал, 2020.....	31
Хүснэгт 6. Малчдын боловсролын түвшин, 2020	32
Хүснэгт 7. Малчин өрхийн орлогын бүтэц.....	34
Хүснэгт 8. Малчин өрхийн сарын дундаж орлого, байршил, мянган төгрөг, 2017 он	35
Хүснэгт 9. Малчдын жилийн орлогын улирлын хэлбэлзэл	35
Хүснэгт 10. Малд нөлөөлөх гадны нөлөөллийн давтамж, 2018-2019	36
Хүснэгт 11. Оролцогч талуудын ангилал.....	38
Хүснэгт 12. Нийгмийн даатгалын статистик 1995-2020 (мянгаар).....	41
Хүснэгт 13. Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, 2020.....	42
Хүснэгт 14. Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого, сая төгрөгөөр, 2019-2021.....	43
Хүснэгт 15. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сангийн төрлөөр, сая төгрөгөөр	44
Хүснэгт 16. Малчин гэр бүлүүдийн авдаг нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмж	55
Хүснэгт 17. Малын тоо болон сүүлийн 12 сард алдсан малын тоо, байршлаар.....	56
Хүснэгт 18. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гол шалтгаанууд	62
Хүснэгт 19. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй шалтгаан	63
Хүснэгт 20. НДС-нд хамрагдалтын шалтгаан, насны бүлгээр	66
Хүснэгт 21. НДС-д хамрагдахаа больсон шалтгаан (олон сонголттой), насны бүлгээр	67
Хүснэгт 22. Эрсдэл, цаг хугацааны хөнгөлөлт, итгэлцэлд хандах хандлага, хувиар.....	71
Хүснэгт 23. Эрсдэл, цаг хугацаа (аливаа үр өгөөжийг цаг хугацаагаар хэмжих) болон итгэлцэлд хандах хандлага, тодорхойлох статистик, хувиар	71
Хүснэгт 24. НДС-ийн гишүүнчлэлийн хоёртын регрессийн загварууд, магадлалын харьцаан дахь коэффициентууд.	73
Хүснэгт 25. Мал, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдах хос шугаман корреляцийн матриц	74
Хүснэгт 26. Даатгуулагчдын шимтгэл төлөх эрмэлзэл, туршилтын бүлгийн хувиар	75
Хүснэгт 27. Хандлагын оноог нийцүүлсний дараах хосолмол дундаж туршилтын үр нөлөө	76
Хүснэгт 28. Даатгуулаагүй хүмүүсийн шимтгэл төлөх эрмэлзэл, тайлбарлах хувьсагч, хувиар.....	76
Хүснэгт 29. НДС-д шимтгэл төлж эхлэх эрмэлзлийн логистик регрессийн загварууд, магадлалын харьцаагаар үр дүнг харуулав.	78
Хүснэгт 30. Шимтгэл төлж эхлэх эрмэлзэлгүй байгаа шалтгаан, хувиар.....	79
Хүснэгт 31. НДС-д одоогоор шимтгэл төлөхгүй байгаа гол шалтгаан-, шимтгэл төлөх эрмэлзлээр (мөр хувиар, Нийт багана хуваарилалтыг илэрхийлнэ).....	80

ХУРААНГУЙ

Монгол Улсад 2020 оны байдлаар нийт өрхийн 27 хувь нь буюу 242,024 өрх мал аж ахуй эрхлэн амьдарч байна. Нийт хүн амын 9 хувь нь малчин хэмээх ангилалд бүртгэлтэй байна. Нийт малчдын 32 хувь нь 'ядуу' өрхөд хамаарна хэмээн тооцоолсон (Ганчимэг нар, 2019) боловч малчдын дунд тэгш бус байдал оршсоор байна. Малчин өрхүүдийн дөнгөж таван хувь нь нийт малын 22 хувийг өмчилдөг бол 45 орчим хувь нь 200-аас доош толгой малтай буюу хүлээн зөвшөөрөгдсөн, амьжиргаагаа залгуулах боломжит тоо толгой малд хүрэхээргүй хэмжээний малтай байна (НҮБ, АХБ, 2018).

Монгол малчдын хувьд жил ирэх тусам залуу малчдын тоо буурч байна. Тиймээс, нас ахиж буй Монгол малчдын хувьд үр өгөөж бүхий өндөр насны тэтгэвэр, хүртээмжтэй эрүүл мэндийн даатгалын тогтолцоо амин чухал асуудал болж байна. Монгол малчдын тэтгэвэр төлөвлөлтийн талаарх сүүлийн үеийн баримтуудад онцлон тэмдэглэснээр малчид нь хөдөлмөр эрхэлж буй хүн амын дөрөвний нэгийг эзэлдэг боловч дөнгөж дөрвөн малчин тутмын нэг нь л нийгмийн даатгалд хамрагдаж байна (Ганчимэг нар, 2019).

Монгол Улсад газарзүй болон байгаль цаг уурын онцлогоос шалтгаалж малчдад нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй, үр өгөөжтэй хүргэхэд амаргүй байдаг. Мөн түүнчлэн нүүдэлчин ба хагас нүүдэлчин байдалтай амьдралын хэв маяг нь төрөөс нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд бэрхшээлүүд учруулдаг (НҮБ, АХБ, 2018). Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд нь голчлон эдийн засгийн стандарт таамаглал дээр үндэслэдэг. Гэвч эдгээр таамаглалуудыг зан үйлийн ба эдийн засгийн дэд салбарууд буюу хувь хүмүүс үргэлж рациональ шийдвэр гаргадаггүй гэдгийг нотолдог онолууд үргэлж сорьж байдаг. Энэхүү судалгаагаар даатгалд хамрагдаж, өндөр насны тэтгэвэр авах хүсэлт гаргана гэж таамаглахуйц малчид олон шалтгааны улмаас даатгалд хамрагддаггүй болохыг илрүүлээ.

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд хандах зан үйлийг илүү сайн ойлгох үүднээс малчдыг үндэсний хэмжээнд төлөөлөхүйц түүврээс асуулга авах ажлыг судалгааны дизайнд тусган орууллаа. Судалгааны зорилтот хүн ам нь малчид байсан бөгөөд уг судалгаанд Монгол улсын нийт 21 аймгаас 8 аймгийг төлөөлөл болгон сонгож бүх малчдыг төлөөлөхүйц 4000 малчныг судалгаанд хамруулсан.

Одоо хэрэгжиж буй бодлогын үр нөлөө болон шинэ бодлогын боломжийг судалж, үнэлэх зорилгоор оролцогч талуудын болон хууль эрх зүйн орчны зөрүүний шинжилгээг хийв. Ингэхдээ судалгааны баг нь нийгмийн даатгалын тогтолцоонд зохицуулалтын шинжтэй болон уялдаа холбооны шинжтэй асуудлуудад зөрүү байгаа эсэхийг тодорхойлох үүднээс холбогдох хууль эрх зүйн болон бодлогын бүхий л баримт бичгүүдийг нягтлан судалж, гол оролцогч талуудтай ярилцлага хийв.

Монгол Улсад Ковид-19 цар тахалтай холбоотой үүссэн нөхцөл байдал болон түүний эсрэг төр засгаас тавьж буй хөл хорионы улмаас зайнаас мэдээлэл цуглуулах аргыг ашиглалаа. Асуумж болон гол ганцаарчилсан ярилцлагыг оролцогчдын боломжтой байдлаас харгалзан утсаар болон цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллалаа.

Судалгааны гол олдворуудад дараах зүйлс багтаж байна.

Хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд, *Нийгмийн даатгалын тухай хууль* нь хувь хүмүүст (өөртөө ажлын байр бий болгогч хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, чөлөөт уран бүтээлчид г.м) нийгмийн даатгалд хамрагдахгүй байх боломж олгосон байна. Ялангуяа тус улсын мал аж ахуй нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуй учир малчдыг хувиараа хөдөлмөр эрхлэгч гэж ангилах бөгөөд малчид зөвхөн сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах боломжтой хэмээн заасан байдаг.

НД-ын тухай хуулиар албан журмаар даатгуулагч өөрийн хүсэлтээр сайн дурын даатгалд давхар хамрагдах эрхийг хязгаарласнаар нэмэлт даатгал хийлгэх боломж хаагдаж, даатгалын хамрагдалтад сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм. Мөн үүгээр зогсохгүй сайн дураар даатгуулагч иргэн зөвшөөрөгдсөн шимтгэлийн хэмжээний хамгийн багаар шимтгэлээ төлж, улмаар ирээдүйд бага тэтгэвэр тогтоолгож, тэтгэврийн наснаас хойш амьжиргааны баталгаажих түвшин бага байхад нөлөөлж болзошгүй байна. Монгол Улсад малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хууль эрх зүйн орчныг (1990-2000) бүрдүүлж, хэрэгжүүлсэн нь малчдыг дахин ийм хууль гарахыг хүлээн Нийгмийн даатгалын сан (НДС)-д шимтгэл төлөхөөс түдгэлзэх, хүлээлт үүсгэх сөрөг нөлөөлөл үүсгэжээ.

Институтийн түвшинд, санхүүгийн эх үүсвэр, техникийн болон боловсон хүчин хангалтгүйгээс орон нутгийн даатгалын ажилтнууд малчдад хүрч ажиллах, нийгмийн даатгалын хамрах хүрээг сурталчилж, өргөжүүлэх боломжгүй байна. Мөн малчдын хувьд шимтгэлээ шалгах, өөрсдөө бие даан төлбөрөө төлөх (мөн гишүүнчлэлийн бусад үйлчилгээг ашиглах) боломж бүхий хүртээмжтэй, хэрэглэгчдэд ээлтэй төлбөрийн болон дуудлагын төвийн үйлчилгээ дутмаг байна.

Бага орлого, газарзүйн алслагдмал байдал, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр сумын төвийг зорин ирэхэд зарцуулах цаг хугацаа гэх мэт саад бэрхшээлээс үүдэн малчид НДС-д шимтгэлээ хуулиар тогтоосон хугацаанд тогтвортой төлж чадахгүй байна. Залуу эрэгтэй малчид шимтгэл төлөхийн ач холбогдлын талаар хангалттай ойлголтоггүй бөгөөд төлөх хүсэлгүй байна. Түүнчлэн хөдөө орон нутгийн малчид тогтмол мэдээлэл авч чадахгүй тул даатгалын тогтолцооны талаар хангалттай мэдлэг, мэдээлэлгүй байна.

- Малчдын боловсролын түвшин, орлого, байршил, нас хүйсээс үл хамааран даатгалын шимтгэл төлөх зорилгоор мөнгө цуглуулах, даатгалд хамрагдахаас илүүтэй ирээдүйд үр хүүхэд, ач зээ, хань ижил минь асарч халамжилна гэсэн хүлээлттэй.
- Мөн тэд нийгмийн даатгалын санд шимтгэл төлөхөөс илүүтэй нэн тэргүүний амин чухал хэрэгцээгээ хангахыг илүүд үздэг. Учир нь тэд ирээдүйд тэтгэврийн насанд хүрч даатгалын үр шимийг хүртэнэ гэх итгэл бага.

Нийгмийн даатгалын тухай хуулиар малчид болон хувиараа бизнес эрхлэгчдийн сайн дурын даатгалд хамрагдах эрхийг хөнгөвчлөхөөр тусгасан. Гэсэн хэдий ч сайн дурын даатгал нь иргэдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хөшүүрэг болж чаддаггүй гэдэг нь аль хэдийн нотлогдсон бөгөөд энэ нь эсрэгээрээ хүмүүсийг даатгалд хамрагдахгүй байх эсвэл нийгмийн хамгааллаас гадуур байж, эрсдэлд өртүүлэхэд хүргэж болзошгүй байна. Энэ нь загварын хувьд зөвлөж буй гол өөрчлөлт нь шимтгэлийн хэмжээг хөнгөлөх, шимтгэл төлөлтийн өөр ангиллыг бий болгох гэх мэт малчдын онцлог шинжүүдийг тусгах замаар сайн дурын даатгалаас албан журмын нийгмийн даатгалд шилжих явдал юм.

Малчид буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан журмын даатгалд шилжүүлэхийн тулд нэн түрүүнд даатгуулагчдыг дэмжих бодлогын орчныг бүрдүүлэх, хэрэгжүүлэх механизмыг бий болгох гэх мэт хэд хэдэн дэд зөвлөмж бүхий цогц стратеги авч хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр зорилтод хүрэхийн тулд дараах зөвлөмжүүдийг санал болгож байна (" **Error! Reference source not found.**" хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлав).

- Зөвлөмж 1: Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх заалтыг түдгэлзүүлэх
- Зөвлөмж 2: Малчдын нийгмийн даатгалыг зохицуулах хууль эрхзүйн тогтолцоог бий болгох
- Зөвлөмж 3: Малчдын санхүүгийн чадавхад нийцсэн шимтгэлийг бий болгох
- Зөвлөмж 4: Шимтгэлийг бууруулах замаар залуучуудын гишүүнчлэлийг урамшуулах
- Зөвлөмж 5: Шимтгэл хураах, тасралтгүй төлөх нөхцөлийг бүрдүүлж, урамшуулах
- Зөвлөмж 6: Нийгмийн даатгалын боловсон хүчнийг нэмэгдүүлэх, сургах
- Зөвлөмж 7: Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг хөнгөвчлөх
- Зөвлөмж 8: Нийгмийн хамгааллын тогтолцооны талаарх мэдлэг, түүнд хандах хандлагыг сайжруулах

1. ҮНДЭСЛЭЛ

Олон зууны туршид Монголчууд нүүдлийн мал аж ахуй эрхэлж, газар зүйн байршил байгаль, цаг уурын онцлогтоо дасан зохицож, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг амьжиргааны гол эх үүсвэрээ болгож ирсэн. Тиймээс байгальд ээлтэй мал аж ахуйн уламжлалт хэлбэрийг тогтвортой хадгалж, малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд зөвхөн малчид төдийгүй Монгол Улсын төр, засгаас анхаарч ирсэн.

Уур амьсгалын эрс тэс өөрчлөлт, мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийн хязгаарлагдмал байдал нь малчдын аж амьдралыг эрсдэлд оруулж, улмаар ядууралд гүн гүнзгий хүргэх эрсдэлтэй байдаг. Иймд Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) нийгмийн хамгааллыг малчдын орлогын баталгааг хангах гол хэрэгсэл болгох байдлаар *Төрөөс малчдын талаар баримтлах бодлого (2009-2020)*-д "Малчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд 100 хувь хамруулж, төрийн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэнэ" гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

Нүүдлийн аж ахуй, мал аж ахуй, ган, зуд зэрэг мал аж ахуйн эрсдэлийн талаарх цөөн хэдэн судалгааг дотоодын эрдэмтэд хийсэн байдаг. Тодруулбал, БНМАУ-ын малчид, хоршоодын гишүүдийн 1986 он хүртэлх шилжилт хөдөлгөөн, суурьшлын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд (Д.Базаргүр, Б.Чинбат, С.Шийрэв-Адъяа, 1990) *"экологи-газарзүйн хувьд тохиромжтой отор газар"* гэсэн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байна. Үзэл баримтлалтай холбоотойгоор цаг хугацаа, орон зайн ялгааг тодорхойлсоны үндсэн дээр малчдын нүүдлийн онцлогийг уулархаг, тал хээрийн гэсэн хоёр хэсэг болгож, Хангай, Хэнтий, Алтай, Төв-Зүүн, Говь гэсэн таван бүсчлэлд хуваасан. Доктор Н.Хавх (Хавх, 2000) Бэлчээрийн тухай хууль, түүний гүн ухааны үндэслэл, бэлчээр малын харилцаанд нөлөөлөх хүчин зүйлс, монголчуудын уламжлалт арга барилыг Буддын гүн ухааны арга барил, ин-ян болон таван элементийн үүднээс тайлбарласан байдаг. И.Ганболд (Ганболд, 2013) Монголын нүүдэлчдийн хувьслыг дөрвөн үе шатанд ангилж, монгол малчдын бэлчээрийн ашиглалтын талаарх уламжлал болон шинэчлэлийг судалсан. Эдгээр бүтээлд малчдын бэлчээрийн ашиглалт, нүүдэлчин амьдралын хэв маягийг судалсан байдаг боловч малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудлыг хөндөөгүй орхигдуулсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага(НҮБ)-ын харьяа байгууллагуудын хамтарсан *'Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь'* (SP-Harders, MNG/19/01/UND) хөтөлбөр нь малчдын амьдралын болзошгүй нөхцөл байдал, тэдний нийгмийн даатгалын хэрэгцээг хангахуйц нийгмийн хамгааллын шинэлэг шийдлүүдийг боловсруулж эдгээр зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулж байна. Эдгээр шалтгаанаас улбаалаад Монгол Улсын малчин хүн амын нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөхөд чиглэсэн шийдвэрийг үндэслэлтэй тайлбарлах тоо, баримт шаардлагатай. Улмаар Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-аас малчдын зан байдал, амьдралын хэв маягийн талаарх шийдвэр гаргагчид болон оролцогч талуудын ойлголтыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү судалгааг санаачилж, захиалсан.

2021 оны 4 дүгээр сараас эхлэн IRIM судалгааны хүрээлэн, Маастрихтын их сургуультай хамтран ОУХБ-ын захиалгаар МУ-ын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд хандах малчдын зан үйлийг судлах судалгааг хэрэгжүүллээ. Энэ хүрээнд IRIM судалгааны хүрээлэн судалгааны төслийг ахалж, Маастрихын их сургууль судалгааны ажлын тэргүүлэх түншээр ажиллав.

Энэхүү тайлангийн бүтцийн дагуу удаах хэсэгт нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг онолын болон бодит байдал талаас нь тайлбарлаж, дараагаар нь судалгааны

зорилго, арга зүйг тус бүр танилцууллаа. Дөрөвдүгээр хэсэгт, тухайн улсын нөхцөл байдлын талаархи ерөнхий мэдээллийг гаргаж өгсөн. Юуны түрүүнд Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон дотоодын бусад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн малчдын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн онцлогийг тайлбарласан. Хоёрдугаарт гол оролцогч талуудын талаарх товч мэдээллийг өгүүлэхээс гадна малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалтай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг танилцууллаа. Уг хэсгийн төгсгөлийг Монгол Улсад малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахад тулгамдаж буй аливаа зааг, бэрхшээлүүдэд хийсэн дүн шинжилгээгээр баяжуулав. Тавдугаар хэсэгт, малчдын тухай буюу энэхүү төслийн хүрээнд малчдаас цуглуулсан анхан шатны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг толилуулахаас гадна малчдын нийгмийн даатгалд хандах хандлага, төсөөллийн талаарх мэдээллийг хүргэж байна. Эцэст нь буюу Зургаадугаар хэсэгт, тайлангийн дүгнэлт хэсгээс өмнө эрэлт нийлүүлэлтийн тал дээр тулгарч буй гол бэрхшээлүүдийг шийдвэрлэх зөвлөмжийг санал болгож танилцуулав.

Энэхүү тайлангийн бүтцийг дурдвал, удаах бүлэгт олон улсын баримт бичгүүдэд шинжилгээ хийж нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг онолын болон бодит байдал талаас нь тайлбарласан бол дараагийн бүлгүүдэд судалгааны зорилго болон арга зүйг танилцууллаа. Дөрөвдүгээр бүлэгт улсын нөхцөл байдлын талаархи ерөнхий мэдээллийг тайлбарлав. Ингэхдээ юуны түрүүнд Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон дотоодын бусад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн малчдын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн онцлогийг тайлбарласан. Түүний дараагаар, гол оролцогч талуудын талаарх товч мэдээллийг өгүүлэхээс гадна малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалтай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг танилцууллаа. Уг бүлгийн төгсгөлийг Монгол Улсад малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахад тулгамдаж буй аливаа зааг, бэрхшээлүүдэд хийсэн дүн шинжилгээгээр баяжуулав. Тавдугаар бүлэгт малчдын тухай буюу энэхүү төслийн хүрээнд малчдаас цуглуулсан анхан шатны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг толилуулахаас гадна малчдын нийгмийн даатгалд хандах хандлага, төсөөллийн талаарх үр дүнг танилцууллаа. Эцэст нь буюу Зургаадугаар бүлэгт тайлангийн дүгнэлт хэсгийн өмнө эрэлт, нийлүүлэлтийн талуудад тулгарч буй гол бэрхшээлүүдийг танилцуулж, шийдвэрлэх зөвлөмжийг санал болгов.

2. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ

2.1 Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахад нөлөөлөх хүчин зүйлс

2.1.1 Даатгалд (нийгмийн) хамрагдалтыг тайлбарлах онол:

Нийгмийн даатгалын шимтгэл гэж хувь хүн өөрт тохиож болох амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт нөлөөлөх эрсдэлээс сэргийлж даатгагч /эрсдэлийг шилжүүлэн авагч/-д урьдчилан өгч байгаа мөнгөн төлөөс юм. Нийгмийн даатгалын зорилго нь хэрэглээг цаг хугацааны явцад жигдрүүлж, хүн ам зүй, эдийн засгийн хямрал зэрэг гаднын эрсдэлийг бууруулахад оршино. Нийгмийн даатгалын тогтолцоо нь бага орлоготой хүмүүст нийтлэг эрх ашиг, хөрөнгийн дахин хуваарилалтын нөлөөг бий болгохуйц эрсдэлийн удирдлагад тулгуурлах бөгөөд шимтгэл төлөгчдийн төлөх олон төрлийн төлбөрөөс бүрддэг.

Ерөнхийдөө нийгмийн даатгалын тогтолцоо нь даатгуулагчийн орлогын тогтвортой байдал ба орлогыг урьдчилан таамаглах боломжтой байдлыг хангахад чиглэгддэг. Даатгалын зах зээлийг бие даасан зах зээл гэж үздэг бөгөөд даатгалд хамрагдах нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарах ба энэ нь нэн ялангуяа даатгалын агентууд бие даан шийдвэр гаргах боломжтой хувийн даатгалын зах зээлд илүү биеллээ олдог. Гэсэн хэдий ч хувь хүний шийдвэрүүд нь эдийн засгийн уналтад нөлөөлөх боломжтой байдаг. Жишээ нь эрсдэлийн бодит түвшнээс бага үнээр даатгуулах эсвэл ёс суртахууны аюул нь даатгуулагчийн эдийн засгийн тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэх боломжтой (Бодвэй нар, 2006). Иймэрхүү эрсдэлтэй тэмцэх нэг арга бол даатгалын зах зээл дэх төрийн оролцоо буюу төр даатгалын үйлчилгээ үзүүлэгч эсвэл зуучлагчийн үүргээр оролцох явдал юм. Хэдий тийм боловч Монгол Улсад нийгмийн даатгал нь бусад олон орны нэгэн адил хүн амын тодорхой бүлэгт сайн дурын үндсэн дээр үйлчилдэг тул хувь хүн өөрийн хүсэл сонирхол, гадаад хүчин зүйл, зан үйлийн өвөрмөц байдал зэргээс шалтгаалан даатгалд хамрагдах эсэхээ шийддэг. Даатгалд хамрагдах эсэхтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцыг эд баялгийн гүйцэтгэх үүрэг, хүлээгдэж буй өгөөжийн хувь, аливаа үр өгөөжийг цаг хугацаагаар хэмжих субъектив үзэл талаас нь эдийн засагчид судалсан байдаг (Браун ба Ким, 1993; Бек & Уэбб, 2003; Ли, Квон, & Чунг, 2010, Аутревилл, 2014) боловч даатгалд хамрагдах эсэх шийдвэрт нөлөөлж болох зан үйлийн зөрүүтэй байдлыг цөөн тооны судлаачид гүнзгийрүүлэн судалжээ (Брахмана нар, 2018). Эрсдэлээс зайлсхийх нь үр өгөөжийг цаг хугацаагаар хэмжих хүчин зүйлсэд нөлөөлөхөөс гадна тухайн улс орны даатгалын хэрэглээтэй эерэг хамааралтай хэмээх таамаглалыг зарим эдийн засагчид (Шлезингер, 1981; Шипиро, 1985) дэвшүүлж байжээ. Түүнчлэн, Чиаптори, Салание (2000) нарын үзэж буйгаар (онолын хувьд) эрсдэл ба даатгалын эрэлт хоорондох эерэг хамаарал нь маш хүчтэй ба зах зээлийн бүтцээс ямар нэг хамааралгүй юм. Үүнийг эрсдэлээс зайлсхийгчид нь анхнаасаа л эрсдэл хийх сонирхолгүй байдагтай холбон тайлбарлаж байгаа бөгөөд хэрвээ хүлээгдэж буй үнэ цэнэ нь ижил бол сугалаа сугалахаас илүүтэй баталгаатай сонголт хийхийг илүүд үзнэ гэсэн үг юм. Энэ нь эрсдэлээс зайлсхийгчид эрсдэлээс бүхэлд нь зайлсхийхийн тулд эрсдэлийн үнэлгээнд ямагт хамгийн багадаа хангалттай шимтгэл төлнө гэсэн үг юм. Даатгал нь эрсдэлийг шилжүүлэх арга учраас эрсдэлээс зайлсхийх нь даатгалын эрэлтэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч, бодит амьдралд даатгалын тогтолцоо нь актуарийн санал болгосон хувь хэмжээнээс илүү төлбөр шаардахаас гадна ихэнх тохиолдолд даатгалын компаниуд эрсдэлийг бүхэлд нь даатгаж чаддаггүй ба даатгал худалдан авах болон даатгалын эрсдэлээс зайлсхийх нь хоорондоо шугаман хамааралтай биш юм.

Түүнчлэн, агентууд оновчтой шийдвэр гаргадаг гэсэн таамаглалаас өөр хэд хэдэн онолууд нийгмийн даатгалд хамрагдаж түүнээс үр өгөөж хүртэх боломжтой хүмүүс яагаад даатгалд хамрагддаггүйг ойлгоход тусална. Юуны өмнө эрсдэлд хандах хандлага үргэлж тогтвортой байдаггүй нь нотлогдсон. Ихэнх тохиолдолд хувь хүмүүс алдагдал багатай үед эрсдэлийг эрэлхийлэгч хандлага гаргадаг бол өндөр үр өгөөжтэй байх үед эрсдэлээс татгалзах хандлага гаргадаг. Үүнийг бага үр ашгийн төлөө илүү их эрсдэл эрэлхийлэх буюу "peanut effect" гэж нэрлэдэг (Прелек ба Ловенштейн, 1991; Вебер ба Чапман, 2005). Тиймээс хохирол бага гэж үзвэл хувь хүмүүс эрсдэл эрэлхийлэгч шиг аашилж даатгалыг худалдан авахгүй гэсэн үг. Мөн тэд ирээдүйн үр өгөөжийн төлөө одоогийн хэрэглээгээ багасгах хүсэл бага байдаг (Талер & Шефрин, 1981). Хэдийгээр хүмүүс цаг хугацааны явцад хэрэглээгээ жигдрүүлснээр илүү өндөр хүлээгдэж буй үр өгөөж хүртэж болох ч шууд алдагдалд орохгүй байхыг илүүд үзэх уг үзэл нь тэднийг нийгмийн даатгалд хамрагдахгүй байхад хүргэдэг гэсэн үг юм. Үүнийг одоо цагийн өрөөсгөл хандлага буюу эдийн засгийн миопиа гэж нэрлэдэг. Мөн хүмүүс өөрсдийгөө хянах чадвар багатайгаас гадна тэтгэвэр төлөвлөлтийн асуудал дээр хойрго хандах хандлагатай байдаг (Талер & Бенарци, 2004). Алс холын ирээдүйтэй холбоотой шийдвэр гаргах болоход хувь хүмүүс илүү тэвчээртэй байж, урт хугацаандаа үр өгөөж өгөх сонголт хийх буюу тэтгэвэр эсвэл даатгалын тогтолцоонд хамрагдах хэрэгтэй болно. Харин шийдвэр гаргах мөч ойртох тусам тэд богино хугацаанд үр өгөөж нь гарах сонголтыг хийдэг бөгөөд энэ нь тэдний шимтгэл төлөх үйл явцыг хойшлуулна гэсэн үг юм. Түүнчлэн тэтгэвэр хуримтлуулах зан үйл нь настай эерэг холбоотой байдаг (Мадриан ба Шеа, 2001) нь ахмад настнууд тэтгэврээ хүртэхэд илүү ойр байгаа тул түүнд илүү их санаа зовдог гэдгийг байгалийн зөн совингийн таамаглалаар тайлбарлаж болно. Харин залуу хүмүүсийн тэтгэврийн төлөвлөлтөд өөрийгөө хянах асуудал, өрөөсгөл хандлага саад болж байж магадгүй юм. Үүний эсрэгээр, Энгстрем, Вестберг (2003) нар гэр бүлтэй хүмүүс болон эцэг эхчүүдийн ирээдүйг харах хандлагыг онцлон тэмдэглэсэн бөгөөд тэд одоо цагт уягдсан хандлагаасаа ангижирч, алс ирээдүйнхээ талаар илүү сайн төлөвлөх магадлалтай тул даатгалд хамрагдахыг хүсдэг.

Аль-Тамими, Бин Калли (2009) нарын үзэж байгаагаар боловсрол, орлогын түвшин нь санхүүгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлдэг ба санхүүгийн мэдлэгтэй хүмүүс хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргах чадвартай тул даатгалыг эрэлхийлэх магадлалтай байдаг. Орлого нь тэтгэврийн хувьд идэвхтэй шийдвэр гаргахад эерэг нөлөө үзүүлдэг гэж таамаглаж болохоор байна (Энгстрем, Вестберг 2003).

2.1.2 Бага болон дунд орлоготой орнуудын иргэд нийгмийн даатгалд хамрагдахад нөлөөлдөг хүчин зүйлс ба түүнийг тодорхойлогч хүчин зүйлсийн эмпирик нотолгоо:

Цөөн тооны судлаачид Монголын хөдөө орон нутгийн хүн ам, тариаланчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид мөн бага ба дунд орлоготой бусад орнуудын даатгалд хамрагдах эрэлт хэрэгцээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөх эрмэлзэлд нөлөөлж буй хүчин зүйлсэд судалгаа хийжээ. Тодорхойлогч гол хүчин зүйлсийг доор тайлбарлав. Юуны түрүүнд Ганчимэг нар (2019) Монголын малчдын санхүүгийн мэдлэг, тэтгэвэр төлөвлөлтийн зан үйлийг судалжээ. Тэдний судалгаагаар малчин өрхийн 32 хувь нь ядуу ч гэсэн малчдын дөнгөж 24 хувь нь нийгмийн даатгалын хөтөлбөрт хамрагдсан байна (2017 оны байдлаар). Судалгаанд хамрагдсан хувь хүмүүсийн нас болон өндөр насны тэтгэвэр эерэг хамааралтай болохыг тогтоожээ. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх боломжтой байсан малчид цаашид ч тэтгэврийн даатгалд хамрагдах магадлал өндөр байгааг судалгааны явцад ажиглажээ. Цаашлаад илүү их хэмжээний өр, зээлтэй малчдын тэтгэврийн шимтгэл төлөх магадлал бага байгааг судалгаа онцолж байна.

Малчдын мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор орон нутагт зохион байгуулагддаг "багийн хурал"-ын үүрэг оролцоонд судалгаа хийсэн боловч тэтгэврийн шимтгэлтэй холбоотой ямар нэгэн чухал хамаарлыг олж судлаачид онцолж чадаагүй байна. Мөн өрхийн нийт орлого, өрхийн хэмжээнд төлж буй нийт шимтгэлийн хэмжээ, хадгаламжид дүн шинжилгээ хийхэд тодорхой ач холбогдол гараагүй байна. Харин Монгол малчдын дунд боловсрол нь тэтгэвэртэй эерэг хамааралтай болох нь тогтоогджээ (Ганчимэг нар, 2019).

Даатгалд хамрагдахад боловсрол эерэг нөлөө үзүүлдэг нь олон улсын нийтлэг жишиг юм. Хятадын Хэйлунцзян мужийн тариаланчдын хувьд боловсролын түвшин арилжааны тэтгэврийн даатгалд хамрагдалттай эерэг хамааралтай (Жан ба Жан, 2018) байхаас гадна эрүүл мэндийн даатгал төлөх эрмэлзэлтэй мөнхүү эерэг хамааралтай гарчээ. Жишээлбэл, Малайз улсад тариаланчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоонд хувь нэмрээ оруулж шимтгэл төлөх чадвар болон эрмэлзлийг үнэлэх зорилготой явуулсан судалгаагаар Селангорын (Малайз) дээд боловсролтой тариаланчид татвараас санхүүждэг тогтолцооноос илүүтэй үндэсний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоонд шимтгэл төлж хувь нэмрээ оруулах эрмэлзэл өндөр байгаа нь тогтоогджээ (Айзуддин нар. 2011). Мөн Энэтхэг улсын өрхийн тэргүүний боловсролын түвшин нь тус улсын хөдөө орон нутгийн хүн амын эрүүл мэндийн бичил даатгалд шимтгэл төлөх хүсэл эрмэлзэлтэй эерэг хамааралтай (Дрор нар. 2007) байдаг бол Иран улсад боловсрол болон төрийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт хоорондоо мөн эерэг хамааралтай гарчээ (Асгари нар.2004). Эсрэгээрээ эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, албан бус ажилчдыг санал болгох даатгалын хувилбарууд, даатгалд хамрагдах журмын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг мөн санхүүгийн мэдлэг бага байх нь тэтгэвэр, эрүүл мэндийн даатгалын эрэлт бага байгаатай холбоотой юм (Ганчимэг нар, 2019, Матхауэр нар. 2008). Даатгал худалдаж авах эрмэлзэл бага байгаагийн бусад шалтгаан нь даатгалын тогтолцооны талаарх ойлголт муу эсвэл ил тод байдал хангалтгүй байгаатай холбоотой байж болно (Кастеллани ба Вигано, 2017; Хайбин нар.2020).

Түүнчлэн нийгэм, эдийн засгийн статус нь нийгмийн даатгалын тогтолцоонд хувь нэмэр оруулах эрмэлзэлтэй уялдаатай байна. Хөдөө орон нутгийн өрхүүд орлого их болох (Дрор нар. 2007, Айзуддин нар. 2011) эсвэл гэр бүлийн хүнд асуудалтай тулгарах (Жан ба Жан, 2018) үед нийгмийн даатгал төлөх эрмэлзэл төрдөг. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн даатгалд хамрагдах эрмэлзэлд дүн шинжилгээ хийхэд эд баялаг, орлого, ажил мэргэжил, өрхийн гишүүдийн тоо нь Иран улсын хувьд ач холбогдол багатай байсан тул үүнийг нийтлэг жишээ гэж хэлэх боломжгүй юм (Асгари нар.2004). Харин Кени улсад албан бус ажилчдыг эрүүл мэндийн даатгалын төлөвлөлтөд хувь нэмрээ оруулахад саад болж буй гол бэрхшээлүүдийн нэг бол төлбөрийн чадваргүй байдал юм. Олноороо суурьшин амьдрах, өөр төрлийн даатгалд бүртгүүлсэн байх, эрэгтэй байх, саяхан эрүүл мэндийн зардал гаргасан эсвэл өрхийн гишүүн олонтой байх зэргээс илүүтэй гэрлэсэн эсвэл бие даан амьдардаг тариачин байх (Жан ба Жан, 2018) зэрэг өрхийн бусад онцлог шинж чанарууд нь хүмүүсийн нийгмийн даатгалд хамрагдах шийдвэртэй эерэг хамааралтай байдаг ажээ (Дрор нар. 2007). Мөн хөдөө орон нутгийн өрхүүд албан ёсны даатгал худалдаж авахын оронд өрх хоорондын тусламжид найдаж амьжиргаагаа залгуулдаг тохиолдлууд байдаг (Бейне, 2014). Үүнийг албан бус даатгалын нэг төрөл гэж үзэх буюу анх төлсөн шимтгэл нь ирээдүйд эргэн гарах үр өгөөжийн хүлээлтийг бий болгодог гэсэн үг юм.

Зан үйлийн зөрүүтэй байдлын хувьд (Брахмана нар. 2018) эрүүл мэндийн даатгал худалдаж авах эрмэлзлийн сэтгэлзүйн хүчин зүйлсийг Индонези улсын жишээн дээр судалжээ. Төлөвлөсөн зан үйлийн онолын хүрээнд эрүүл мэндийн даатгалын эрэлт хэрэгцээ нь худалдан авалтад хандах

хандлага, субъектив хэм хэмжээ, зан үйлийн хяналтаас хамаардаг болохыг тогтоожээ. Түүгээр ч зогсохгүй эрүүл мэндийн даатгалын ашиг тусын талаар ойлголттой байна гэдэг нь санхүүгийн өндөр мэдлэгтэй холбоотой тул ийм хүмүүс даатгал худалдаж авах хүсэл эрмэлзэл илүү өндөртэй байдаг. Эцэст нь хүмүүс эрүүл мэндээ өндөр үнэлэх тусам эрүүл мэндийн даатгалд хамрагдах магадлал өндөр байдаг.

Чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хомс эсвэл эмнэлэг хүртэлх зай хол байх гэх мэт гаднын хүчин зүйлс шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж улмаар эрүүл мэндийн даатгал төлөх эрмэлзлийг бууруулдаг (Матауэр нар, 2008; Дрор нар.2007; Асгари нар. 2004). Харин газрын чанар муу байх нь Хятадын тариаланчдын арилжааны тэтгэвэрт хамрагдалтыг нэмэгдүүлдэг аж (Жан ба Жан. 2018). Иран улсын хувьд тосгоноос хамгийн ойрын хот хүртэлх зай, тосгоны хүн амын түвшин зэрэг нь өрхийн эрүүл мэндийн даатгал төлөх эрмэлзлийг бууруулдаг (Асгари нар. 2004). Энэ нь жижиг тосгонд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвүүд цөөн байдаг мөн эрүүл мэндийн нэгжүүдээс хол байх зэрэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж сайтай айл өрхүүдийг бодвол даатгалынхаа үр ашгийг хүртэж чадахгүйтэй холбоотой.

2.2 Нүүдэлчин, хөдөө орон нутгийн хүн амын нийгмийн болон эрүүл мэндийг хамгаалах олон улсын туршлага

2.2.1 Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин хүн амын нийгмийн хамгааллын арга барил

Олон улсын хамтын нийгэмлэг болон дэлхийн өнцөг булан бүрд байгаа засгийн газрууд бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой амьжиргаа, нөөцийн менежментийн стратегид оруулах хувь нэмрийг улам бүр хүлээн зөвшөөрөхийн сацуу дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д оруулж буй хувь нэмрийг нь үнэлж, өвөрмөц шинж чанар, соёл, эмзэг байдлыг нь сайшааж байна (Шеллинг, Вейбель, Бонфо нар. 2008). (Хагас) нүүдлийн мал аж ахуй нь нэн ялангуяа Сахелийн бүс нутгийн хуурай, хагас хуурай газар нутаг (жишээ нь Мавритани, Нигери, Мали, Чад), Африкийн эвэр (жишээ нь, Сомали, Кени, Этиоп) болон Ойрх Дорнод ба Төв Азийн (жишээлбэл, Иран, Афганистан, Монгол) бүс нутагт өргөн тархсан хэвээр байна. Гэсэн хэдий ч бэлчээрийн мал аж ахуй болон бүс нутгийн амьжиргааны цогц арга хэмжээ авахын оронд юун түрүүнд нэг талаас зах зээл болон тэсвэрлэх чадавхыг дэмжих¹, нөгөө талаас малын эрүүл мэнд, тэжээл, бэлчээрийн менежмент, малжуулах болон малын тоо толгойг бууруулах арга барил, улсын хэмжээний нийгмийн хамгааллын тогтолцооны загварууд нь бэлчээрийн малчдын онцлог хэрэгцээг ихэнх тохиолдолд хангаж чадахгүй байна (Гебремескел, Деста, Касса, 2019; Дэлхийн Банк, 2020).

Тиймээс Кени (H SNP), Этиоп (P SNP), Уганда (S AGE) зэрэг томоохон, өргөжиж буй тогтолцоонууд нь бэлчээрийн мал аж ахуйн бүс нутгийн амьжиргаа, хүнсний аюулгүй байдлын үр дүнг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж буй боловч эдгээр тогтолцоонууд нь нийгмийн хамгааллаас ялгаатай, малчдад тусгайлан зориулагдсан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Олон төрлийн амьжиргаа бүхий эсвэл газар тариалангийн нөхцөлд авч хэрэгжүүлэхээр боловсруулсан хөтөлбөрүүдийн үр

¹ Дэлхийн Банкнаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн Сахелийн Бэлчээрийн Дэмжлэг Үзүүлэх төсөл, эсвэл Этиопид Африкийн Хөгжлийн Банкны санхүүжүүлэн хэрэгжүүлсэн Зудыг Тэсвэрлэх ба Тогтвортой Амьжиргааны хөтөлбөр гэх мэт

дүн нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн асуудлыг ихэнхдээ орхигдуулсан байдаг (Lind & Birch, 2014). Жишээ нь, Этиоп улсын Үр Бүтээмжийн Аюулгүй Байдлын Сүлжээний Хөтөлбөр (ҮБАБСХ) нь тухайн улсын бусад хэсгүүдтэй харьцуулахад бэлчээрийн мал аж ахуй дамнасан Афар мужид бүрэн ач тусаа хүргэж чадаагүй. Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн байгаль орчны нөхцөл байдал, нүүдлийн хэв маяг, ард иргэдийн үйлдвэрлэлийн системийг тусгасан дэд бүтэц болон олон нийтийн хөдөлмөрийн бүрэлдэхүүн хэсгүүдгүй байжээ. (СПИДА нар. 2017). Мөн Сабатес-Уилер, Линд и Ходдиноттын (2011) олж тогтоосноор үр бүтээмжтэй өрхийн хөрөнгийг бий болгох (эхэн үед нэн чухал) шинэ ойлголт болоод Афар, Сомали дахь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг ядуу өрхүүдийн дунд нөөцийг харилцан хуваалцах хүрээнд ҮБАБСХ-ийг хөрсөн дээр буулгахад амаргүй байв. Хэдийгээр тивийнхээ хоёр дахь том тогтолцоо бөгөөд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг бүс нутагт нэг цонхны үйлчилгээг өгч, олон нийтэд зорьж ажиллаж, аргачлалыг хөрсөн дээр буулгах талаар зарим зөвлөгөө (олон бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид таалагдах байдлаар) өгч байсан боловч хүнсний аюулгүй байдал, хөрөнгийн хамгаалалт, хуримтлалд үзүүлэх нөлөөлөл нь уялдаагүй хэвээр байна. (МоА, 2014; Касса, 2018).

Гайхалтай нь Кени улсад хэрэгжиж буй Өлсгөлөнгийн Аюулгүй Байдлын Сүлжээ Хөтөлбөрийн (ӨАБСХ II) хувьд 2015 онд гамшгийн хариу арга хэмжээг сайжруулах зорилгоор малын даатгал, нийгмийн хамгааллыг (болзолгүй тусламж) нэгтгэж, нэгэн зэрэг хөгжүүлжээ. Улмаар 100,000 ядуу өрх тогтмол мөнгөн тэтгэмж авдаг бол эрсдэлийн сангууд нь Малын индексжүүлсэн даатгалын (IBIL) загвартай төстэй Ургамлын Нөхцөлийн Индексэд тодорхойлсон хүчин зүйлийн үндсэн дээр нэмэлтээр урьдчилан бүртгүүлсэн 40,000 эмзэг бүлгийн өрхийг хамрах тэтгэмжийн хүрээг өргөтгөснөөс гадна тэдэнд аливаа цочролоос үүдсэн тэтгэмжид хамруулсан байна (СПаН, 2018). Эмзэг байдлын босго хүртэлх зай нь өсөн нэмэгдэхийн хирээр бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг өрхүүд бүс нутгийн хэмжээнд туршигдсан Кени улсын Малын даатгалын үндэсний хөтөлбөр (КМДҮХ) болоод бусад үйлчилгээ үзүүлэгчдийн шимтгэлийн татаасыг бууруулахын давуу талыг ашиглаж байна (Жанзэн, Женсен, Муде, 2016). Дөрвөн мужийг хамарсан өргөн цар хүрээтэй, зардал ихтэй бүртгэл бүхий зорилтод суурилсан алхмууд хийгдэж байх үед КМДҮХ нь банкны данс нээх, иргэний үнэмлэх олгох (аль аль нь урьдчилсан нөхцөлийн хүрээнд), ашиг хүртэгч бүс нутгуудад иж бүрэн мэдээллийн сан бий болгох, олон нийтийн төлбөрийн системийг сайжруулах, банкны төлөөлөгчийн загварыг анхлан нэвтрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан. (Гарднер нар. 2017).

Бэлчээрийн мал аж ахуйн бүс нутгуудад (жишээ нь Сахел, Төв Ази) нийгмийн үйлчилгээ, тэр дундаа эрүүл мэнд, боловсролын салбарт амжилттай хэрэгжиж буй эсэхэд Шеллинг, Вейбель, Бонфох (2008) нар дүгнэлт хийхэд (1) төслийн хийц загварын бүх үе шатанд бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн утга учиртай оролцооны ач холбогдол, (2) хөдөлгөөнт болон хөдөлгөөнт бус үйлчилгээг хослуулсан (улирлын чанартай үйлчилгээ хүргэлт), шинэлэг нийтэд түшиглэсэн (ж нь, нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд) шийдлүүдийг нэвтрүүлэх мөн тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрэлхийлэх салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих (жишээ нь, түүхий эд үйлдвэрлэгчдийн сүлжээг ашиглах), (3) соёлын болон хүйсийн мэдрэмжтэй байдлыг хангах асуудлуудыг онцолжээ. Эцсийн дүндээ Африк тивийн олон засгийн газрууд хамгийн ядуу, эмзэг хуурай газрын бүс нутгуудад бүх нийтийн нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхээс гадна хагас нүүдэлчин бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийг даатгалын тогтолцоонд нэгтгэхтэй холбоотой тулгарч буй нэмэлт бэрхшээлээс үүдэн зөвхөн шимтгэлгүй хөтөлбөрүүдийг явуулж байна. Тиймээс уг сэдэвтэй холбоотой илүү тодорхой шилдэг туршлага, статистик өгөгдөл хомс хэвээр байна.

2.2.2 Хөдөө орон нутагт хөдөө аж ахуйн болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх нь

Үндэсний даатгалын тогтолцооны хүрээнд хөдөө орон нутгийн ажилчид хэмээх ангилалд багтдаг бэлчээрийн малчид болон газар тариалан, мал аж ахуйг хослуулан эрхлэгчид нь улирлын ижил төстэй нөхцөл байдалд ажиллаж амьдрахаас гадна тэдний хөдөлмөр эрхлэлт нь албан бус шинж чанар ихтэй байдаг тул нийгмийн даатгалд хамрагдахад ижил төстэй саад бэрхшээлтэй тулгардаг (Сато, 2021). Нийгмийн даатгалд хамрагдахгүй байх эсвэл сайн дурын хамрагдалт бага байхад нөлөөлдөг гол шалтгаанууд нь: (1) хууль эрх зүйн хүрээний хасалт, (2) орлогын хэлбэлзэлтэй холбоотой шимтгэлийн санхүүгийн дарамт, (3) санал болгож буй тэтгэвэр тэтгэмж, захиргааны үйл явц нь ирээдүйн даатгуулагчдын хэрэгцээг хангахгүй байх, (4) нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээлэлгүй байх, (5) нийгмийн даатгалын байгууллагад үл итгэх байдал (Ван Гиннекен, 1999, 2010) юм. Олон улсын туршлагаас харахад эдгээр зүйлстэй холбоотой арга хэмжээ авах нь нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд эерэг үр дүн авчирчээ.

Хуулийн хамрах хүрээг өргөтгөж, албан бус ажилчдын санхүүгийн дарамтыг бууруулах

Хууль эрх зүйн орчин болон даатгалын загварын (жишээ нь, ажлын цагт хязгаар тавих) хүрээнд энгийн, түр хугацааны эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалд авахгүй байх нь даатгалд хамрагдахгүй байх үндсэн шалтгаан хэмээн Сато (2021) тодорхойлжээ. Харин зарим улс орны хувьд хөдөө орон нутаг, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон газар тариалангаар амьжиргаагаа залгуулагч иргэдэд зориулсан тусгайлсан хуулийн заалтуудыг боловсруулжээ. Олон оронд хувиараа хөдөлмөр эрхлэгч болон сайн дурын даатгуулагчид ажил олгогч болон ажиллагчдын шимтгэлийн ачааллыг хөнгөлөхөд хувь нэмрээ оруулдаг (хоёр дахин үнэ бүхий шимтгэлийн хураамжаар) нийтлэг туршлага байдаг. Хэдийгээр энэхүү арга барил нь актуарчдын хувьд логик утга учиртай боловч дээр дурдсан тогтворгүй, бага орлоготой ажилчдын хувьд нийгмийн даатгалыг маш өндөр үнэтэй болгож хамтын санхүүжилтийн зарчмыг алдагдуулдаг (ОУСС, 2012). Тиймээс шимтгэлийн хувь хэмжээг албан бус эдийн засагт ажиллаж буй ажилчдын санхүүгийн бодит байдалд нийцүүлэн тогтоох нь зүйтэй.

Засгийн газрууд энэхүү асуудлыг шийдвэрлэхдээ шимтгэлд нь татаас олгох замаар ирээдүйн сайн дурын даатгуулагчдын хувьд боломжийн, сонирхол татахуйц байдлаар шийдсэн. Нийгмийн хамгааллын чанаргүй тогтолцоог бий болгохгүйн тулд няхуур хандаж тэтгэмжийн багцыг бага шимтгэлд нийцүүлэх эсвэл тэтгэмжид татаас олгох гэх мэт өөр бусад арга барил ашигладаг байна.

Тухайлбал Тунис, Кабо Верде, Бразил, Алжир гэх мэт улсууд тодорхой зорилтот бүлгүүдийн (хөдөө аж ахуйн ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бага орлоготой ажилчид гэх мэт) хэрэгцээ шаардлага, шимтгэл төлөх чадавхад тохирсон тэтгэмжийн багц, шимтгэл бүхий хэд хэдэн тусдаа тогтолцоог хөгжүүлсэн байдаг. (ESCWA, 2019; OECD & ОУХБ, 2019).² Эквадор улс хөдөө орон нутгийн ажилчдад өндөр татаас олгох нийгмийн хамгааллын хөтөлбөрийг явуулдаг (ОУХБ, 2013). Бие даасан, жижиг тариаланчдын (оролцогчдын >50%) хувьд биеллээ олсон, жишээ нь Тунис улсын бага орлоготой ажилчдад зориулсан нийгмийн даатгалын тогтолцоо нь өндөр насны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй болон тэжээгчээ алдсаны тэтгэмжийг хүртэхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний гуравны хоёртой тэнцэх тогтсон дүнгээр шимтгэл төлдөг (ЭСКВА. 2019).

² Бага орлоготой ажилтнууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 7.5% тэй тэнцэх хэмжээгээр төлдөг

Түүнчлэн хөндлөн татаас олгох бодлогын (бусад салбарын даатгуулагчид тэтгэмжийг татаасаар дэмжих) үр дүнд Тунисийн жижиглэнгийн загасчдын тэтгэмжийн түвшин, шимтгэл төлөх чадавхыг хамгаалах боломжтой болжээ (НҮБ-ын ХХААБ, 2019).

Иран улс 2015 оны байдлаар 1.35 сая орчим хүнд өндөр настны, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны болон ажлын байрны ослоос үүдэлтэй тахир дутуугийн тэтгэвэр болон эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ үзүүлдэг "Орон нутгийн болон нүүдэлчдийн нийгмийн даатгалын сан"-аар дамжуулан хөнгөлөлттэй, сайн дурын даатгалын үйлчилгээг нүүдэлчин малчдадаа үзүүлдэг байна. (Санхүүгийн трибун, 2015; Риизи, Махдави, 2007; Сато, 2021). Үүний нэгэн адилаар Вьетнам, Оман зэрэг улсууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөх шимтгэлд тайлагнасан орлогоос нь хамаарч тус бүр 30 ба 68 хүртэлх хувьд нь татаас олгодог (НҮБ-ын БАЭЗНК, 2019).

Дээрх орнууд татаасны хэлбэрээр даатгалд хамрагдалтыг дэмждэг бол харьцангуй өндөр хөгжилтэй, аж үйлдвэржсэн зарим мужуудад шимтгэл төвлөрсөн хэвээр байна (Санхүүгийн трибун, 2015; Риизи, Махдави, 2007; Сато, 2021). Үүний нэгэн адилаар Вьетнам, Оман улсууд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөх шимтгэлийн 30% ба 68 хүртэлх хувьд татаас олгодог бөгөөд үүнийг орлогын тайлан дээр хаалтан дотор болзолт гэж бичиж бүртгэдэг (ЭСКВА, 2019).

Өмнөд Солонгос, Тунис зэрэг цөөн улс орон нийгмийн даатгалын хамрах хүрээгээ голчлон албан журмын даатгалын тогтолцоогоор амжилттай өргөтгөж чаджээ (Берендт ба Нгуен, 2018). Өмнөд Солонгос улс 1977-1989 оны хооронд төр засгийн идэвхтэй дэмжлэг, нийгмийн яриа хэлэлцээ, зөвшилцлийн үр дүнд бүх нийтийн эрүүл мэндийн даатгалын системийг бий болгосон (Ван Гиннекен, 2008) бол Тунис улс 1990-ээд онд эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг 60-аас 84 хувьд хүргэжээ (Ван Гиннекен, 2008). Эдгээр хоёр улс хоёулаа хот, хөдөөгийн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн даатгалын хамрах хүрээг өргөтгөхөд сорил бэрхшээлтэй тулгарсан бөгөөд "давхар шимтгэл төлөх" асуудлаас зайлсхийхийн тулд ажил олгогчдын төлөх шимтгэлийн хувь хэмжээнд татаас олгох замаар интервенци хийжээ (Барса ба Алферс, 2021). Ингэхийн тулд мөн төлбөрийн шаардлагыг тодорхойлохын тулд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын чадавхийг үнэлэх системийг нэвтрүүлжээ (Ван Гиннекен, 2008).

Судалгаагаар албан журмын даатгалын тогтолцоо нь өргөн хүрээг хамрах, зохистой байдлын хувьд сайн дурын механизмаас илүү үр дүнтэй болох нь батлагджээ (ОУХБ, 2021). Сайн дурын хамрагдалт нь амжилттай үр дүнд хүрэх нь ховор байдаг бөгөөд үүнд даатгал сонгоход тулгардаг сөрөг асуудлууд нөлөөлөх хандлагатай байдаг. Харин үүний эсрэгээр хэрэв шимтгэлд татаас өгөх, шимтгэл төлөх ангиллыг ялгавартай тодорхойлох гэх мэт төлбөрийн хязгаарлагдмал боломж бүхий хүмүүст тохирох онцлог шинж чанаруудыг агуулсан албан журмын даатгалын тогтолцоо нь илүү итгэл төрүүлэхүйц үр дүнг авчирдаг (Берендт ба Нгуен, 2018; ОУХБ, 2021).

Захиргааны үйл явцыг оновчтой болгох, орлогын хэлбэлзлийг авч үзэх

Захиргааны шаардлагыг дагаж мөрдөх нь зарим ангиллын ажилчдын хувьд хэт их дарамт үүсгэх нь бий. Албан бус эдийн засагт ажиллаж буй ажилчид захиргааны үйл явцад цаг гаргахад өндөр зардал гаргах хэрэгтэй болдог. Ялангуяа малчид малаа удаан хугацаанд хараа хяналтгүй орхих боломжгүй учраас нийгмийн даатгалын хэлтсийг зорьж очих нь зардал ихтэй байдаг. Тиймээс захиргааны үйл явцад биеэрээ оролцох оролцоог аль болох багасгах нь зүйтэй. Үүний нэгэн адил дээрх хүн амаас олон тооны бичиг баримт шаардах эсвэл баримт бичгийг авахад нь хүндрэл учруулахаас зайлсхийх хэрэгтэй. Вьетнам зэрэг зарим орны туршлагаас үзэхэд зөвхөн хуулийн хүрээ, татаасыг сунгах нь даатгалыг сунгахад бараг л хангалтгүй байдаг. Захиргааны үйл явцыг хялбарчлах нь нэн чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Бүртгэл болон үйлчилгээг хүргэх механизм

Хөдөлгөөнт оффис, нэг цонхны үйлчилгээний тусламжтайгаар засаг захиргааны үйлчилгээг уугуул иргэддээ ойртуулах хөтөлбөрүүдийг анхлан хэрэгжүүлсэн улс нь Бразил юм. Мөн уян хатан ажлын цаг, ажлын өдрүүд нь хүрч ажиллахад хэцүү ангиллын хүн амд эерэг тусжээ. Уян хатан төлбөрийн нөхцөл эсвэл шимтгэл төлөх хялбаршуулсан аргыг нэвтрүүлснээр Уругвай, Перу, Аргентин, Индонез, Вьетнам зэрэг улсууд нийгмийн даатгалд хамрагдах, шимтгэл хураах үйл явцыг сайжруулж чадсан (Нгуен ба Кунха, 2019). Бразил, Аргентин, Испани, Уругвай зэрэг улсад хувиараа ажиллагчдад зориулсан хялбаршуулсан татварыг (Монотакс) нэвтрүүлсэн нь шимтгэл хураах үр дүнтэй ахиц дэвшлийг авчирсан нь гайхалтай. Түүнчлэн Бразил улс бичил бизнес эрхлэгчдэд урамшууллын багц бүхий нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөвчилсөн татварын хялбаршуулсан тогтолцоог нэвтрүүлжээ (Дуран-Валверде нар.2013). Морроко, Египет улсууд жижиг хэмжээний загасчдын загас агнуураас олох борлуулалтын (хоршоодын санд байршуулах) хураамжийн хувиар орлогоос автоматаар суутгах шимтгэлийг нэвтрүүлсэн нь төлбөртэй холбоотой бодит саад тотгор болоод ихэвчлэн өрөөсгөл гардаг сарын орлогын тооцоог арилгаж чаджээ (НҮБ-ын ХХААБ, 2019).

Турк, Уганда, Уругвай зэрэг олон оронд цахим төлбөр тооцоо нь хүрч ажиллахад хэцүү хүн амыг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах үр дүнтэй арга хэмжээ болж ирсэн (ОУХБ, 2021). Олон улсын туршлагаас харахад суурь дэд бүтэц, харилцаа холбооны систем нь шимтгэл, тэтгэмж төлөх өөр бусад аргуудыг хэрэгжүүлэх боломжийг олгосон (Уоллер, 2017). Мавритани улсын эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр олгох хөтөлбөр нь зөвхөн гар утасны сүлжээг шаарддаг. Харилцаа холбоог ашиглах нь Камбож, Индонез, Малайз, Филиппин зэрэг улсуудын нийгмийн даатгалд үр ашгаа өгсөн (ОУХБ, 2021) бол Танзани улсад стандарт гар утсаараа дамжуулан шимтгэлээ шууд төлөх системийг нэвтрүүлсэн (Уоллер, 2017). Кени улсад “Хаба Хаба” системийг нэвтрүүлснээр даатгуулагчид бүртгүүлэх, шимтгэлээ төлөх, гишүүнчлэлийн дансны статусаа утсаар шалгах боломжтой болсон. Энэхүү систем нь нийгмийн даатгалын албанд очих шаардлагагүйгээр даатгуулагчдын тоог амжилттай нэмэгдүүлж чадсан ажээ (ОУСС, 2020).

Харьцуулах орлого

Тунисийн жижиг хэмжээний загасчид аж ахуйд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэн хялбаршуулсан тогтмол хураамжийн шимтгэл ногдуулдаг бөгөөд тайлагнасан орлогынхоо хувиас хамааран багасгасан боловч уян хатан тэтгэмжийн багц авдаг (НҮБ-ын ХХААБ, 2019). Тунисийн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн шимтгэлийг тэдний мэргэжилтэй холбоотой тогтмол стандарт цалингаар тодорхойлдог байна. (ЭСКВА, 2019).

Доод ангилалд бүртгүүлэх нь тусгай үндэслэл шаарддаг. Руанда улс бага шимтгэл бүхий албан, төвлөрсөн бус олон нийтэд суурилсан эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлсэн. Энэхүү систем нь хэдхэн жилийн дотор хамрах хүрээг бараг хоёр дахин нэмэгдүүлсэн бөгөөд даатгуулагчид нь олон нийтийн нэгдсэн үйл явцын үндсэн дээр өрхийн орлогын ангилалд нийцүүлэн жилийн шимтгэл төлдөг (НҮБХХ ба ОУХБ, 2011).

Даатгалын хамрах хүрээг өргөтгөх урамшууллыг санал болгох нь

Шимтгэл төлөх, дүрэм журмыг дагаж мөрдсөнөөр бий болох урамшуулал

Санхүүгийн хувьд эмзэг бүлгийн хүн ам хэрэглээгээ жигдрүүлэх механизм багатай байдаг бөгөөд үүний үр дүнд тэд тэтгэвэр гэх мэт урт хугацааны давуу талуудаас илүүтэй ойрын хэрэгцээгээ эн тэргүүнд тавих хандлагатай байдаг. Тиймээс сайн дурын даатгалд хамрагдсаны ашиг тус нь тухайн бүлгийн хэрэгцээнд нийцэх шууд давуу талуудыг агуулсан байх ёстой, эс тэгвээс тэд хөрөнгө оруулалтын үнэ цэнийг олж харахгүй байж магадгүй (Гиннекен, 2003). Нийгмийн даатгалын багцад эрүүл мэндийн үйлчилгээ, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тусгасан нь зөвхөн урт хугацааны тэтгэмжийг багтаасан тогтолцооноос илүү даатгалд хамрагдалтыг илүү сонирхол татахуйц болгож чадна. Үүний дагуу Марокко, Тунис улсууд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоогоо "багцалсан". Хэдийгээр шимтгэлийг нэгэн зэрэг цуглуулдаг, бүртгэл нь албан боловч маш бага орлоготой хувиараа хөдөлмөр эрхлэгчид нийгмийн даатгалын зарим хэсгээс татгалзаж болно (ЭСКВА, 2019). Энэхүү элемент нь нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх үндсэн суурь юм.

Тодорхой дэд бүлгүүдийн хувьд нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдсанаар тусгай зөвшөөрөл авах эсвэл аливаа нэг үйлчилгээ авах эрх үүсэх болзол тавих нь даатгалд хамрагдах нэмэлт урамшуулал эсвэл хөндлөнгийн хяналт тавих боломжийг бий болгожээ. Нийгмийн даатгалын хөтөлбөрт хамрагдалтад тусгай зөвшөөрөл олгох эсвэл тодорхой үйлчилгээнд нэвтрэх эрхийг болзолтойгоор тавих нь нэмэлт урамшуулал болоод хөндлөнгийн хяналт тавих боломжийг бий болгоно. Марокко улсын Аж үйлдвэрийн танхим эсвэл мэргэжлийн холбоод зэрэг байгууллагууд худалдаа эрхлэхийг зөвшөөрөхөөс өмнө нийгмийн болон эрүүл мэндийн тогтолцоонд хамрагдсан байх, шимтгэл төлсөн тухай нотлох баримтыг шаардах гэх мэт нөхцөлийг тавьдаг (ЭСКВА, 2019). Уг арга нь Марокко улсад амжилттай болох нь нотлогдсон бөгөөд жижиглэнгийн загас агнуурчдын 95 хувь нь тусгай зөвшөөрөлтэй байдаг. Үүний нэгэн адил Египет, Тунисийн жижиглэнгийн загасчдын хувьд улсын нийгмийн даатгалд хамрагдах нь загас агнуурын тусгай зөвшөөрөл авахад тавигдах урьдчилсан нөхцөл юм. Энэхүү албан журмын даатгалын шаардлагын үр дүнд Египет улсын даатгалд хамрагдалт гайхалтай амжилтад хүрсэн бол харин Тунис улс ижил үр дүнд хүрч чадаагүй. Тухайн тогтолцооноос санал болгож буй ашиг тус, үйлчилгээний үнэ цэнэ нь Египет болон Тунис улсуудын жишээний хувьд үр дүнгийн зөрүүтэй байдлыг үүсгэжээ. Тунис улсын хувьд даатгалд хамрагдах гол шалтгаан нь загас агнуурын тусгай зөвшөөрөл авах хэрэгцээ шаардлага байсан бол Египет улсын хувьд жижиглэнгийн загасчид даатгалд хамрагдах нь давхар үнэ цэнтэй гэдгийг ойлгосон явдал юм (НҮБ-ын ХХААБ, 2019). Оманы хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд даатгалд хамрагдсан байх нь бусад байгууллагаас зээл, тусламж авах урьдчилсан албан нөхцөл юм (ESCWA, 2019).

Хөдөлмөрлөх эрх, зохистой хөдөлмөрийг дэмжих өртгийн сүлжээний гэрчилгээ

Шинээр ялангуяа газар тариалангийн салбарт гарч ирж буй өөр нэг хувилбар бол үйлдвэрлэгчдийг олон улсын тогтвортой байдлын гэрчилгээжүүлэлтийн тогтолцоонд (жишээ нь: Fairtrade, UTZ гэх мэт) оруулах явдал юм. Энэхүү тогтолцооны гол зорилго нь бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлж хэрэглэгчдэд тогтвортой зан үйлийг сурталчлах замаар нэмүү өртөг шингээх бөгөөд хэдийгээр эдгээр шошго нь тогтвортой байдлын зарим шинж чанарыг (нийгмийн хамгаалалд бага зэргийн анхаарал хандуулах) агуулсан байдаг боловч цалингаар ажиллагчдын сайн сайхан байдалд бодит хувь нэмэр оруулдаг эсэх талаарх мэдээллүүд зөрчилтэй байдаг (Ван дер Вал, 2018). Зарим сайн дурын даатгалын тогтолцоо хангалттай нөлөө үзүүлж чадаагүй бөгөөд засаглалын доголдол,

хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байна гэх шүүмжлэлд өртжээ. Жишээ нь "Бонсухро" гэрчилгээний шошго/3/ нь хэд хэдэн удаа Бразил улсын хөдөлмөрийн долоон үндсэн эрхийг зөрчсөн нь тогтоогджээ (Есүс, Женевьев, & Ричардсон, 2016).

2021 онд Монгол Улсад Стандарт, хэмжил зүйн газрын Текстилийн техникийн хорооноос MNS 6926:2021 – Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндэсний стандартыг баталсан. Энэхүү стандартын зорилго нь текстилийн салбарын өргөн хүрээний асуудалд⁴ стандарт нэвтрүүлэх замаар байгаль орчин, нийгмийн ёс зүй, хариуцлагыг бий болгох юм. Үүнээс гадна энэхүү үйлдвэрлэлийн стандарт нь албан ёсны гэрээ хэлэлцээр, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг хөдөлмөрлөх эрхийн тодорхой стандартуудыг агуулжээ. Гэсэн хэдий ч MNS 6926:2021 стандарт нь үйлдвэрлэгчийн түвшинд үйлчлэх тул малчдад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн стандартын хэрэгжилт, хяналтыг агуулаагүй ажээ.

Нийгмийн даатгалын тухай тодорхой заалтуудыг тусгаагүй ч Ховд аймгийн Чандмань суманд туршилтын журмаар хэрэгжиж буй "Ногоон бэлчээр төсөл - Хариуцлагатай нүүдэлчид" хэмээх хөтөлбөр нь санхүүгийн хөшүүргээр дамжуулан мал аж ахуйн гаралтай түүхий эдийн гарал үүсэл, чанарыг мөшгөх (бэлчээр болон мал аж ахуйн тогтвортой менежментийг хадгалах) системийг хөгжүүлэх зорилготой юм. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны зүгээс удирдан ажиллуулах Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн гарал үүсэл, чанарыг мөшгөх системд бүртгэгдсэнээр Ногоон бэлчээр төслийн үйл ажиллагаа болон хэрэгжилтэд хяналт тавих боломжтой. Эцэст нь QR кодоор дамжуулан эцсийн хэрэглэгчид гол үзүүлэлтүүдийн талаар мэдээлэл авах боломжтой болно.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, зохион байгуулалтыг бэхжүүлэх

Нийгмийн хамгааллын үйл ажиллагаа, ойрын болон урт хугацааны үр ашгийн талаарх харилцаа холбоо тодорхой байх, мэдлэгийг дээшлүүлэх нь сайн дурын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн даатгалд шимтгэл төлөх нь эмзэг бүлгийн өрхүүдийн санхүүгийн хувьд өндөр хөрөнгө оруулалт болдог тул шимтгэл төлөх эсэх нь нийгмийн даатгалыг үнэ цэнтэй гэж үзэх ойлголт болоод нийгмийн даатгалын байгууллагуудад итгэх итгэлээс хамаарна. Тиймээс янз бүрийн ангиллын ажилчдад тохирсон харилцаа холбооны стратеги байх ёстой. Энэ утгаараа, ирээдүйд даатгалд хамрагдах боломжтой гишүүн болон нийгмийн даатгалын байгууллага хоорондох заагийг лавшруулж болзошгүй аливаа ялгаварлан гадуурхалт бүхий ойлголтоос урьдчилан сэргийлэхийн тулд даатгалын байгууллагууд мэргэжилтнүүдээ янз бүрийн хөдөлмөр эрхлэгчидтэй харьцахад сайн сургаж, бэлтгэгдсэн байхыг хангах ёстой.

Хятад улсын хувьд нийгмийн даатгалын хамрагдалтын түвшин бага байсан нь харилцаа холбоо тодорхой бус, мэдлэг мэдээлэл хангалтгүй байсантай холбоотой (ОУХБ, 2020). Мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах кампанит ажил нь олон оронд уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн арга хэмжээ, хөдөлгөөнт театр (Тажикстан), үйлдвэрчний эвлэлийн түншлэл (Тунис), семинар (Кабо Верде) (ОУХБ, 2021) зэрэг өөр өөр арга барилаар хэрэгждэг. Камерун улс нийгмийн даатгалын тогтолцоонд сайн дураараа хамрагдах сонирхолтой хүмүүст мэдээлэл, мэдлэг

³ Нийгэм, байгаль орчны хамгийн доод стандартын дагуу элсэн чихэр, этилийн спиртийн үйлдвэрлэлийг баталгаажуулах зорилгоор бий болсон.

⁴ Байгалийн нөөц ашиглалт, эрчим хүчний хэрэглээ, химийн бодисын хэрэглээ, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохицуулалт, нийгмийн хариуцлага, хөдөлмөр хамгаалал, амьтны эрх.

түгээх зорилгоор "нийгмийн нарийн бичгийн дарга нар"-ыг магадлан итгэмжлэх тогтолцоог боловсруулсан. Нарийн бичгийн дарга нарын газрууд шинэ даатгуулагч бүрээс бага хэмжээний төлбөр авдаг (ОУСС, 2017). Кадер ЖКН хөтөлбөрийн хүрээнд Индонези улсад ижил төстэй арга барилыг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрт зорилтот бүлгүүдийн агентуудыг сонгон шалгаруулж, хандив цуглуулах, шинэ гишүүд элсүүлэх, харилцаа холбоог сайжруулах зорилгоор сургаж авдаг (Нгуен, Кунха, 2019). Уругвайд нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх боловсролыг үндэсний суурь боловсролын сургалтын хөтөлбөрт оруулсан. Хөтөлбөр нь нийгмийн хамгаалал, түүний ач холбогдлын талаарх мэдлэгийг бага наснаас нь нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллын соёлыг бий болгох зорилготой (ОУХБ, 2016). Мавретанид Тивскийн сүүний үйлдвэрээс бараа бүтээгдэхүүн, зах зээлийн сүлжээг ашиглан нүүдэлчин бэлчээрийн малчдад санхүүгийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлжээ (Шеллинг, Вейбел, Бонфо, 2008).

3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь МУ-ын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд малчдын хандах хандлагыг судлахад оршино. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны тухай ойлголт, зан үйлийг судлах;
- Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд малчдын хамрагдалтын өнөөгийн байдал даатгалын үйлчилгээ авах хэрэгцээ, тулгарч буй бэрхшээлийг судлах
- Малчдыг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдах болон эс хамрагдахад нөлөөлж буй шалтгаануудыг тодруулах;
- Малчдад /Нүүдэлчин хүн амд/ зориулсан нийгмийн даатгалын тогтолцооны загвар, тэдгээрт зориулсан даатгалын болон санхүүгийн салбарын бусад үйлчилгээ, төлбөрийн тогтолцооны олон улсын дэвшилтэд туршлага өөрийн орны загваруудыг харьцуулан судлах;
- Хууль, бодлогын зохицуулалт, үйлчилгээтэй холбоотой оролцогч талуудын үйл ажиллагаанд зөрүүний шинжилгээ гүйцэтгэх;
- Үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц боломжит чадавх, нөөцийг тодорхойлох
- НД, ЭМД-н үйлчилгээ, малчдын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хууль, эрх зүйн орчноос үүдсэн бэрхшээлүүдийг тодорхойлох;
- Малчдад НД, ЭМД-г хүргэж буй байгууллагууд болон технологийн тогтолцоог шинжлэх;
- Малчдад зориулсан нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сайжруулах санал зөвлөмж боловсруулах.

Бид малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд хандах хандлагыг илүү сайн ойлгох зорилгоор судалгааны загварыг санал болгосон. Өөрөөр хэлбэл үүнийгээ нийгэм, эдийн засгийн судалгааны модулиудыг ашигтай байдал-алдагдлын тэгш хэмийн нөлөөнд суурилсан туршилтын модультай хослуулсан. Учир нь тендерийн тоглоомууд (bidding games) болон салангид сонголтын туршилтууд (discrete choice experiment) нь бодлогын дизайны талаар ач холбогдолтой мэдээллийг өгдөггүй. Энэхүү загвар нь нийгэм-хүн ам зүй, зан байдал, мэдээллийн хувьсагчдаас нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байдлыг тайлбарлах хүчин зүйлсийг тодруулах зорилготой.

3.2. Судалгааны дизайн

Энэхүү судалгаанд доор үзүүлсэнчлэн хосолмол арга бүхий дизайныг ашигласан бөгөөд тоон болон чанарын гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдсэн болно. Өнөөгийн бодлогын үр нөлөөг үнэлэх, боломжит шинэ бодлогыг тодорхойлохын тулд судалгааны дизайны хүрээнд анхдагч өгөгдлийг цуглуулахын хажуугаар оролцогч талууд болон зөрүүний шинжилгээнүүдийг гүйцэтгэсэн. Үүний тулд, холбогдох хуулийн болон бодлогын баримт бичгүүдийг шинжилж, гол оролцогч талуудтай ярилцлага гүйцэтгэж тогтолцооны уялдаа холбоотой байдал, зохицуулалт дах зөрүүг тодрууллаа.

Дүрс 1. Судалгааны бүрэлдэхүүн хэсгүүд



3.2.1. Тоон судалгааны бүрэлдэхүүн хэсэг

Судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн хэрэглэгдэхүүн нь асуумж юм. Тухайлбал, нийт 84 асуулт бүхий асуумжийг ашиглан судалгааны мэдээллийг цуглуулсан. Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаарх ойлголт, зан үйлийг илүү сайн ойлгох зорилгоор түүвэр судалгааг ашиглан малчдаас анхдагч өгөгдөл цуглуулсан. Ашиг-алдагдлын харьцааны нөлөөлөлд суурилан нийгэм, эдийн засгийн асуултуудыг туршилтын асуултуудтай хослуулах замаар малчдын өөр өөр бүлгүүдийн дундах даатгалд хамрагдахгүй байгаа учир шалтгааныг олохыг зорьсон. Асуумж нь нийт 84 асуултаас бүрдсэн. Судалгааны мэдээллийг CATI судалгааны программ хангамжийг ашиглан цуглуулсан. IRIM нь судалгааны мэдээллийг компьютерын тусламжтай утсан судалгаа (CATI)-ны арга ашиглаж цуглуулдаг дуудлагын төвтэй. IRIM нь судалгаанд оролцогчдыг сонгохын өмнө зорилтот бүлэгт нийцэж байгаа эсэхийг нягталж, хамруулсан.

3.2.2. Чанарын судалгааны бүрэлдэхүүн хэсэг

Гол оролцогч талтай хийсэн ганцаарчилсан ярилцлага

Малчдын зан төлөв, нийгмийн даатгалд хэрхэн нөлөөлж буйг судлах зорилгоор ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан. Энэхүү ярилцлагын зорилго нь малчид нийгмийн даатгалын шимтгэлээ төлөхгүй байгаа гол шалтгааныг тодруулах явдал байв. Нийт 52 ганцаарчилсан ярилцлага хийсэн.

Сонгогдсон оролцогч талуудыг бодлого боловсруулах түвшний (макро), хэрэгжүүлэх түвшний (мезо) болон гүйцэтгэх түвшний (микро) гэсэн гурван түвшинд төлөөлөх байдлыг харгалзан

ярилцлага зохион байгуулсан. Ярилцлагуудыг гүйцэтгэхдээ уулзалт болохоос өмнө ярилцлагад оролцогчдод хагас бүтэцлэгдсэн хэлбэр ярилцлагын асуултуудыг илгээж, түүний дараагаар дунджаар 60-80 минут үргэлжилсэн ярилцлагыг гүйцэтгэсэн. Ярилцлага эхлэхээс өмнө ярилцлагад оролцогчдоос ярилцлагыг хураагуурт бичиж, судалгааны зорилгын дагуу судалгааны нууцыг хадгалах тухай урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан.

Баримт бичгийн шинжилгээ

Гол оролцогч талтай хийсэн ганцаарчилсан ярилцлагуудаас гадна бид одоо хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө, шинэ бодлогын чадавхыг хэмжихийн тулд оролцогч талууд болон зөрүүгийн шинжилгээг хийсэн.

3.3. Судалгаа болон туршилтын дизайн

Асуумжийн эхний хэсэгт (тусдаа баримт бичигт тусгагдсан) малчин өрхийн хүн ам зүйн бүтэц (хүйс, нас, гэрлэлтийн байдал, гэр бүлийн бүтэц зэрэг) болон тэдний боловсрол, орлогын ангилал, хөрөнгийн талаарх мэдээллийг цуглуулсан. Ингэснээр өөр өөр нөхцөл байдал, шинж байдал бүхий малчдын хариултуудын ялгаатай байдалд дүн шинжилгээ хийх боломжийг бий болгосон.

Хоёрдох хэсэгт судалгаанд оролцогчдын амьдралын мөчлөгийн өвөрмөц эрсдэлүүд, тэр дундаа эрүүл мэндийн асуудал ба тэдгээрийн ажил хөдөлмөр, өрхийн эдийн засгийн сайн сайхан байдалд үзүүлэх үр дагаварт анхаарлаа хандуулсан. Үүний дараагаар өрхүүдийн цочролыг даван туулах арга барилд анхаарлаа хандуулсан.

Гуравдугаар хэсэгт бид оролцогчдоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын асуултуудыг асуусан. Нэгдүгээрт, нийгмийн даатгалын талаарх мэдлэгт гол анхаарлаа хандуулсан. Ингэснээрээ малчдын нийгмийн даатгалын талаарх ерөнхий ойлголт, нийгмийн даатгалын байгууллагуудын талаарх мэдлэг, даатгал нь юу санал болгодог, түүнд хамаарах эрх, үүргийн талаарх мэдээлэл цуглуулахыг зорьсон. Хоёрдугаарт, бид нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах, хамрагдахгүй байх шалтгаануудын талаар олон сонголттой асуултуудыг ашиглан эдийн засаг, газар зүй, институц, зохион байгуулалт, нийгэм соёлын болон хувь хүнээс хамааралгүй байх шалтгаануудын талаар тодруулсан. Энэ хэсэгт холбогдох байгууллагуудын үйлчилгээний чанар, тэдэнд итгэх итгэлийн талаарх асуултуудыг багтаасан.

Туршилтын судалгаагаар бид судалгаанд оролцогчдын нийгмийн даатгалд төлөх хүслийг *туршилтын загварын дагуу* шалгасан. Atzmuller & Steiner (2010) болон Chemin (2008) нарын санал болгосноор бүх судалгаанд оролцогчдод эрсдэлийн нийтлэг таамаглалын хувилбарыг танилцуулж, дараа нь өөр өөр хувилбаруудыг санамсаргүй байдлаар танилцуулсан. Судалгаанд хамруулахдаа дөрвөн бүлэг болж ажилласан ба ингэхдээ хоёр зорилтот бүлэг, нэг идэвхтэй хяналт, нэг хяналтын бүлэг болгож хуваасан. Эхний зорилтот бүлэг (эрсдэл эрэлхийлэх зан байдлыг бий болгох) ашиг тусын талаар хангалттай мэдээлэлгүй байх нь нийгмийн даатгалд хамрагдах хүсэл, сонирхолд хэрхэн нөлөөлж болохыг судалсан. Өөрөөр хэлбэл, эхний зорилтот бүлгээс нийгмийн даатгалд хамрагдахын ашиг тусыг тайлбарлахгүйгээр нийгмийн даатгалд хамрагдах гэнэтийн хэрэгцээнүүдийг тодорхойлуулсан. Хоёрдох зорилтот бүлэг (эрсдэл эрэлхийлэх зан байдлыг бий болгох) судалгаанд оролцогчдод шимтгэлийн шаардлагуудаас бусад нийгмийн даатгал төлөхийн ашиг тусын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Гурав дахь бүлэг судалгаанд оролцогчдод мэдээллийг бүрэн өгсөн. Ингэснээр хамгийн бодитой, ил тод хувилбарын дагуу судалгаанд

оролцогчдын нийгмийн даатгалд хамрагдах шалтгаан болж буй зан хандлагыг тодруулах зорилготой. Эцэст нь нэмэлт мэдээлэл өгөөгүй пласебо бүлгийг хамруулсан.

Хүснэгт 1. Туршилт судалгааны хүрээнд ашиглагдах нөхцлүүд

Бүлэг	Төрөл	Тайлбар
Нийт бүлэг	Урьдач нөхцөл	Та дараах нөхцөл байдлыг төсөөлнө үү: Та одоо өөрийгөө 45 (эрэгтэй бол 50 нас) настай байна гэж төсөөл. Та сүүлийн (эрэгтэй бол 35 жил, Эмэгтэй бол 30 жил)-д малчин байсан уу. Та банк эсвэл орон нутгийн дэлгүүрүүд дэх өр төлбөрөө бүрэн барагдуулсан боловч танд маш бага хэмжээний хадгаламж үлджээ.
Туршилтын бүлэг 1	Ашиг тусын талаар хязгаарлагдмал мэдээлэл өгнө. Эрсдэлийг сорих зан байдлыг өдөөж өгнө.	[...] Сүүлийн багийн хурлаар Нийгмийн даатгалын байцаагч нийгмийн даатгалын схемийн талаар ярьсан. Тэрээр даатгалд хамрагдах нь хэдий сайн дурын шинжтэй боловч, малчдыг зайлшгүй хамрагдахыг зөвлөж байв. Малчид нийгмийн даатгалын шимтгэлээ хувааж төлөх мөн төлбөр төлөх аргуудаас (жишээлбэл интернэт, мобайл банкиг ашиглах) алийг нь ч ашиглах боломжтой тухай мэдээлсэн. Мөн түүнчлэн сард төлөх шимтгэлийн доод хэмжээ 60,900 төгрөг байхыг тайлбарласан.
Туршилтын бүлэг 2	Шимтгэлийн талаар хязгаарлагдмал мэдээлэл өгнө. Эрсдэлт өртөхгүй байх зан байдлыг өдөөж өгнө.	[...]Сүүлийн багийн хурлаар Нийгмийн даатгалын байцаагч нийгмийн даатгалын тогтолцооны тухай ярьж өгсөн. Тэрээр өнгөрсөн хугацаанд шимтгэл төлж даатгуулсан малчин хөгжлийн бэрхшээлтэй болоход тахир дутуугийн тэтгэвэр олгохын зэрэгцээ эрэгтэй 55, эмэгтэй 50 насанд хүрвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. Сард олгох тэтгэврийн хэмжээ хамгийн багадаа [210,000] төгрөг байхыг тайлбарласан.
Идэвхтэй хяналтын бүлэг	Бүтэн мэдээлэл	[...]Сүүлийн багийн хурлаар Нийгмийн даатгалын байцаагч нийгмийн даатгалын тогтолцооны тухай ярьж өгсөн. Энэхүү тогтолцоонд хамрагдсан байхад хөгжлийн бэрхшээлтэй болох эсвэл мэргэжлээс шалтгаалсан ослын эрсдэлийг хариуцахын зэрэгцээ тэтгэврийн насанд хүрмэгц өндөр насны тэтгэвэр тогтоолгоно. Тэтгэврийн насанд хүрмэгц сар тутамд олгох тэтгэврийн хэмжээ хамгийн багадаа [210,000] төгрөг байна. Даатгалд хамрагдсан малчин хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдвал тэтгэмжийн сангаас тэтгэмж олгоно. Нийгмийн даатгалын байгууллагаас малчдын НДШ-г нөхөн төлүүлж, нийгмийн даатгалд нөхөн хамруулахаар болсон. Гэхдээ одоогоос эхлэн тэтгэвэрт гарах хүртлээ сар бүр доод тал нь 60,900 төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл болгон төлөх ёстой. Шимтгэлээ хувааж төлөх боломжтой бөгөөд төлбөрийг өөрийн хүссэн арга хэлбэрээрээ төлөх боломжтой (жишээлбэл интернэт болон мобайл банкиг ашиглаж болно) юм.
Идэвхгүй хяналтын бүлэг	Мэдээлэлгүй	[МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ]

Эх сурвалж: Өөрсдийн боловсруулалт

Судалгаанд оролцогчдод эдгээр урьдач нөхцөлийг танилцуулсны дараагаар, нийгмийн даатгалд хамрагдах хүсэлтэй эсэхийг тодруулж, үгүй гэсэн хариултын шалтгааныг асуусан.

3.3.1. Түүврийн дизайн

Түүвэрт хамрагдсан хүн ам нь мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнээс орлого бүрдүүлдэг байнгын малчид юм. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны статистик мэдээгээр 2020 оны байдлаар 298,798 малчин байгаа нь МУ-ын нийт хүн амын 8.7 хувийг эзэлж байна.

Ажлын даалгаварт тусгаснаар МУ-ын дөрвөн бүсийг хамарч найман аймгаас нийт 4,000 гаруй малчдыг түүвэрлэсэн. Хүснэгт 2-т бүс тус бүрээс түүвэрлэгдсэн малчдын тоо, нийт малчдын тоонд эзлэх хувь хэмжээг харуулав.

Хүснэгт 2. Түүврийн хэмжээ

Бүс	Малчдын тоо(п)	Нийт малчдын тоонд эзлэх хувь	Аймаг/дүүрэг (п)	Түүврийн хэмжээ (п)	Зорилтот аймаг (п)
Баруун	73,659	0.25	5	1000	2
Хангай	124,350	0.42	6	1691	3
Төв	60,689	0.20	7	822	2
Зүүн	36,310	0.12	3	487	1
Улаанбаатар	3,781	0.01	9	N/A	-
Нийт	298,789	1.0		4000	8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо. (2020). http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1001_022V1

Түүвэрлэлтийн үе шатууд

Судалгааны зорилтот хүн ам буюу түүврийн хэмжээг хувь хүн, малчдаас бүрдүүлсэн ба судалгааны үндсэн нэгж нь малчин хүмүүс юм. Бид олон үе шатат түүврийн аргыг ашигласан ба дараах хүснэгтэд судалгааны түүврийн үе шат бүрийн түүврийн хүрээ болон түүврийн нэгжийг харуулав. Аймгуудыг тухайн бүс нутгийг төлөөлөх чадвараар нь сонгосон. Үүнд газарзүйн байршлын ялгаа, ижил төстэй байдлыг харгалзан үзсэн. Мөн хариултын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд бүс нутгуудаас хамгийн олон малтай аймгуудыг сонгосон. Малчдын тоог бүс нутгийн малчдын тоотой пропорциональ байдлаар сонгосон. Казахууд бол Монголын хамгийн олон хүн амтай үндэстний цөөнх юм. Тиймээс Казахуудын дийлэнх нь төвлөрсөн Баян-Өлгий аймгийг зориудаар сонгож байна. Казахуудын амьдралын хэв маяг, уламжлалт ахуй нь бусад үндэстэн ястнаас өөр байх магадлалтай. Тиймээс, Казахуудын олонх нь амьдардаг Баян-Өлгий аймгийг зорилтот байдлаар сонгон авсан.

Хүснэгт 3. Түүвэрлэлтийн үе шатууд

Түүврийн үе шат	Түүврийн нэгж	Түүврийн хүрээ	Түүврийн аргачлал	Түүврийн шалгуур үзүүлэлт	Үр дүн
Үе шат 1	Аймгууд	4-н бүс, 21 аймаг	Зорилтот түүвэр	Бүс нутгийн малчид	Баян-Өлгий, Увс аймаг (Баруун бүс) Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор аймаг, (Хангайн бүс) Төв, Өмнөговь аймаг (Төвийн бүс) Сүхбаатар аймаг (Зүүн бүс)
Үе шат 2	Малчид (судалгаанд оролцогчид)	15-54 насны малчдын жагсаалт	⁵ Шаталсан түүвэр	Нас Хүйс Боловсрол Даатгал	4,000 малчин

Эх сурвалж: Судалгааны баг өөрсдөө боловсруулсан.

⁵ 18-49 насны эмэгтэй малчид, 18-54 эрэгтэй малчид

Түүвэрлэлт ба түүврийн хуваарилалтууд

Шаталсан түүвэрт хамгийн өргөн хэрэглэгддэг түүврийн аргуудад пропорциональ болон пропорциональ бус тэгш түүвэр, оптимал буюу Нейманы түүврийн арга хамаардаг. Пропорциональ түүвэр нь практикт хэрэглэгддэг түүврийн хуваарилалт хамгийн энгийн арга бөгөөд давхаргууд нь бие биеэсээ мэдэгдэхүйц ялгаатай үед ихэвчлэн ашиглагддаг. h бүсээс n_h түүврийн хэмжээг пропорциональ хуваарилалтын дараах магадлалаар сонгоно.

$$\pi_{hk} = \frac{n_h}{N_h} = \frac{n \cdot \frac{N_h}{N}}{N_h} = \frac{n}{N}$$

Энэ тохиолдолд түүврийн жин тогтмол $w_{hk} = w = N/n$ байна. Энэхүү судалгаанд пропорциональ хуваарилалтын аргыг ашиглав.

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээллийг ҮСХ-ноос гаргасан малчдын харьцаанд үндэслэн гаргасан. Судалгааны багийнхан мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн чанарт тогтмол хяналт тавьж, үндсэн үзүүлэлтүүд нь аймаг бүрийн дараах хүснэгт үзүүлсэн статистик үзүүлэлттэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулсан.

Хүснэгт 4. Нас болон хүйсийн статистик

Насны бүлэг	Хувь	Эмэгтэй	Эрэгтэй
15-24	8.8	9.7	6.2
25-34	24.0	24.4	23.1
35-44	31.2	30.4	32.6
45-54	23.7	23.3	24.7
55-64	12.5	12.2	13.4
Нийт	100	100	100

Гэсэн хэдий ч бүс нутгийн хүн ам зүйн байдал, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, мэдээлэл цуглуулахад учирч болзошгүй эрсдэл зэргээс шалтгаалан тархалтад ± 5 хувийн хэлбэлзэлтэй байхаар төлөвлөсөн.

Түүврийн төлөөлөх чадвар

IRIM судалгааны хүрээлэнгийн баг малчин бүрийн байршил, нас, хүйсийн жагсаалтыг гаргасан. Түүнийгээ байршлаар буюу байршил, 8 аймаг (Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор, Төв, Өмнөговь, Сүхбаатар); хүйсээр буюу эмэгтэй, эрэгтэй; насаар буюу дөрвөн давхаргатай (15-24, 25-34, 35-44, 45-49, (Эмэгтэй)/(54-Эрэгтэй)) гэсэн шинж байдлуудад үндэслэж давхраа үүсгэсэн. Өөрөөр хэлбэл аймаг тус бүрд 8 бүлэг үүсэх ба малчин бүрийг яг нэг бүлэгт хамааруулж хуваарилсан.


Малчдын төлөөлөхүйц байдлыг хангасан түүврийг гаргахад аймаг (сум)-ын түвшний хүн амын бүртгэл, малчдын холбоо барих хаяг зэрэг захиргааны мэдээлэлтэй байх нь чухал байсан⁶. Тиймээс IRIM улс орон даяар судалгаа хийж байсан өөрийн туршлагад үндэслэн орон нутгийн засаг

⁶ Мал, тэжээвэр амьтад, хашаа, хороо, худгийн тооллого нь жил бүр зохион байгуулагддаг.

захиргааны нэгжүүдтэй холбогдож, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ) болон ОУХБ-аас албан бичгийг ашиглаж малчидтай холбоо барих хаягийг хүссэн.

Зорилтот газруудаас малчдын дэлгэрэнгүй мэдээллийг олж авахдаа дараах зурагт үзүүлсэн аргыг ашигласан.

Дүрс 2. Зорилтот газруудаас малчдын дэлгэрэнгүй мэдээллийг олж авахдаа ашигласан арга



3.3.2. Санамж

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор талбарт мэдээлэл цуглуулах боломжгүй байсан. Тиймээс, Үүнээс үүдэн CATI-ээр дамжуулан судалгаа явуулах шаардлага үүссэн. Судалгаанд оролцогчдын сүлжээ муу байх, батерей муу байх зэрэг практик шалтгаануудаас үүдэн хариултын хувь болон бүрэн гүйцэт байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд мессежээр урьдчилан мэдэгдэх, урамшуулал олгох зэрэг арга хэмжээг шат дараалалтай авч байсан. Мөн компьютерийн тусламжтай утсан судалгаа нь судалгаанд оролцогчид асуултуудыг бүрэн ойлгоход хүндрэлтэй байдгийг харгалзан судалгааны асуумжийг судалгаанд оролцогчийн танин мэдэхүйн ачааллыг харгалзан боловсруулсан. Гэвч судалгааны асуумж урт байгаагаас шалтгаалан зарим оролцогчид судалгааг дуусгалгүй судалгааг орхисон, зогсоосон тохиолдлууд байсан. Энэ тохиолдолд судалгаанд оролцогч судалгаа өгөх боломжтой болмогц судалгааг үргэлжлүүлсэн. Эдгээрээс шалтгаалж мэдээлэл цуглуулалт 11 дүгээр сар хүртэл үргэлжилсэн.

Хоёрдугаарт, мэдээлэл цуглуулах багийн гүйцэтгэл нь орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагаас өгөх малчидтай холбоо барих мэдээллээс бүрэн хамааралтай байсан. Гэсэн хэдий ч зарим зорилтот бүсүүдээс ирсэн жагсаалт дах малчдын тоо нь тухайн нутаг дэвсгэр дэх малчдын тооноос доогуур байсан. Тиймээс, малчдыг түүвэрлэх ажил нь орон нутгийн удирдлагуудаас ирүүлсэн малчдын жагсаалтад үндэслэсэн.

4. МОНГОЛ: МАЛЧИД БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН СИСТЕМ

Энэхүү бүлэг нь Монгол малчдын хүн ам зүй, нийгмийн болон эдийн засгийн онцлог шинж, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын өнөөгийн түвшнийг тодорхойлсон хэсгээс эхэлж байна. Үүний дараагаар, малчдын эрүүл мэнд болон нийгмийн даатгалыг зохицуулж буй өнөөгийн хууль эрх зүйн орчныг тодорхойлсон хэсэг орсон. Хуулиар заагдсан зүйлс ба түүний хэрэгжилт хоорондын зөрүү болон тэдгээртэй холбоотой асуудлуудыг тодруулах зорилгоор хуулийн шинжилгээг оролцогч талуудын ярилцлагад хийсэн шинжилгээтэй зэрэгцүүлэн шинжиллээ.

4.1. Монгол малчид

Монголчууд олон зууны турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж, газар зүйн байршил, байгаль, цаг уурын онцлогт дасан зохицож, мал аж ахуйн бүтээгдэхүүнээр амьжиргааны гол эх үүсвэрээ хийж иржээ. Иймдээ ч байгальд ээлтэй мал аж ахуйн уламжлалт хэлбэрийг тогтвортой хадгалах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх тал дээр зөвхөн малчид төдийгүй Монгол Улсын төр засгаас ч анхаарч ирсэн байна. Монголчууд эрт дээр үеэс бие биедээ мал бэлэглэж, хишиг малыг өсгөн үржүүлдэг уламжлалтай бөгөөд хот суурин газар нутаглаж, мал аж ахуй эрхэлдэггүй атлаа тодорхой тооны малтай болох нь элбэг. Түүнчлэн сүүлийн жилүүдэд аж ахуйн зориулалтаар мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн тоо нэмэгдэж байна (Үндэсний статистикийн хороо, 2019 он). Иймд иргэдийн нийгэм эдийн засгийн байдлыг судалж, төрөөс малчдын талаар баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байгаа ба үүний хүрээнд “Малтай хүн”, “малчин” гэх мэт ойлголтуудыг ялган томъёолсон. Жилийн турш мал маллаж амьжиргаагаа залгуулдаг хүнийг малчин гэдэг. Энэхүү судалгаа нь малчдын амьдралын хэв маяг, тэдэнд учирч болох эрсдэл, эдгээр эрсдэлд хэрхэн хандах хандлага зэргийг судлахад тодорхойлолтыг ашиглав.

4.1.1. Хүн ам зүйн шинж

Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ) мэдээлснээр малчдын тоо жил ирэх тусам цөөрсөөр байна. 2010-2020 онд малчдын тоо 28.9 мянгаар буюу 8.8 хувиар буурсан байна. 2020 оны байдлаар Монгол Улсад 298,789 малчин бүртгэгдсэний 58.3 хувь нь эрэгтэйчүүд байна. Монгол Улсын нийт хүн амын 19.9 хувь нь малчин өрхийн гишүүн байгаа ба нийт ажиллах хүчний 24.1 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна (ҮСХ, 2020).

Дүрс 3. Малчдын тоо, 2010-2020



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1001_022V1

Сүүлийн жилүүдэд 15-34 насны залуу малчдын эзлэх хувь буурсаар байна. 2011 онд нийт малчдын 41.5 хувийг 15-34 насны малчид эзэлж байсан бол 2020 онд 29.8 хувь болж, 11.7 пунктээр буурчээ. Мөн хугацаанд 35-59 насны малчдын эзлэх хувь 10,8 пунктээр, 60-аас дээш насны малчдынх 0.9 пунктээр өссөн байна. Энэ нь малчдын тоо сүүлийн жилүүдэд цөөрөөд зогсохгүй залуучуудын дунд малчин болох сонирхол багасаж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, мал аж ахуйн салбарт ажиллаж буй хүмүүсийн насжилт эрчимжиж байна (Үндэсний статистикийн хороо, 2020).

Дүрс 4. Малчдын насны бүтэц, 2011-2020



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2019)

Мөн малчдын хүйсийн харьцаа өөрчлөгдөж байгааг статистик мэдээ харуулж байна. 35 ба түүнээс дээш насны малчдын талаас илүү хувийг эмэгтэй малчид эзэлдэг бол залуу малчдын дунд эрэгтэй малчид зонхилж байгаа юм. Залуу малчдын хүйсийн ялгаа нэмэгдэж байгаа нь хожуу гэрлэлт, төрөлт буурах, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, малчдын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг үзүүлж болзошгүй (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2019).

Нийт малчдын 81 хувь нь гэр бүлтэй бөгөөд тэдний дийлэнх нь гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Харин малчдын 13.1 хувь нь гэрлээгүй, 4.9 хувь нь бэлэвсэн, үлдсэн хэсэг нь гэрлэлтээ цуцлуулсан эсвэл тусдаа амьдарч байна (Үндэсний статистикийн хороо, 2020). Эмэгтэй малчдын дунд сүүлийн үед хийсэн судалгаагаар эмэгтэйчүүд ихэвчлэн 18-25 насны хооронд гэрлэдэг болохыг тодорхойлсон (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2020). Бэлэвсэн малчдын тоо нас ахих тусам нэмэгдэж байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүдэд голчлон илэрч байна. Тус үзүүлэлт нь эрэгтэйчүүдийн эндэгдлийн түвшин өндөр байгааг харуулж буй юм (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2019).

Хүснэгт 5. Малчдын гэрлэлтийн байдал, 2020

Нас	Гэрлээгүй	Гэрлэсэн, бүртгэлтэй	Гэрлэсэн, бүртгэлгүй	Тусдаа амьдарч байгаа	Салсан	Бэлэвсэн	Нийт (%)
15-24	68.3	24.7	6.7	0.1	0.1	0.1	100
25-34	19.1	70.4	9.4	0.3	0.4	0.4	100
35-44	6.4	86.2	4.6	0.6	0.9	1.4	100
45-54	4.5	85.0	3.9	0.9	1.1	4.6	100
55-64	4.0	78.9	3.1	0.9	1.0	12.1	100
65+	3.2	60.5	1.5	0.5	0.4	33.9	100
Нийт	13.1	75.4	5.3	0.6	0.7	4.9	100

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2020).

4.1.2. Нийгэм, эдийн засгийн онцлог шинж

Боловсрол

1990-ээд онд чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж, нэгдлийн мал хувьчлагдсаны дараа олон хүүхэд сургуулиа орхиж, мал маллах болсон. Үүнээс болж өдгөө 30-40 гарсан малчдын дийлэнх нь бичиг үсэггүй болсон. Бичиг үсэг тайлагдаагүй малчид холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч чаддаггүй, мөн түүнчлэн тэдэнд бичиг үсэг заах багшийн хүрэлцээ хангамж бага, нийгмийн ажилтан дутмаг зэрэг шалтгааны улмаас хөдөөгийн малчдад хүрч ажиллаж чадахгүй байна.

Нийт малчдын 22.2 хувь нь бага, 39.4 хувь нь анхан, 24.1 хувь нь суурь, 6.3 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой, 4.5 хувь нь дээд боловсролтой, 3.5 хувь нь боловсролгүй байна (Үндэсний статистикийн хороо, 2020). Залуу малчдын 4.5 хувь нь боловсролгүй байгаа нь санаа зовоож байна. Ерөнхийдөө, малчдын боловсролын түвшин нийт хүн амтай харьцуулахад харьцангуй доогуур түвшинд байна (Үндэсний статистикийн хороо, 2020).

Хүснэгт 6. Малчдын боловсролын түвшин, 2020

Нас	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Бакалавр	Нийт (%)
15-24	3.5	22.2	39.4	24.1	6.3	6.3	100.0
25-34	3.6	13.3	38.9	31.6	7.9	7.9	100.0
35-44	4.1	21.2	29.6	28.8	6.6	6.6	100.0
45-54	4.0	27.1	44.5	19.8	1.6	1.6	100.0
55-64	2.2	12.3	46.1	29.2	8.1	8.1	100.0
65+	2.9	24.7	39.9	18.3	11.1	11.1	100.0
Нийт	4.5	50.5	22.6	8.9	9.1	9.1	100.0

Source: Үндэсний статистикийн хороо. (2020). *Салбарын танилцуулга: Хөдөө аж ахуй.*

Хөдөлмөр эрхлэлт

Монгол улсын нийт ажиллах хүчний 24.1 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна. (Үндэсний Статистикийн хороо, 2020). Малчдын аж байдлын судалгаанд (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018 он) дурдсанаар 15 ба түүнээс дээш насны малчин өрхийн гишүүдийн 87 хувь нь мал аж ахуйн салбарт, 11.2 хувь нь цалинтай хөдөлмөр, 1.2 хувь нь өрхийн аж ахуй эрхэлж, 0.6 хувь нь цалингүй хөдөлмөр эрхэлж байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн "Ногоон алт" төслийн судалгаагаар (Votolini et al., 2015) манай улсад нэг малчин өдөрт дунджаар 9.2 цаг, эрэгтэй хүн 11.1 цагийг мал аж ахуйн ажилд зарцуулдаг байна. Малчны ажлын долоо хоног дунджаар Хөдөлмөрийн тухай хуульд заасан долоо хоногийн 40 цагийн нормоос 24.4-37.7 цагаар илүү байна. Малчдын ажлын хамгийн ачаалал багатай хугацаа есдүгээр сараас дараа оны хоёрдугаар сар хүртэл байдаг бол хамгийн ачаалалтай үе нь гуравдугаар сараас есдүгээр сард байдаг. Урин дулааны улиралд төл бойжуулах, сүү, цагаан идээ боловсруулах, малын ноос, ашиг шимтийг авах, хадлан, тэжээл бэлтгэх зэрэг улирлын чанартай ажил хийгддэг байна. Малчин өдөрт дунджаар 20-30 төрлийн ажил гүйцэтгэдэг бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогоос хамааран хуваарилах хугацаа өөр өөр байдаг. Малчдын Аж Байдлын Судалгаагаар (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018 он, х.42) малчдын 88.8 хувь нь өдөрт 9-өөс дээш цагийг малдаа зарцуулж байна. Малчид туслах ажилтантай (улирлын болон байнгын ажилчин) байвал энэ хугацаа мэдэгдэхүйц багасдаг. Мал аж ахуйн салбарт шинээр гарч ирж буй үзэгдлийн нэг бол "туслах малчид" юм. Зарим малчин өрх, малчид өөрсдөө малаа маллах боломжгүй үедээ мал маллах сонирхол бүхий иргэдийг хөлслөн авч

ажиллуулж эхэлсэн. Эдгээр хүмүүсийг туслах малчин гэх ангилалд хамруулан авч үзэх болсон. Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар туслах малчдыг малчинд тооцож, НДШ төлөх боломжтой. Саяхан Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа туслах малчныг хөдөлмөр эрхэлж буйд тооцож, сайн дурын үндсэн дээр нийгмийн даатгалаа даатгуулах тухай заалт орсон (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2022).

Эрүүл мэнд

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын (2020) тайланд дурдсанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж сайн байна: Судалгаанд хамрагдсан малчдын 58.5% нь сумын эрүүл мэндийн төв, 23% нь аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд, 10% хувийн нь хэвшлийн эмнэлгүүдэд, 3.7% нь Улаанбаатар хотын эмнэлгүүдэд, 3.4% нь аймгийн бусад эмнэлгүүдэд үйлчлүүлсэн гэсэн бол нэгээс бага хувь нь эмнэлгийн үйлчилгээ хүртэж чадаагүй тул явуулын эмнэлгүүдэд үйлчлүүлдэг гэж хариулжээ. “Малчдын аж байдлын судалгаа”-аас харахад тэдний 52.9 хувь нь ЭМД-аар эмнэлгийн үйлчилгээ авч байсан. Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан малчдын 35.3 хувь нь нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж, 32.8 хувь нь эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөө, 29 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт, 12.8 хувь нь жирэмсний хяналтад, 12.4 хувь нь 0-1 насны хүүхдийн эмчийн хяналтад, 9.9 хувь нь архаг өвчний хяналтад хамрагдсан бөгөөд 9.4% нь эмнэлгийн яаралтай тусламж авчээ. Өвчний улмаас эмнэлэгт хандсан малчдын 21 орчим хувь нь зүрх судас, цусны эргэлтийн тогтолцооны өвчтэй, цусны даралт ихсэх, зүрхний хэм алдагдах зэрэг асуудалтай; 11.7 хувь нь үе мөчний үрэвсэлтэй, 6.7 хувь нь ходоод гэдэсний өвчтэй, 5.2 хувь нь гэмтэл, хордлоготой, 3.8 хувь нь цистит, бэлгийн замын халдварт өвчинтэй, 0.5 хувь нь хорт хавдартай, 0.7 хувь нь мэдэхгүй байна гэж хариулсан байна.

4.1.3. Малчдын эдийн засаг

Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтад нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг нь тэдний эдийн засгийн чадавх буюу өрхийн орлого, зардал юм. Малчин өрхийн нийгэм эдийн засгийн байдал, орлого, зардлын талаар олон судалгаанууд өмнө нь хийгдсэн байдаг (ХНХСИ, 2018; Эм Эм Эс Жи, 2018; Пипл ин Нийд болон Мэрси Кор, 2018).


Үндэсний статистикийн хорооноос өрхийн эдийн засгийн байдал, орлого, зардлын судалгааг малчин өрхийн хувьд тусгайлан гүйцэтгэдэггүй тул судалгааны энэ хэсэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)-ийн малчин өрхийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, хэрэглээ, өмч, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт зэргийг судалсан судалгааны хоёрдогч тоон мэдээг түлхүү ашигласан.⁷

Мал болон бусад хөрөнгө

Малчдын хамгийн чухал хөрөнгө бол мал юм. Нийт судалгаанд хамрагдсан өрхийн малын тоог хооронд харьцуулагдахуйц болгох зорилгоор нийт малын тоог бог буюу хонин толгойд (1 үхэр = 6 хонь, 1 адуу = 7 хонь, 1 тэмээ = 5 хонь, 1 ямаа = 0.9 хонь) шилжүүлсэн. Нийт малчин өрхийн 56.8% нь 500, 23.9% нь 501-999, 19.3% нь 1000-аас дээш бог буюу хонин толгойд шилжүүлсэн малтай байна.

⁷ Судалгааг бүсийн төлөөлөл болох 8 аймаг, 24 сум, нийслэлийн нийт 1050 малчин өрхөөс авсан.

Дүрс 5. Малчин өрхийн малын тоо, хонин толгойд шилжүүлсэн



Эх сурвалж: Малчдын аж байдлын судалгаа (ХНХСИ, 2018)

Малаас бусад хөрөнгийн хувьд зарим малчин өрх орон сууц, тохилог байшин, трактор, суудлын тэрэг, хөргөгч, интернэт гэх мэт хөрөнгөтэй байхад зарим малчин өрх цахилгаангүй, зориулалтын бус сууцанд амьдарч байна. Малчин өрхийн 87% нь гэрт амьдардаг. Мөн тэдний 61% нь сэргээгдэх эрчим хүч, 21% нь бага оврын цахилгаан үүсгүүр ашигладаг бол 2% огт цахилгаангүй байна. Халаалтын хувьд 98% ердийн галлагаатай зуухтай байна. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 68% нь өөрийн гэсэн өвөлжөөтэй, 41% нь хаваржааны газартай байна. Нийт малчдын 84% нь ямар нэг механикжсан тээврийн хэрэгсэлтэй (ХНХСИ, 2018).

Орлогын эх үүсвэр ба бүтэц

Малчин өрхийн хувьд орлогын гол хэсгийг мал, малын гаралтай түүхий эдээс олох орлого бүрдүүлдэг. Гэхдээ малчин өрхүүд нь зөвхөн малын орлогоос гадна хэд хэдэн төрлийн орлогын эх үүсвэртэй байна. Тухайлбал, нийт малчин өрхийн 95% нь тодорхой хэмжээний мал аж ахуйн орлоготой байдаг бол 75% нь тэтгэвэр тэтгэмж авдаг, 17% нь цалин хөлс авдаг, 10% орчим нь өрхийн аж ахуйн болон бусад орлогын эх үүсвэртэй байдаг (ХНХСИ, 2018).

Мэдээллийн эх сурвалжаас хамааран тооцоолол өөр өөр байгаа боловч, ойролцоогоор малчин өрхийн нийт орлогын 67- 88.2 хүртэлх хувийг мал аж ахуйн орлого эзэлж байна. ХНХСИ (2018)-ийн судалгааны тайланд дурдсанаар малчин өрхийн орлогын 67% нь мал аж ахуйн орлого, 17% нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 11% нь цалин хөлс, үлдсэн хэсгийг өрхийн бизнесийн болон бусад орлого бүрдүүлж байна. Харин мөн онд хийгдсэн Эм Эм Си Жи (2018)-ийн судалгааны хувьд малчин өрхийн нийт орлогын 88.2% нь мал аж ахуйн орлого, 8.1% нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 2.4% нь цалин хөлс, үлдсэн хэсгийг өрхийн бизнесийн болон бусад орлого бүрдүүлдэг гэсэн байна.

Хүснэгт 7. Малчин өрхийн орлогын бүтэц

Орлогын төрөл	Эзлэх хувь
Ноос, ноолуурын борлуулалт	45.3%
Мал, махны борлуулалт	39.0%
Малын арьс, ширний борлуулалт	2.5%
Сүү сүүн бүтээгдэхүүний борлуулалт	1.4%
Тэтгэвэр, тэтгэмж	8.1%
Цалин, хөлс	2.4%
Бусад	1.2%

Эх сурвалж: Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны тайлан (Эм Эм Си Жи, 2018)

Нийт орлогод мал аж ахуйн орлогын эзлэх хувь нь тухайн малчин өрхийн байршлаас хамааран харилцан адилгүй байдаг. Тухайлбал, сумын төвд оршин суудаг малчин өрхийн хувьд мал аж ахуйн орлого нь нийт орлогын 42%, нийслэл болон аймгийн төвд харьяалагддаг малчин өрхийн хувьд 60% гаруй байхад хөдөөд 73% байна (ХНХСИ, 2018). Малчин өрх суурьшлын бүсэд ойр байх тусам

малын ашиг шимээс бусад эх үүсвэрээс олох орлогын нийт орлогод эзлэх хувь хэмжээ нэмэгддэг байна.

Мөн малчин өрхийн жилийн дундаж орлого болох 11,508 мянган төгрөгийг сард шилжүүлж тооцоход 2017 оны байдлаар сарын дундаж орлого 959.0 мянган төгрөг байх тооцоо гарчээ. Сарын дундаж орлого нь мөн байршлаас шалтгаалан янз бүр байна.

Хүснэгт 8. Малчин өрхийн сарын дундаж орлого, байршил, мянган төгрөг, 2017 он

Байршил	Цалин хөлс	Тэтгэвэр тэтгэмж	Мал аж ахуйн орлого	Өрхийн бизнес	Бусад	Дундаж орлого
Улаанбаатар	560.4	335.0	825.1	325.0	300.0	1197.7
Аймгийн төв	980.6	286.8	791.7	1587.1	148.5	1210.7
Сумын төв	733.5	250.8	429.0	373.6	230.8	924.8
Хөдөө	447.7	189.0	666.0	781.7	167.3	874.6
Нийт	616.4	219.8	673.8	874.7	182.2	959.0

Эх сурвалж: Малчдын аж байдлын судалгаа (ХНХСИ, 2018)-ийн тоон мэдээнд үндэслэн судлаачдын тооцсон тооцоолол. Хүснэгт дэх орлогын төрлүүдийн хувьд, судалгаанд хамрагдсан малчин өрх нь тухайн төрлийн орлогыг олдог тохиолдолд уг орлогын дунджаар тооцсон дүн болно. Тухайлбал, цалин хөлс авдаг малчин өрхийн цалин хөлсний орлого сард дунджаар 616.5 мянган төгрөг, тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрхийн тэтгэвэр тэтгэмжийн сарын дундаж орлого 219.8 мянган төгрөг гэх мэт. Харин хүснэгтийн сүүлийн баганаан дахь дундаж орлого гэсэн үзүүлэлт нь өрхүүдийн сарын дундаж орлогыг илэрхийлж байна.

2017 оны байдлаар судалгаанд хамрагдсан нийт малчдын 68.2% нь сард дунджаар 900,000 төгрөг хүртэл, 24.5% нь 900,001-2,100,000 төгрөг, 7.3% нь 2,100,001 төгрөгөөс дээш орлоготой байсан байна (ХНХСИ, 2018). Энэ нь малчин өрхийн ихэнх нь буюу 70 орчим хувь нь малчин өрхийн сарын дундаж орлого болох 959.0 мянган төгрөгөөс доош орлоготой буюу ядууралд ойрхон амьдарч буйг илтгэж байна.

Малчин өрхийн орлогын хэмжээ нь сар бүр харилцан адилгүй буюу нүүдлийн мал аж ахуй үйл ажиллагааны мөчлөг, цаг агаарын байдлаас шалтгаалан улирлын хэлбэлзэл өндөр байдаг. Тухайлбал, Эм Эм Си Жи (2017) судалгаанд дурдсанаар малчин өрхийн орлого хаврын улиралд хамгийн өндөр, өвөл хамгийн бага буюу хавар олдог орлогоос 3.3 дахин бага байдаг болохыг тодорхойлсон байна. Мөн уг тайланд дурдсанаар эмэгтэй өрхийн тэргүүнтэй малчин өрхийн жилийн дундаж орлого нь нийт малчин өрхийн дундаж орлого болох 10.5 сая төгрөгөөс 32%-аар бага буюу жилд ойролцоогоор 7.1 сая төгрөг байдаг байна.

Хүснэгт 9. Малчдын жилийн орлогын улирлын хэлбэлзэл

Улирал	Орлого	Хувь
Хавар	5,025,920	48%
Зун	1,736,569	16%
Намар	2,246,302	21%
Өвөл	1,538,678	15%
Жилийн дундаж орлого	10,547,468	100%


Эх сурвалж: Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааны тайлан (Эм Эм Си Жи, 2018)

Зардал

Малчин өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг харвал судалгаанд хамрагдсан нийт өрхийн сард шилжүүлсэн дундаж зардал нь 1,227 мянган төгрөг байна. Үүнээс мал аж ахуйтай холбоотой зардал болох малын тэжээлийн зардал хамгийн өндөр дүнтэй буюу нийт зардлын 20% орчмыг бүрдүүлж байна (ХНХСИ, 2018). Мөн малчдын зардлын хоёр дахь том бүрэлдэхүүн нь зээлийн төлбөр байна.

Үүний шалтгаан нь малчид мотоцикл, автомашин, телевиз гэх мэт хөрөнгүүдийг хэрэглээний зээлээр худалдаж авдагтай холбоотой байж болох юм.

Дүрс 6. Малчин өрхийн зардлын бүтэц



Эх сурвалж: Малчдын Аж Байдлын Судалгаа (ХНХСИ, 2018)-ны тайланд үндэслэн судлаач дахин боловсруулсан.

Дундаж зардал нь суурьшлын бүсээс хамааран өөрчлөгдөж байгаа бөгөөд нийслэлийн өрхийн дундаж зардал 1,721.7 мянган төгрөг (+40%), аймагт 1,473 мянган төгрөг (+20%), суманд 1,247 мянган төгрөг (+2%), хөдөөгийн өрх 1,117.4 мянган төгрөг (-9%) зарцуулж байна. Үүнээс үзэхэд төв суурин газраас алслагдах тусам малчин өрхүүдийн зардлын хэмжээ буурч байна (ХНХСИ, 2018). Зардлын хувьд нийт өрхийн 52.2% нь сард дунджаар 900,000 төгрөг хүртэл, 47.8% түүнээс дээш зардал гаргадаг байна.

4.1.4. Малчдад тулгарах эрсдэлүүд ба даатгал

Малчид бусад салбарын ажилчидтай л адил нийтлэг өвчин, аж ахуйн ослоос болж богино болон урт хугацаанд хөдөлмөрийн чадвар алдах, нас барах эрсдэлийг үүрдэг. Малчид нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг тул дээрх төрлийн эрсдэлүүдэд өртөх магадлал өндөр. Учир нь нүүдэлчин малчид хатуу ширүүн орчинд ажиллаж, амьдарч, эрүүл мэнд, боловсрол, санхүү зэрэг нийгмийн үндсэн үйлчилгээг шууд авах боломж хязгаарлагдмал байдаг (Ахерн, 2018).

Ялангуяа, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй экосистем, биологийн төрөл зүйлийн өөрчлөлт нь малчдад томоохон бэрхшээл учруулаад зогсохгүй тэдний амьжиргаа, мал аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлж эхэлсэн (БОАЖЯ, 2014). Ялангуяа зуд, ган, хуурайшилт, бороо, цас, шуурга, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдсэнээс мал аж ахуйд учирч буй хохирлын хэмжээ нэмэгдэж, малчид осолд өртөж, амь насаа алдах эрсдэлтэй байна. 2018-2019 онд малчдад учирсан гамшиг, сүйрэл, ослын тохиолдлыг Хүснэгт 10-д үзүүлэв (Онцгой Байдлын Газар, 2019).

Хүснэгт 10. Малд нөлөөлөх гадны нөлөөллийн давтамж, 2018-2019

Үзүүлэлт	2018	2019
Гамшиг, ослын тохиолдлууд	4,373	4,990
Гамшиг, осолд өртсөн малчдын тоо	304	262
Гамшиг, осолд өртсөн малчдын хувь	6.95	5.25
Малын хорогдол	1,906,565	26,134
Хохирлын хэмжээ, тэрбум төгрөг	467.3	35.8

Эх сурвалж: 2019 оны гамшиг, сүйрэл, ослын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл: <https://nema.gov.mn/n/94381>

2018 онд аюулт үзэгдэл, ослын улмаас 29 малчин амь насаа алдаж, үүнээс 12 малчин малын эрэлд явж байгаад сураггүй алга болсон, үерийн улмаас 15 малчин, гал түймрийн улмаас хоёр малчин эндсэн байна; харин 2019 онд долоон малчин нас барж, үүнээс 6 малчин малын эрэлд явж байгаад сураггүй алга болж, нэг малчин аягад цохиулсан байна. 2018-2019 онд нийт 566 малчин өрх 1932.7 мянган толгой мал, 503.1 тэрбум төгрөгөөр хохирсон байна. Энэ нь ихэвчлэн малчдын амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж, ядууралд хүргэдэг байна.

Эмэгтэй малчдын сайн сайхан байдлын талаарх саяхны судалгаанд (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, 2019, х.29) цаг агаарын хүнд нөхцөлд мал маллаж байхдаа гэмтэж бэртсэн тохиолдлын талаар асуусан. Судалгаанд хамрагдсан малчдын 28.9% нь ямар нэгэн байдлаар гэмтэл авсан гэж хариулсан байна. Гэмтлийн шинж чанарыг авч үзвэл 32.1% нь амьтанд хазуулсан, өшиглүүлсэн, гишгүүлсэн, 20.7% нь морь, тэмээнээс унасан, 19.0% нь наранд түлэгдсэн, 14.4% нь хуруу, хөлийн хуруу, нүүр, чихээ хөлдөөсөн, 13.4 хувь нь гар, хөл, хүзүү, толгойгоо халтирч эсвэл унан гэмтээсэн бол 0,3 хувь нь байгалийн гамшгаас шалтгаалан орон байр нь нурах үед гэмтэл авсан байна (Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2019, х.29).

Малчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжид захиргааны хүнд суртал, эрүүл мэндийн үйлчилгээний чанарын асуудлууд муугаар нөлөөлсөөр байна: Малчдын 21.4% нь эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлага муу гэж; 19.2% нь ямар нэгэн асуудалгүй ч эмнэлгийн үйлчилгээнд урт дараалалтай, 17.5% нь эмнэлэгт хэвтүүлэлгүй дахин ир гэж хэлсэн; 17.2% нь эмнэлгийн нөхцөл муу, хүртээмж муутай; 15.1% нь мал малладаг гэр бүлийн цөөн хүнтэй учир эмнэлэгт үзүүлж амждаггүй, 9.6% нь алслагдсан бүс нутагт амьдардаг тул эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадаагүйгээс эмнэлэгт үзүүлж амжаагүй гэжээ (Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2020, х.70). Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь тус хөтөлбөрт сайн дураараа даатгалд хамрагдах сонирхлыг бууруулж буй нэг хүчин зүйл гэж үзэж болно.

Малчдын халамжийн судалгаагаар (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018) судалгаанд хамрагдагчдын 3.9 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн бол үүний 32.5 хувь нь төрөлхийн, 67.5 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна. 25-аас дээш насны олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь харьцангуй өндөр байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгохын тулд эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг сайжруулахаас гадна улсын хэмжээнд чанартай, хүрэлцэхүйц эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, боловсон хүчинтэй байх шаардлага тавигдаж байна. Тухайлбал, эмэгтэйчүүд алслагдмал газар амьдардаг, дэд бүтэц муутай, цаг агаарын хүнд нөхцөлтэй, эрүүл мэнддээ анхаарал тавьж чадаагүй зэрэг шалтгаанаар гэртээ амаржих, өвчин хүндрэх асуудлууд гарсаар байна. Иймд нийгмийн болон эрүүл мэндийн даатгал нь малчдад учирч болзошгүй хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын эрсдэлээс үүдэн учирч болзошгүй хохирлыг барагдуулах чухал хэрэгсэл юм.

4.2. Малчдад зориулсан нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын харилцааны гол оролцогч талууд

Судалгааны хоёрдох гол зорилго нь малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалт бага байхад нөлөөлж буй хууль эрх зүйн орчин болон үйлчилгээний орчинд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх байв. Тиймээс оролцогч талуудын өнөөгийн бодлогын үр нөлөөг үнэлэх, шинэ бодлогын боломжуудыг судлахад чиглэж байв. Шинжилгээг гүйцэтгэхдээ өнөөгийн

хууль болон бодлогын баримт бичгүүдийг цуглуулах, оролцогч талуудын урьдчилсан жагсаалт гаргаж тэдгээрийн дунд ярилцлага гүйцэтгэх арга зүйг ашигласан. Хийгдсэн ярилцлагуудын гол зорилго нь талуудын чиг үүрэг, хариуцаж буй ажлууд болон нийгмийн даатгалын хууль, журам, үйлчилгээ хүргэлттэй холбоотой сорилт, боломжуудыг илрүүлэх байв.

Холбогдох хууль болон бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу малчдын нийгмийн даатгалын асуудалд хамааралтай талуудыг ерөнхий 4 ангилалд хувааж болохоор байна. Үүнд, оролцогч талуудын түвшнийг нь харгалзан шийдвэр гаргах түвшинд (дээд), бодлого хэрэгжүүлэх (дунд) түвшинд, бодлогын хэрэгжилтийг хангах (анхан) түвшинд ажиллаж буй талууд болон бусад холбогдох талууд гэсэн ангилалд хуваан авч үзлээ. 2021 оны байдлаар Монгол Улсын засгийн газрын бүтцэд иргэдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын асуудлыг хариуцан хэрэгжүүлэгч 2 агентлаг байдаг.

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарагдаж байна.
2. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх ажлын хүрээнд хамаарагддаг.

Дараах хүснэгтэд оролцогч талуудын шинжилгээ болон гол оролцогч талуудын болон малчдын дунд ийсэн ярилцлага дээр үндэслэн тодорхойлсон оролцогч талуудыг харууллаа.

Хүснэгт 11. Оролцогч талуудын ангилал

Түвшин		Гол талууд
Шийдвэр гаргагчид	Дээд	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам (ХНХЯ): <ul style="list-style-type: none"> • Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар Эрүүл Мэндийн Яам (ЭМЯ) Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХХҮЯ) Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар
	Дунд	Орон нутгийн Нийгмийн Даатгалын Хэлтэс
Бодлого хэрэгжүүлэгчид	Доод	Сумын нийгмийн даатгалын байцаагчид Багийн Засаг дарга нар
		Малчдын нөхөрлөл, хоршоолол Монголын Ахмадын Холбоо Орон нутгийн банкны салбарууд Малчид

Нийгмийн даатгалын харилцаанд шууд оролцогчид гэсэн ангилалд сум хорооны нийгмийн даатгалын байцаагч, ажилтнууд, ажил олгогчид, даатгуулагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөөлөл багтаж байна. Харин нийгмийн даатгалын харилцааг дэмжин оролцогчдын бүрэлдэхүүнд сум, багийн засаг дарга нар, орон нутгийн банк, санхүүгийн байгууллагын ажилтнуудыг хамааруулан авч үзсэн. Гуравдах ангилал буюу нийгмийн даатгалын харилцааг зохицуулан оролцогчдын төлөөлөлд ХНХЯ-ны холбогдох газар хэлтийн ажилтнууд, НДЕГ-ын төлөөлөл, аймаг нийслэлийн нийгмийн даатгалын нийгмийн даатгалын газар хэлтсийн төлөөллүүдийг авч үзлээ.

Нийгмийн даатгалын харилцааг зохицуулах оролцогч талуудын талаар

Монгол улсад нийгмийн даатгалын бодлого боловсруулагч нь УИХ, Засгийн газар, ХНХЯ түүний газар хэлтсүүд байдаг. Харин Нийгмийн даатгалын талаар гарсан хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг ХНХЯ-ны Бодлогын хэрэгжилтийн газар болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох газар хэлтсүүд хүлээдэг.

Нийгмийн даатгалын харилцаанд шууд оролцогч талуудын талаар

Орон нутагт аймаг нийслэлийн засаг дарга, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн нийгмийн даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. ҮСХ-оос гаргасан тоон мэдээллээр, 2020 оны байдлаар Монгол Улсад нийт 339 сум байна. Нийт 339 сумаас 9 сум нь нийгмийн даатгалын тасаг /2-5 сумын байцаагч/-тай бол үлдсэн 330 суманд нийгмийн даатгалын нэг байцаагчтай, нийт 352 байцаагч ажиллаж байна.

Сумын нийгмийн даатгалын тасаг, байцаагч нь

- сум орон нутагт нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- ажил олгогч, даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах;
- шимтгэлийн орлого бүрдүүлэх;
- малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийг сайн дурын даатгалд хамруулах;
- тэтгэвэр, тэтгэмж, тогтоох, олгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс малчдыг нийгмийн даатгалд хамруулах, тэдэнд нийгмийн даатгалын ач тусыг ойлгуулан таниулах ажлыг сум, багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулж байна. Энэ чиглэлээр малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулж, ноос ноолуур, мах түүхий эд авах үедээ тэдэнд мэдээлэл өгдөг мөн төрийн бус байгууллагууд, арилжааны даатгалын байгууллагуудтай олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр тогтмол хамтран ажилладаг байна.

Нийгмийн даатгалын харилцаанд дэмжин оролцогчдын талаар

Нийгмийн даатгалын харилцаанд дэмжин оролцогчдын гол төлөөлөл нь төрийн үйлчилгээг өөрийн харьяа нутаг дэвсгэрт оршин суугаа иргэддээ түргэн шуурхай хүргэх үүргийг хүлээн ажиллаж байгаа сум багийн засаг дарга нар байдаг. Сумын төвөөс алслагдсан багийн иргэдийн уулзалтыг зохион байгуулах малчдын гэр орноор орж амьдрал ахуйтай танилцах ажилд сумын засаг дарга нар нийгмийн даатгалын байцаагчдыг авч явдаг нь нийгмийн даатгалын байцаагчидтай хийсэн ярилцлагаас харагдаж байна.

Хөдөө орон нутагт малчдыг нийгмийн даатгалд хамруулахад нийгмийн даатгалын төв байгууллагаас арилжааны банкнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж малчид банкнаас зээл хүссэн тохиолдолд нийгмийн даатгалд даатгуулсан байх шалгуур тавьж ажиллаж байсан бол сүүлийн жилүүдэд энэ харилцаа тасалдсан байна. Одоогоор малчдыг нийгмийн даатгалд хамруулахад сум багийн засаг даргаас өөр дэмжин оролцогч байхгүй болсон байна.

4.3. Хуулийн гол заалтууд ба одоогийн хамрагдалтын хэмжээ

Нийгмийн даатгалын багц хуулиудыг 1994 онд Монгол улсын УИХ-аар хэлэлцэн баталж 1995 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжүүлж эхэлсэн. Шинээр хэрэгжиж эхэлсэн нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд даатгуулагчдад үүсэж болох эрсдэлийн чиглэлээс хамааруулан 5 төрөлтэй байхаар

хуульчилсан бол нийгмийн даатгалд хамрагдах хэлбэрийн хувьд албан журмын болон сайн дурын гэсэн хоёр сонголттойгоор зохицуулалт хийсэн. Хуулийн хүрээнд даатгалд хамрагдах хүний төлөх шимтгэлийг даатгуулагчийн нас, ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн чадвар, иргэншил зэргээс хамааруулан төрөөс хариуцах, даатгуулагч, ажил олгогч (аж ахуй нэгж) өөрөө төлөх, сайн дурын үндсэн дээр шимтгэл төлөх гэсэн ангиллаар заагласан байна.

Монгол улсын нийгмийн даатгал нь тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн гэсэн 5 төрөлтэй байна. Зөвхөн эрүүл мэндийн даатгалд Монгол улсын бүх хүн албан журмаар даатгуулахаар хуульчилсан. Бусад 4 төрлийн даатгалд иргэд албан журмаар болон сайн дурын үндсэн дээр хамрагдана. Иргэн аж ахуйн нэгж байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа хүмүүс албан журмаар даатгуулдаг бол хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид сайн дурын үндсэн дээр даатгуулах боломжтой.

Дүрс 7. 1994 оны Нийгмийн Даатгалын тухай хуулийн дагуу олгогдох нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжүүд



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ)

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.2 дугаар зүйлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан этгээдийн нийгмийн даатгалд заавал даатгуулах асуудлыг зохицуулсан бол 4.3 дугаар зүйлд хөдөлмөр эрхэлдэггүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийг сайн дурын үндсэн дээр даатгуулахаар тусгажээ. Малчид энэ хуулийн 4.3 дугаар зүйл заалтад хамаарах учир нийгмийн даатгалд хамрагдах эсэх нь тэдний сонголт юм. Гэсэн хэдий ч малчин нийгмийн даатгалд хамрагдахаар шийдсэн тохиолдолд даруй хуулийн заалтууд хэрэгжиж эхэлнэ. Сайн дурын даатгуулагчид (малчид) тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал зэрэг багцыг бүхэлд нь сонгох үүрэгтэй. Зөвхөн нэг эсвэл хоёр даатгалын төрлийг сонгох боломжгүй юм.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд тэтгэвэр тогтоон олгох насыг таван жилээр нааш татах /бууруулах/ тухай нэмэлт өөрчлөлт 2017 онд оруулсан 2018 оноос хэрэгжсэн. Мөн хуулиар 2018 оноос хойш нийт 20-иос доошгүй жил ажилласан, үүний 15-аас доошгүй жилийг мал аж ахуйд зарцуулсан эрэгтэй малчин 55 нас хүрээд, мөн нийт 20-иос доошгүй жил ажилласан, үүнээс 12 жил зургаан сарыг мал аж ахуйд зарцуулсан малчин эмэгтэй 50 нас хүрээд тэтгэвэрт гарна гэж заажээ.

УИХ-аас “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулийг 2017 онд баталсан. Уг хууль нь 2020 оноос мөрдөгдөж эхэлсэн ба малчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилготой байсан. Энэ нь урд нь нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаагүй малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөхөн төлөх боломж олгосон. Тэтгэврийн даатгалын шимтгэл төлөөгүй жилийн шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10%-иар тооцсон байна. Энэхүү хууль нь тэтгэвэр тогтоолгох нас дөхсөн малчдад шимтгэл төлсөн жил, авах тэтгэврийн хэмжээгээ нэмэгдүүлэх боломжийг олгожээ. Үүнтэй ижил төстэй хууль эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээнд мөн байдаг. Өөрийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өмнөх жилүүдэд төлж байгаагүй малчид (болон бусад иргэд) шимтгэлээ нөхөн төлснөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх нээгддэг.

4.3.2. Өнөөгийн хамрагдалтын байдал

2020 оны байдлаар хөдөлмөрийн насны хүн амын 97 хувь нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Энэхүү хамрагдалтын өндөр хувийг эрүүл мэндийн албан журмын даатгалтай холбон тайлбарлаж байна. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгчдийн тоо 2010-2015 оны хооронд 591 мянгаас 989 мянга болж бараг хоёр дахин нэмэгджээ. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны хүн амын 51.5%-79.5%-д хүрч хамрагдалтын түвшин нэлээд өссөн байна. Энэ хугацаанд албан журмын болон сайн дурын шимтгэл төлөгчид ч хоёул нэмэгдсэн.

Хүснэгт 12. Нийгмийн даатгалын статистик 1995-2020 (мянгаар)

	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019	2020
Ажиллах хүч	813	848	1,001	1,147	1,244	1,276	1,357	1,359	1,274	1,180
Даатгалд хамрагдсан	409	423	368	591	989	1,028	1,036	1,122	1,157	1,147
Албан журмын	395	423	339	527	800	800	837	952	825	953
Сайн дурын	14	18	29	64	189	229	199	170	162	193
Хамрах хүрээ (%)	50.3	50.0	36.8	51.5	79.5	80.6	76.3	82.6	90.8	97.1

Тайлбар: Хамрагдвал зохих хүн гэдэг нь хөдөлмөр эрхлэх боломжтой хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. (Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2021а))

Даатгалд хамрагдах хувь хэмжээ 2015-2020 оны хооронд улам нэмэгдсэн боловч сайн дурын даатгуулагчдын тоо 2016 онд оргил үедээ хүрсний дараанаас буурсан байна. Зөвхөн 2020 онд сайн дурын даатгалын шимтгэл төлөгчдийн тоо мэдэгдэхүйц нэмэгдсэнийг статистик мэдээ харуулж байгаа ч нийт даатгуулагчдын дөнгөж 17 хувийг эзэлж байна (Үндэсний статистикийн хороо, 2021а).

Хүснэгт 13. Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалп хамрагдалт, 2020

Шалгуур үзүүлэлтүүд	Нийт	Хувь
Нийт малчдын тоо	298,789	100.0%
50 нас хүртэлх эмэгтэй малчид, 55 нас хүртэлх эрэгтэй малчид	233,147	78.0%
Нийгмийн даатгалд хамрагдсан малчид	49,049	16.4%
Эрүүл даатгалд хамрагдсан малчид (хөдөлмөрийн насны)	74,984	25.1%
"Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай" хуулиас ашиг тус хүртсэн малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид	17,506	5.9%
Малчны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгосон тэтгэвэр авагчид	17,216	5.8%

Эх сурвалж: Мэдээлэл технологийн төвийн дата сан.

Үндэсний статистикийн хорооны мэдээллийн дагуу Монгол Улсын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 298,789 малчин (нийт хүн амын 8,9%) байгаагийн 233,147 нь хөдөлмөрийн насны, улмаар нийгмийн даатгалд хамрагдах боломжтой малчин байна. Эрүүл мэндийн даатгалд 74,984 (25,1%) малчин хамрагдсан бол нийгмийн даатгалд 49,049 малчин (хамрагдвал зохих малчдын 16,4%) хамрагдсан. Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тал хувь (50,5%) нь эмэгтэйчүүд байна. Баримт бичгийн шинжилгээнээс харахад малчдын нас ахих тусам хамрах хүрээ нэмэгдэж байна. 45-49 насны малчдын 24.5 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан бол 35-39 насны малчдын ердөө 15.3 хувь нь (40-44 насныхан 21.7 хувь, 50-54 насныхан 16.0 хувь) даатгуулсан байна. Малчид тэтгэврийн нас ойртох тусам эцсийн дүндээ тэтгэвэр авах сонирхол нэмэгдэж байна.

Мөн "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай" хууль хэрэгжиж эхэлснээс хойш нөхөн төлөх сонирхол нэмэгдсэн гэдгээс үүнийг харж болно. 2021 оны аравдугаар сарын байдлаар 18,600 малчин нийт 38,4 тэрбум төгрөгийг (шинэ хуулийн дагуу) тэтгэврийн даатгалын 1995-2019 шимтгэлийг нөхөн төлсөн гэж НДЕГ мэдээлжээ. Энэ хуульд нийт малчдын 44.4 хувь хамрагдсан бөгөөд үүнээс 55.6 хувь нь эмэгтэйчүүд, 95.5 хувь нь 40-өөс дээш насны (эсвэл тэтгэврийн насанд дөхөж байгаа, тэтгэвэрт гарах хүсэлтэй) иргэд байна.

4.3.3. Шимтгэл төлөлт болон санхүүжилт

2019 оны 1 сараас 2021 оны 3 сар хүртэлх хугацаанд дунджаар 3.02 сая хүн буюу ойролцоогоор Монгол улсын нийт хүн амын 93% нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Гэхдээ энэ хугацаанд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүмүүсийн 70.6%-ийнх нь шимтгэлийг төр, 23.6%-ийг ажил олгогч, 5.8%-ийг даатгуулагч өөрөө тус тус хариуцан эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн хүн амын 64.3% (117,850) нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 26.2% (48,020) нь малчид байна (Үндэсний Статистикийн хороо, 2021b). Харин эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүтцийг авч үзвэл сангийн нийт орлогын дунджаар 75.6%-ийг ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл, 20.1%-

ийг төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл, 4.4%-ийг сайн дураар даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлого бүрдүүлж байна.

ЭМД-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газраас жил бүр шинэчлэн тогтооно гэж заасан байдаг. Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, эцэг, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж буй ялтны даатгалыг төрөөс хариуцан төлдөг байна. Монгол улсын засгийн газрын 2020 оны 252 дугаар тогтоолоор төрөөс хариуцсан иргэдийн сард төлөх ЭМД-ийн шимтгэлийн хэмжээг 8400 төгрөг, тэтгэврийн насны иргэд хүүхдээ асарч байгаа эхчүүд, хугацаат цэргийн албан хаагчдын сард төлөх ЭМД-ын шимтгэлийн хэмжээг 8400 төгрөг байхаар тогтоожээ. Мөн, малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сард төлөх ЭМД-ын шимтгэлийн хэмжээг 4200 төгрөг (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувьтай тэнцүү) байхаар тогтоожээ. Гэвч, албан журмаар даатгуулагчид (хөдөлмөрийн хөлснийх нь 2%) болон тэдгээрийг ажлын байраар хангаж буй ажил олгогчид (ажилтных нь хөдөлмөрийн хөлснийх нь 2%) сардаа тус бүр хөдөлмөрийн хөлснийхөө 2 хувьтай тэнцэх хэмжээгээр ЭМД-ын шимтгэл төлдөг. Өөрөөр хэлбэл: хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад өөрөө 2%-иар, ажил олгогч нь мөн 2%-иар бүгд 4%-иар шимтгэл төлдөг. ҮСХ-оос гаргасан албан ёсны мэдээллээр 2021 онд Монгол улсын дундаж цалин 1200,0 мянган төгрөг байна. Энэ хэмжээнээс тооцоолбол албан журмаар даатгуулагчид сард дунджаар $1200,0 \times 2\% = 24,0$ мянган төгрөг төлдөг ба эдгээр иргэдийг ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид мөн төдий чинээ шимтгэлийг бас төлдөг. Өөрөөр хэлбэл 1200,0 мянган төгрөгийн цалинтай албан журмаар даатгуулагч сард $24,0 \times 2 = 48,0$ мянган төгрөг төлж байна. Хэдийгээр төрөөс шимтгэлийг хариуцан төлдөг иргэдийн ЭМД-ийн шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлсэн хэдий ч малчид төлбөл зохих хэмжээ бага хэвээр байна. Харин ажил олгогч болон ажилтнуудын сард төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэл нь бусад хүн амын бүлгээс өндөр байсаар байна.

Дараах хүснэгтэд эрүүл мэндийн даатгалын сангийн 2019-2021 оны хоорондын орлогын задаргааг харууллаа.

Хүснэгт 14. Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлого, сая төгрөгөөр, 2019-2021

Орлого	2019	2020	2021 ⁸
ЭМД-ын сангийн орлого бүгд	469,617.4	487,806.8	503744.2
ААНБ-аас төлөх шимтгэл	123,447.5	323,509.7	388,198.1
Ажиллагсдаас төлөх шимтгэл	150,369.6		
Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	54,500.8		
Төр хариуцах иргэдийн шимтгэл	83,804.1	84,016.1	83,101.9
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч			302.0
Ял эдэлж буй ялтан			552.3
Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	14,759.0	14,676.4	17,042.5
Бусад орлого /хүүгийн орлого бусад/	42,736.4	65,604.6	14,547.3

Source: Мэдээлэл технологийн төвийн дата сан, ЭМДЕГ

⁸ Урьдчилсан гүйцэтгэл

Харин зарлагын хувьд нийт зарлагын 86.8% нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал, 3.5% нь сувиллын тусламж үйлчилгээний зардал, 9.7% нь эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд зарцуулагдсан байна.

Нийгмийн даатгалын тухайд, өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтаар тэтгэврийн даатгалд 12.5%, тэтгэмжийн даатгал болон ҮОМШӨ-ний даатгалд тус бүр 1% буюу бүгд 14.5 хувиар тооцож шимтгэл төлнө. Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйл 2-т заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг тооцохдоо, Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй орлогод үндэслэх ёстой бол харин дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс ихгүй байхаар заажээ. Үүний дагуу, малчид өөрсдийн сар тутам төлөх шимтгэлийн хэмжээг өөрөө тодорхойлж төлнө. Өөрөөр хэлбэл, сард төлөх шимтгэлийн доод хэмжээ нь 60.9 мянган төгрөг (жилд 730,8 мянган төгрөг) буюу жилдээ 15-20 хоньтой тэнцэх хэмжээний мөнгөн дүн бий шимтгэлийг төлснөөр тэтгэвэрт гарсны дараа эсвэл гэнэтийн хохирол тохиолдсон үед тэтгэвэр, тэтгэмж авах нөхцөл бүрдэх юм.

2020 оны байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 1,872.2 тэрбум төгрөг байсны 63.8% нь тэтгэврийн сангийн орлого, 7.6% нь ҮОМШӨ-ний даатгалын сангийн, 5.9% нь тэтгэмжийн даатгалын сангийн, 1.4% нь ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 15. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сангийн төрлөөр, сая төгрөгөөр

Үзүүлэлт		2019	2020	2021 оны урьдчилсан байдлаар
Тэтгэврийн даатгалын сан	Орлого	1,469,476.9	1,198,381.0	1,842,185.1
	Зарлага	1,839,194.9	2,174,916.9	2,300,641.3
Тэтгэмжийн даатгалын сан	Орлого	157,542.1	111,300.4	140,479.6
	Зарлага	126,220.8	147,740.8	172,751.9
ҮОМШӨ-ний даатгалын сан	Орлого	210,956.8	142,068.0	125,623.4
	Зарлага	52,854.1	34,227.2	34,415.8
Ажилгүйдлийн даатгалын сан	Орлого	41,537.1	25,920.3	28,799.9
	Зарлага	44,000.2	94,911.0	57,754.0
Улсын төсвийн татаас		605,492.8	399,417.6	593,852.5
ЭМД-ын сан	Орлого	469,617.4	487,806.8	1,000,209.4
	Зарлага		1,100.0	1,100.0
Бүгд	Орлого	2,485,005.7	1,878,187.3	2,732,040.5
	Зарлага	2,062,270.0	2,451,795.9	2,565,563.0

Харин сангийн зарлагын хувьд 2020 онд 2,451.7 тэрбум төгрөг байсны 88.7% нь тэтгэврийн даатгалын сангийн, 6.0% нь тэтгэмжийн даатгалын сангийн, 1.4% ҮОМШӨ-ний даатгалын сангийн, 3.9% нь ажилгүйдлийн даатгалын сангийн зардал тус тус бүрдүүлж байна. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хүрээнд нийт 8348 малчин тэтгэвэр тогтоолгож, 15.8 тэрбум төгрөгийг тэтгэвэрт нь зарцуулаад байна.⁹ Мөн

⁹ Эх сурвалж-Нийгмийн даатгалын ерөнхий газар

малчны тэтгэврийн насыг наашлуулсантай холбоотойгоор, 2021 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 18,543 мян.малчин өндөр насны тэтгэвэр тогтоолгож, тэтгэвэрт нь 20.9 тэрбум.төг зарцуулсан бөгөөд малчны дундаж тэтгэврийн хэмжээ 354.0 мян.төгрөг байна.¹⁰

Хуулийн энэ зохицуулалтын дагуу мМөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр сайн дураар даатгуулсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч эх хүүхдээ 3 нас хүртэл асрах хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг нийгмийн даатгалын сангаас, 50 хувийг эх өөрөө хариуцан төлөх боломжтой болсон.¹¹

Монгол Улсын Засгийн газраас олон улсад тархаад байгаа COVID-19 цар тахлын улмаас нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдад шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх замаар санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, 2020 оны 4-9 сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох шимтгэлийн хэмжээгээр чөлөөлсөн бол 2020 оны 10-12 сард шимтгэлийг 5.0 хувиар төлөх, үлдэх 8.5 хувиас чөлөөлөх, 2021 оны 1-6 сард 8.5 хувиар төлөх, үлдэх 6.0 хувиас¹² чөлөөлж байна. Нийт дүнгээр 2021 оны 3 дугаар сарын байдлаар 169.2 мян.сайн дураар даатгуулагчид 72.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлээд байна.¹³

4.3.4. Нийгмийн даатгалын шинэчлэлийн бодлогууд

Малчдын нийгмийн даатгалын хамралт хангалтгүй байгаа нөхцөл байдлыг харгалзан төр засгаас бодлогын барим бичгүүд батлан гаргаж хэрэгжүүлээд байна. УИХ-ын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан *"Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015/2030"*-д малчдын нийгмийн хамгааллын асуудлаар тодорхой бодлого тусгагдсан байна. Тухайлбал, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарт ажиллагчдад зориулсан албан журмын тэтгэврийн даатгалын тусгай хөтөлбөр бий болгох зорилт дэвшүүлж уг зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчид зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан байгуулж, шимтгэлийн хэмжээ, хугацаа, тэтгэврийн нас болон тэтгэвэр тогтоох, олгох харилцааг тусгай хуулиар зохицуулах;
- малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50-иас багагүй хувийг төрөөс хариуцах бөгөөд төрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлийг хариуцах хугацааг хуулиар зохицуулах;
- тэтгэвэр бодох аргачлал нь энгийн, ойлгомжтой, даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанаас тэтгэврийн хэмжээ хамаарахаар байх;
- нийгмийн даатгалын байгууллага нь тусгай санд шимтгэл цуглуулах үйл ажиллагааг эрхэлж, даатгуулагчийн өөрөө төлсөн шимтгэл болон төрөөс хариуцан төлсөн шимтгэлийг тухай бүр бүртгэж, даатгуулагчид мэдээлэх;
- тусгай сангийн хуримтлагдсан хөрөнгийг өсгөн арвижуулах зорилгоор Засгийн газрын бонд, үнэт цаас, бусад эрсдэл багатай банк, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх.

¹⁰ Эх сурвалж-Нийгмийн даатгалын ерөнхий газар

¹¹ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3.3.1, 3.6.1, 3.6.2 дахь заалтууд

¹² Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 2, 2¹, 2² дугаар зүйл

¹³ Эх сурвалж-Нийгмийн даатгалын ерөнхий газар

Иймд Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) нийгмийн хамгааллыг малчдын орлогын баталгааг хангах гол хэрэгсэл болгох байдлаар *Төрөөс малчдын талаар баримтлах бодлого (2009-2020)*-д “Малчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд 100 хувь хамруулж, төрийн нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 29 өдрийн 34 дүгээр тогтоолоор “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг баталж 2020-2024 онд хэрэгжүүлэхээр болсон. Уг хөтөлбөрийн хүрээнд малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлэхээр төлөвлөсөн байна (Монгол улсын Засгийн газар, 2020).

4.4. Нийгмийн даатгалын хууль, бодлогын зохицуулалт дах зөрүү болон тулгамдсан асуудлууд

Судалгааны багийн зүгээс даатгалын тогтолцооны нэг хэсэг болох хууль эрх зүйн орчин, оролцогч талуудын хоорондын хамаарлын талаар нарийвчилсан судалгаа шинжилгээ хийж, үүсэж байгаа бэрхшээлийг тодорхойлох зорилго тавьж ажиллалаа. Энэхүү бүлэгт үзүүлэх үр дүн нь судалгааны ажлын зорилгын хүрээнд цуглуулсан тоон мэдээлэл, оролцогч талуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлага, хууль эрх зүйн баримт бичгүүдийн шинжилгээнд тулгуурласан болно.

4.4.1. Хууль болон бодлогын зохицуулалтын асуудлууд

Малчдыг нийгмийн даатгалд хамруулахад орон зайн болон цаг хугацааны хувьд нилээд бэрхшээл тулгардаг байна. Монгол улс нь цаг уурын бүслүүрийн хувьд дөрвөн улиралтай, эрс тэс ширүүн уур амьсгалтай тул малчид малын бэлчээрлэх нутаг, өвс ургамал, усны аясыг даган байнгын нүүдэллэн амьдардаг тул тухайн нөхцөл байдалд тохирсон даатгалын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай болдог. Монгол Улсад малчдыг нийгмийн даатгалд хамруулахтай холбогдож үүсэх харилцааг зохицуулсан дараах хуулиуд үйлчилж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хууль (1994)
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994)
3. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай (1994)
4. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль (1994)
5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль (1990)
6. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай хууль (2012)
7. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль (2017)

Дээрх хуулиудын зарим зүйл заалтуудын гол үзэл баримтлал түүний эерэг болон сөрөг талууд малчдыг нийгмийн даатгалд хамруулахад хэрхэн нөлөөлөл үзүүлж болохыг нягтлан судалж дараах үнэлэмж дүгнэлтүүдийг гаргалаа.

- **Нийгмийн даатгалын тухай хуульд малчдыг нийгмийн даатгалд сайн дураар хамрагдах зохицуулалт оруулсан нь нийгмийн даатгалд хамрагдалт бага байхад нөлөөлж байна.** Нийгмийн даатгалын хамрагдалт албан журмаар болон сайн дурын гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид чөлөөт уран бүтээлчид сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах боломжтой. Хүн амын бүлгийг хийж буй ажил мэргэжилд үндэслэн албан болон сайн дураар даатгуулах бүлэгт хуваарилсан нь хүн амын зарим бүлгийг даатгуулахгүй

байх боломж олгож байна. Мөн сайн дурын даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцох зохицуулалт хийсэн нь даатгуулагчид хамгийн доод хэмжээгээр шимтгэл төлөх сонирхлыг бий болгосон. Гэхдээ энэхүү зохицуулалт нь сайн дурын даатгуулагчдын ирээдүйд авах тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээнд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

- **Нийгмийн даатгал шимтгэл төлж байгаа малчдыг нийгмийн даатгалын багц дотроос өөрийн хэрэгцээнд суурилсан даатгалын төрлийг сонгох эрхийг хязгаарлаж, сайн дурын даатгалыг багцаар сонгох зохицуулалт хийсэн нь малчдын даатгалд хамрагдах сонирхолд сөргөөр нөлөөлж байна.** Нийгмийн даатгалын тухай хуулийн 4-р зүйлд заасны дагуу малчид тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалуудыг багцаар сонгоно. Сайн дурын даатгалын энэхүү багц нь малчдыг даатгалд татан оролцуулах бус хөндийрүүлэх зохицуулалт болсон. Жишээлбэл: тодорхой эрхэлсэн ажилгүй гэртээ хүүхэд асарч байгаа эхчүүд сайн дурын даатгалд хамрагдахын тулд ҮОМШӨ-ний даатгалыг заавал сонгох нь утга учиргүй. Ингэж өөрт хамааралгүй даатгалд хамрагдахын шаардах нь малчдын тэтгэврийн даатгалд хамруулахад сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 7 дугаар зүйлд ... даатгуулагч нийгмийн даатгалын нэг төрлийн сангаас тэтгэвэр буюу тэтгэмжийг давхардуулж олгохгүй бөгөөд илүү таатай нөхцөлтэй тэтгэвэр буюу тэтгэмжийн аль нэгийг сонгон авах эрхтэй гэж заасан. Монгол улсын дээд шүүхээс хуулийн дээрх заалтад тайлбар хийсэн. Тайлбарт НД-н 5 төрлийн санг нэг сан гэж ойлгон, НД-н хоёр өөр төрлийн сангаас нэгэн зэрэг тэтгэвэр эсвэл тэтгэмж авах эрх үүссэн үед давхардуулж олгохгүй байхаар тайлбарласан. Жишээлбэл, өндөр насны тэтгэвэр авагч албан журмаар даатгалд хамрагдаж ажил хийж байгаад үйлдвэрлэлийн осолд орсны дараа тахир дутуугийн тэтгэврийг ҮОМШӨ-ий даатгалын сангаас авах боломжгүй болж байна. Энэ тохиолдолд даатгуулагч 3-5 төрлийн санд шимтгэл төлөх нь утга учиргүй юм. Өөрөөр хэлбэл авахгүй тэтгэвэр тэтгэмжийн төлөө шимтгэл төлүүлж байна.
- **Нийгмийн даатгалын тогтолцооны хуваарилалт тэгш бус гэж харагдаж байна.** Хэдийгээр хүн амын бүлгүүдийн онцлогийг харгалзан үзэх нь зөв ч, НД-д шимтгэл төлөх нийт хугацааг хүн амын бүлгүүдэд өөр өөрөөр тооцож, зарим бүлгүүдэд нөхөн даатгах боломж олгож байна. НД-д тасралтгүй шимтгэл төлсөн даатгуулагчийн хувьд ямар нэгэн урамшуулалгүй хэр нь шимтгэлээ төлөхөөс зайлсхийсэн иргэдэд нөхөн даатгал хийх боломж олгож байгаа нь иргэд, ялангуяа малчид, НД-ын шимтгэл төлөхгүй байх, НД-ын шударга бус тогтолцоог бүрдүүлэх үндэслэл болж байна. Тухайлбал, НД-н тухай хуулийн 4-р зүйлд ажил мэргэжлийн онцлогоос хамааруулан хүн амын зарим бүлгүүдийг 20-25 жил шимтгэл төлсөн бол нас харгалзахгүй өндөр насны тэтгэвэр тогтоон олгох эрх үүсгэж байна. Энэ нь нь залуу наснаас эхлэн тасралтгүй НД-н шимтгэл төлж буй иргэдийн хувьд илүү олон жил, илүү өндөр үнийн дүнгээр НДШ төлсөн ч адил хэмжээний тэтгэвэр авч байгаа нь шударга бус хуваарилалт мэт харагдуулж байна. Улмаар иргэдийн дунд НД-д хамрагдахгүй байх сөрөг хандлага бий болоод байна. Мөн түүнчлэн, тэтгэврийн даатгалын сангийн шударга хуваарилалтын зарчим алдагдсан болохыг илтгэж байна.
- **Нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэхтэй холбоотой гаргаж буй хууль, журмууд нь зөвхөн малчид бус нийт иргэдийг НД-д хамрагдахгүйгээр дараа нь ижил төстэй хууль гармагц даатгалаа нөхөн төлүүлэх сонирхлыг нь төрүүлж байна.** Тэдний хувьд нийгмийн даатгалаа нөхөн төлөх мөн ирээдүйд гарах ижил төстэй хуулийн зохицуулалтыг хүлээн НДШ-ээ төлөхгүй байх сонирхол өндөр байна. Энэ нь НД-д хамрагдалт буурах шалтгаан болж байна.

Мөн НД-ын тухай хуульд заасан “нийгмийн даатгалын шимтгэл” гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч, ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд урьдчилсан төлсөн төлбөрийг хэлнэ гэж заасныг энэхүү хууль зөрчиж байгаа хэрэг болсон. Хэдийгээр энэ хууль нь тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж амжаагүй тэтгэврийн насанд дөхсөн иргэдэд шимтгэлээ нөхөн төлж, улмаар тэтгэвэр тогтоолгох боломж олгосон сайн талтай бол сангийн хувьд цөөн хүн хамрагдах нь төлбөрийн чадварт мөн сайн талтай боловч энэхүү заалтыг хэрэгжүүлснээр шинэ залуу малчид НД-д хамрагдалтаа хойшлуулах, дараагийн нөхөн даатгалын хууль гарахыг хүлээх эргэлзээ төрүүлэх магадлалтай.

- **НД-н шимтгэлийг төлөх давтамж, гэрээг шинэчлэх хугацаа нь малчдын аж амьдрал, орлого олох, зарлага гарах хугацаатай нийцэхгүй байгаа нь малчдыг нийгмийн даатгалд хамруулах боломжийг хязгаарлаж байна.** Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6-д “... сайн дурын үндсэн дээр даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ сар, улирал, хагас жил, жилээр гэрээний дагуу төлнө” гэж заасан. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхдээ НД-ын байгууллага өмнөх сарын шимтгэлийг нөхөн авдаггүй дараа сар, улирлыг урьдчилж авах байдлаар зохион байгуулдаг нь малчдад бэрхшээл учруулдаг байна. Тухайлбал, малчид оны эхэнд ямар ч орлогогүй, малын тэжээлийн зардал ихтэй. Орлого 4-5 сард ноолуураас, оны төгсгөлд мал махнаас ордог. Гэтэл оны эхний 1-4 сарын шимтгэлийг нөхөж авдаггүй энэ нь хамрагдалтад сөргөөр нөлөөлдөг. Малчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд, малчид ноос, ноолуур зарсан орлогоороо оны эхний улирлын НД-н шимтгэлээ хавар нөхөн төлөх сонирхол өндөр байдаг нь ажиглагдсан. Харамсалтай нь, одоогоор 1-ээс 4-р сарын шимтгэлийг нөхөн төлдөггүй нь эдгээр сарын НД-д малчид хамрагдах боломжид нь сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна. Орлогын тогтмол бус байдлаас үүдэн нэг улирал төлөх боломжгүй байсан малчдын хувьд НД-н төлөлтөд тасалдалт бий болдог бөгөөд энэ нь боломжид тэтгэвэр, тэтгэмжид хамрагдахад нь сөргөөр нөлөөлдөг. Ялангуяа, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдахын тулд тасралтгүй төлсөн байх нь үндсэн шаардлага болдог. Жишээлбэл, НД-н тухай хуулийн 19 дүгээр зүйлд ... тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас 12 сараас багагүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй хэмээн заасан. Гэвч, НДШ төлөлтөд үүссэн тасалдалт нь уг шаардлагад нийцэхгүй болгож, шаардлагатай тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй болгоход хүргэдэг. Энэхүү заалтын дагуу, малчдын амьжиргааны орлогын давтамж болон НДШ-н төлөлтийн хуваарь, давтамж хоорондоо нийцэхгүй байгаагаас үүдэн сайн дураар даатгуулагчийн хувьд тэтгэвэр, тэтгэмж авах боломж маш бага байхад нь нөлөөлж байна.

4.4.2. Хэрэгжилттэй холбоотой асуудлууд

- **Нүүдлийн малчдын тархан суурьшсан байдал нь малчин тус бүрд хүрч үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээл үүсгэж байна.** Монгол улсын бэлчээрийн талбай ойролцоогоор 1,0 сая км.кв гэж судлаачид тогтоосон байдаг. Тиймээс, нийгмийн даатгалын байцаагчид болон орон нутгийн удирдлагуудын хувьд малчдад хүрч очих, нийгмийн даатгалд хамруулах нь цаг хугацаа, орон зайн хувьд томоохон сорилт болж байна. Нэн ялангуяа, улирлын шинжтэй хэрэгцээ шаардлага болон хатуу ширүүн уур амьсгалаас шалтгаалан малчид бэлчээр, ус, ургамалтай газруудаар тасралтгүй нүүж явдаг нь малчдын байршлыг тогтоож, алслагдмал газраас олж, хүрч очиход томоохон сорилт болгодог байна.

- **НДС-аас нөхөн төлбөр авах боломжийн талаар мэдээлэл хүртээмжгүй байгаа нь НД-д даатгуулагчид даатгалын давуу талаа ашиглах боломжийг хязгаарлаж, улмаар НД-д хамрагдах сонирхол буурахад нөлөөлж байна.** Тухайлбал малчид осолд өртөх, хүүхэд төрүүлэх, эмнэлэгт хэвтэх зэрэгтээ даатгалаас нөхөн төлбөр тэр бүр авч чаддаггүй. Гол шалтгаан нь тухайн үед сумын төвөөс хол нутаглаж буй байдал, яаралтай эмнэлэгт хандах, нөхөн төлбөр хөөцөлдөх хүн хүчний хүрэлцээ дутмаг байдагтай холбоотой байна. Мөн малчдын нөхөн төлбөр авах боломж, НДС-аас авах боломжтой тэтгэвэр, тэтгэмжийн тухай мэдлэг сул, даатгалын байцаагч нарын хүрч очих боломж, сурталчлах ажил дутмаг байгаатай холбоотой.
- **Нийгмийн даатгалын байцаагч малчин бүрд хүрч ажиллах санхүүгийн нөөц муу байдаг.** Ялангуяа газар зүйн байршлаас шалтгаалан зарим аймгуудад малчдад хүрч очихын тулд ихээхэн цаг хугацаа, мөнгө зарцуулах шаардлагатай болдог. Гэвч, одоогийн байдлаар малчдын тоо болон газар нутгийн хэмжээ, малчдын тархалтаас шалтгаалсан төлөвлөлт, төсөвлөлт хийгдэхгүй байгаа нь орон нутгийн байцаагчдын дунд харилцан адилгүй ачаалал бий болгож, үйлчилгээний хүртээмжийг тэгш бус байхад нөлөөлж байна. Монгол улсын хэмжээнд нийгмийн даатгалд хамрагдвал зохих 233,147 малчинд 330 суманд тархан байршиж байна. Эдгээр малчид орон нутагт нийгмийн даатгалын 352 байцаагч үйлчилж байгаа бөгөөд нэг байцаагчид 662 малчин ногдож байна. Малчдын нийгмийн даатгалд хамрагдалтын байдлыг авч үзвэл нийгмийн даатгалын нэг байцаагч $166 = (58564/352)$ малчныг нийгмийн даатгалд хамруулсан байна. Энэ өргөн уудам нутагт 352 байцаагч хүрч үйлчилгээ үзүүлэхэд цаг хугацаа, орон зай, санхүүгийн хувьд нөөц боломж хомс гэж үзэж болох юм.

4.5. Ололт, асуудлуудын хураангуй

Монголын малчид нь дэлхий дээр нүүдэлчин хэлбэрээр амьдарч буй сүүлийн бүлгүүдийн нэг болж байна. Тиймээс, малчдыг нийгмийн даатгалд хамруулах нь орон зай, цаг хугацаанаас ихээхэн хамаарч байна. Ялангуяа, улирлын шинжтэй хэрэгцээ, эрс тэс уур амьсгал нь малчдыг бэлчээр, ногоо, ус даган тасралтгүй нүүхэд хүргэдэг. Тиймээс, малчдын эдгээр онцлог хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзсан нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчлэх шаардлага байна.

Малчдын хүн ам зүйн бүтэц аажмаар өөрчлөгдөж байна. Нэн ялангуяа, залуу малчдын тоо буурч, эрэгтэй малчдын тоо давамгайлах хандлагатай байна. Энэ нь хүн ам зүйн хувьд малчдын дунд хожуу гэрлэлт өсөх, төрөлтийн хувь буурах, улмаар дотоод шилжилт хөдөлгөөн бий болох гэх мэт сөрөг үр дагавартай байна. Хэдийгээр одоогоор малчдын олонх нь гэрлэсэн байгаа боловч малчдын нас залуужих тусам энэ хувь бурах хандлагатай байна. Мөн малчдын хувьд нас залуужих тусам боловсролын түвшин өндөр болж байна. Малчдын хувьд, дөрвөн малчин тутмын гурав нь амьжиргааны баталгаажих суурь хэрэгцээг хангахуйц тооны малтай байна. Мөн малчин өрхийн орлогын дийлэнх нь мал болон малын бүтээгдэхүүний орлого болон тэтгэвэр, тэтгэмжийн орлогоос бүрдэж байна. Харин малчин өрхийн зардлын хувьд малын тэжээлийн зардал болон зээлийн хүү, буцаан төлөлт нь гол хоёр зардлын төрөл болж байна. Малчдын хувьд амьдарч буй орчин, байгаль цаг уурын байдал, амьдралын хэв маягаас шалтгаалан эрсдэлд өртөх тохиолдол их байна. Мөн газар зүйн байршил болон нүүдэллэн явах онцлогоос хамааран нийгмийн үйлчилгээнд хамрагдах, нэн ялангуяа яаралтай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ авах, цаг үеийн мэдээллээс хоцрохгүй байх, төрийн үйлчилгээг цаг алдалгүй авах боломж хязгаарлагдмал байна.

Малчдын нийгмийн даатгалын асуудлыг гол 7 хуулийн хүрээнд зохицуулж байна. Нийгмийн Даатгалын тухай хуульд зааснаар малчид нь НД-д сайн дураараа хамрагдахаар заагдсан бөгөөд сардаа хамгийн доод тал нь 60.9 мянган төгрөг буюу жилдээ 730.8 мянган төгрөг төлөхөөр байна. 2020 оны байдлаар нийт малчдын дөнгөж 16.4 хувь нь НД-д хамрагдсан байгаа нь малчдын хамрагдалт маш бага байгааг харуулж байна.

Малчдын дунд НД-д хамрагдалт бага байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Юун түрүүнд, хууль, эрх зүйн орчны хувьд малчдыг НД-д сайн дураар хамрагдах зохицуулалт хийж өгсөн нь хамрагдахгүй ч байж болох боломж олгосон. Энэ нь НДШ төлж НД-д хамрагдахгүй байх сонирхлыг нь нь өдөөсөн гол хүчин зүйл болсон. Мөн хүн амын ялгаатай бүлгүүдэд НДС-аас тэтгэвэр авах эрх үүсэх хугацааг өөр өөрөөр зааж өгсөн нь тасралтгүй, тогтмол төлж буй даатгуулагчдад НДС-г шударга бус хуваарилалттай хэмээн харагдуулж байна. Мөн НДШ-ийг нөхөн төлөх хуулийн хүрээнд НД төлдөггүй хүн амын бүлгүүдэд мөн давуу байдал бий болгож, нөхөн төлөх боломжийг үүсгэж, зарим тохиолдолд төрөөс НДШ-ийг хөнгөлөх боломж олгож байна. Энэ нь мөн тасралтгүй, шударгаар төлж буй иргэдийн хувьд сөрөг хандлага үүсгэж, залуу малчдад НД-д хамрагдахгүйгээр ижил төстэй хуульд найдаж, НДШ төлөлтийг хойш тавихад хүргэж байна.

Эдгээрээс гадна, НД-д хамрагдсан болон хамрагдаагүй малчдын хувьд НДШ төлсний давуу тал, үр шимийн талаар мэдлэг дутмаг байгаа нь хамрагдалт бага байхад нөлөөлж байна. Тухайлбал, НДШ төлж буй малчдын хувьд тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсэхүйц нөхцөл байдалд орсон ч нөхөн төлбөр, тэтгэмж, тэтгэвэр авах тухай мэдэхгүй байгаа нь малчдыг НДШ төлсний үр шимээ хүртэхгүй хоцрох, улмаар НД-н тогтолцоонд итгэх итгэл сулрахад хүргэж байна. Энэ нөхцөл байдал нь хөдөө алслагдмал газрын малчдад, мэдээлэл хүргэх, НД-н талаар сурталчлах боломж хязгаарлагдмал байдагтай холбоотой байна. Нэн ялангуяа, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудад малчдын тоо болон газар зүйн байршлын онцлогт тохирсон үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт хийгдэхгүй, ажиллах хүний нөөц, санхүү болон техникийн нөөц хязгаарлагдмал байдаг нь нөлөөлдөг байна. Улмаар сумын болон хөдөө алслагдмал байдаг малчдын хувьд НД-н талаар мэдээлэлгүй байх, ач холбогдлыг нь ойлгохгүй байх, улмаар хамрагдалт бага байхад нөлөөлж байна.

5. НИЙГМИЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААРХ МАЛЧДЫН ЗАН ҮЙЛ


Энэхүү бүлэгт 4000 малчны дунд хэрэгжүүлсэн судалгааны үр дүнг танилцуулах болно. Тус судалгаа нь малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаарх ойлголт, зан үйлийг илүү сайн ойлгох зорилготой. Эхний хэсэгт судалгаанд оролцогчид болон тэдний өрхийн хүн ам зүй, нийгэм-эдийн засгийн онцлогийг тодорхойлсон. Дараа нь тайланд амьдралын мөчлөгийн өвөрмөц эрсдэл, судалгаанд оролцогчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаарх мэдлэг, ойлголтод дүн шинжилгээ хийсэн. Төгсгөлийн хэсгүүдэд дүн шинжилгээ нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахад нөлөөлж буй хүчин зүйлсэд төвлөрч, малчдын дунд хийсэн туршилтын үр дүнг танилцуулсан.

5.1. Оролцогчдын хувийн болон өрхийн хүн ам зүйн мэдээлэл ба нийгэм, эдийн засгийн шинж байдал

5.1.1. Оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Судалгаанд нийт 4000 малчин оролцсон ба үүний 55% нь эрэгтэй малчид бол 45% нь эмэгтэй малчид байна. Нийт оролцогчдын дийлэнх нь буюу 55% нь өрхийн тэргүүн байсан бол үлдсэн малчдын 82% нь өрхийн тэргүүний эхнэр/нөхөр байв. Оролцогчдын дийлэнх нь 35-44 настай (39%) байсан ба 25-34 болон 45-54 насны ижил хэмжээний (27% ба 28%) оролцогчид оролцсон. Таван оролцогч тутмын дөрөв нь гэрлэсэн хүмүүс байв (81%).

Дүрс 8. Судалгаанд оролцогчид, насны бүлгээр



Дүрс 9. Судалгаанд оролцогчид, гэрлэлтийн байдлаар




Ойролцоогоор гурван оролцогч тутмын нэг нь бүрэн бус дунд боловсролтой бол тэдний зөвхөн 8% нь дээд боловсрол эзэмшсэн байна. Боловсролын түвшний жендерийн байдлаар харьцуулан үнэлэхэд дунд болон түүнээс дээш боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс арай өндөр байна.

Дүрс 10. Оролцогчдын боловсролын түвшин, хүйсээр




Дүрс 11. Оролцогчдын боловсролын түвшин, насны бүлгээр



Дээрх дүрсэд харуулсанчлан боловсролын түвшин залуу насны бүлгүүдийн дунд өндөр байгаа буюу дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийн тал нь 25-34 насны хүмүүс байна.

Дүрс 12. Хүүхдийн тоо



Дүрс 13. Эцэг эхийг тань хэн асардаг вэ?




Оролцогчдын дийлэнх нь буюу 86% нь хүүхэдтэй байсан ба тэдний хүүхдийн дундаж тоо нь 2.9 буюу 2-3 хүүхэдтэй байна. Ойролцоогоор дөрвөн оролцогч тутмын нэг нь 4-5 хүүхэдтэй. Судалгаанд оролцогчдын ердөө 15% нь өөрийн эцэг эхийг асарч халамжилдаг бол 17% нь өөр хүнээр эцэг эхээ асруулдаг байна.


5.1.2. Өрхийн бүтэц, орон сууц болон хөрөнгө

Судалгаанд оролцогчдын өрхийн гишүүдийн тоо олон гэдэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал оролцогчдын өрхийн гишүүдийн тоо дунджаар 4.3 буюу оролцогчдын тал хувь нь 4-5 өрхийн гишүүдтэй байна, харин 22% нь 6 ба түүнээс дээш өрхийн гишүүнтэй байна. Түүнчлэн бараг бүх өрхөд (98%) бүртгэлтэй малчин амьдардаг бол тэдний дийлэнх нь (74%) нэгээс олон малчинтай.

Дүрс 14. Өрх тус бүрт одоогоор амьдарч буй хүний тоо



Дүрс 15. Өрх тус бүрт байгаа бүртгэлтэй малчдын тоо




Судалгаанд хамрагдсан оролцогчдын тал хувь нь нийт 2 ба түүнээс дээш тооны сууц эзэмшдэг байна. Дийлэнх оролцогчид (69%) хөдөө орон нутагт амьдардаг бол 22% нь сумын төвд харин аймгийн төвд ердөө 9% нь амьдардаг байна. Оролцогчдын дийлэнх хувь буюу 86% нь хөдөө орон нутагт дор хаяж нэг сууцтай байсан бол 2% нь нийслэл хотод өөрийн сууцтай байв.

Дүрс 16. Танай өрхийн сууц хаана байрладаг вэ?



Дүрс 17. Танд хэдэн сууц байгаа вэ?



Нүүдэлчин аж амьдралтай гэдгээс үл шалтгаалан оролцогчдын тал хувь нь өөрийн гэсэн газар эзэмшдэг байна. Судалгаанд оролцогчдын ихэнх буюу 70% нь мотоциклтой байхад өөрийн эзэмшлийн машинтай оролцогчдын хувь талаас бага байна.


Дүрс 18. Танай өрхөд доорх өмч хөрөнгө байдаг уу? (олон сонголттой)



5.1.3. Орлогын мэдээлэл

Малчдын орлогын гол эх үүсвэр нь мал болон малын бүтээгдэхүүнээс олсон орлого, тэтгэвэр, тэтгэмжийн мөнгө байна. Судалгаанд оролцсон малчдын өрхийн жилийн орлого дунджаар 15,278,807.0 төгрөг байгаа нь Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан өрхийн дундаж орлоготой ойролцоо байна. Байршлаар харьцуулан харвал, хөдөөгийн өрхүүдийн хувьд орлого нь нийт малчдын дундаж орлогоос өндөр байгаа бол аймгийн төв болон сумын төвийн малчдын хувьд харьцангуй бага орлоготой байгаа нь харагдаж байна. Түүнчлэн аймаг болон сумын төвд амьдардаг малчдын хувьд цалингийн орлогын хувь харьцангуй өндөр байна.

Дүрс 19. Танай гэр бүлийн дундаж орлого хэд вэ?



Оролцогчдын дийлэнх хувь (81%) нь хүүхдийн мөнгө авдаг ба түүнчлэн ач холбогдол бүхий хувь нь (22%) 3-аас доош насны хүүхдээ асрах тэтгэмж авдаг байна. Харин малчдын ердөө 14% нь өндөр насны тэтгэвэр авдаг байна.

Хүснэгт 16. Малчин гэр бүлүүдийн авдаг нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмж

Нийгмийн халамжийн төрлүүд	Хувь
Хүүхдийн мөнгө	81%
Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд олгох тэтгэмж	26%
Жирэмсний тэтгэмж болон 3-аас доош насны хүүхдээ асрах тэтгэмж.	22%
Өндөр насны тэтгэвэр	14%
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр	12%
Асрамжийн тэтгэмж	4%
Ахмад настан, тэжээгчээ алдсан 18-аас доош насны хүүхэд, өрх толгойлсон эцэг/эх болон 16-аас дээш насны одой хүмүүсийн тэтгэмж	3%
Хоол хүнс, тэжээлийн дэмжлэг (хүнсний талон)	3%
Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сувилал, амралтын газарт үзүүлэх хөнгөлөлт	1%
Бусад тэтгэмж, хөнгөлөлт	1%
Бусад	1%

Судалгаанд оролцогчдын ач холбогдол бүхий хувь буюу 22% нь өөрийн болон гэр бүлийн орлогыг тодорхойлохдоо амьжиргаагаа залгуулахад хэцүү (эсвэл маш хэцүү) байдаг гэж тодорхойлсон бол 62% нь зохицуулан амьдардаг гэх хариулыг өгсөн байна. Харин бага хэмжээний малчид тав тухтай амьдарч байна гэжээ.

Дүрс 20. Та өөрийн болон гэр бүлийн орлогын нөхцөл байдлыг тодорхойлно уу.



Малчдын олонх нь өрхийн зээлтэй байгаа бөгөөд хадгаламжтай малчдын хувь асар бага байна. Нийт өрхийн 64 хувь нь зээлтэй байгаа бол, дөнгөж 12 хувь нь хадгаламжтай байна. Өрхийн орлогын түвшин нэмэгдэх тусам хадгалах боломжтой өрхийн тоо нэмэгдэж байна. Дунджаар тэд жилд 4.1 сая төгрөг хадгалах боломжтой байна. Гэсэн хэдий ч хадгаламжтай хүмүүсийн тал хувь нь жилд 2.4 сая төгрөгөөс бага мөнгө хадгалдаг байна. Өрхийн орлого нэмэгдэх тутам идэвхтэй зээлтэй өрхийн тоо нэмэгдэж байгаа боловч орлогын түвшин өндөр болох үед зээлтэй өрхүүдийн хувь эргээд буурч байна.

Дүрс 21. Зээл болон хадгаламжийн байдал, орлогын түвшнээр



Судалгаанд оролцогч нэг өрх дунджаар 49 бод, 353 бог мал эзэмшиж байгаагаас сүүлийн 12 сарын хугацаанд малынхаа 8 хувийг байгалийн гамшигт өвчин, хулгай, чоно, нохойд бариулах зэргээс үүдэн алджээ. Судалгаанд оролцсон нийт 4000 малчдын хувьд нийт 1,607,784 мал эзэмшиж байгаа бөгөөд нийт малын 12 хувийг бог мал, 88 хувийг бод мал эзэлж байна. Байршлаар нь харьцуулан үзвэл, аймгийн төвд нийт малын 6 хувь, сумын төвд 18 хувь, хөдөөд 76 хувь нь тус тус байршиж байна.


Хүснэгт 17. Малын тоо болон сүүлийн 12 сард алдсан малын тоо, байршлаар

Төрөл	Мал, байршлаар					Байгалийн гамшиг, гэмт хэрэг, халдварт өвчин эсвэл амьтадын дайралтаас шалтгаалан сүүлийн 12 сарын хугацаанд алдсан мал				
	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө орон нутаг	Нийт	%	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө орон нутаг	Нийт	%
Үхэр	638	1,951	13,185	15,774	1	86	389	1,282	1,757	11
Адуу	5,066	15,808	71,453	92,327	6	419	1,716	6,963	9,098	10
Тэмээ	5,821	16,014	66,055	87,890	5	433	1,810	6,795	9,038	10
Хонь	44,694	121,250	549,016	714,960	44	3,957	9,916	37,755	51,628	7
Ямаа	48,543	128,632	519,645	696,820	43	3,499	10,323	37,812	51,634	7
Бусад	0	2	11	13	0	0	0	0	0	0
Нийт	104,762	283,657	1,219,365	1,607,784	-	8,394	24,154	90,607	123,155	8
% (нийт дүнгээс)	6	18	76	100	100	7	20	73	100	-


*%-төрөл тус бүрийн нийт дүнгээс

Сум болон хөдөөгийн малчдын хувьд холбоо, хоршоолол, нөхөрлөлд хамрагдах нь нийтлэг байгаа ч, мал аж ахуйтай холбоотой шийдвэрээ гэр бүлийн хүрээнд зөвлөлдөж гаргаж байна. Нийт малчдын 20 хувь нь ямар нэгэн малчдын бүлэг, хоршоо, холбоонд хамаарч байна. Малчдын гишүүнчлэл нь байршил, насны бүлэг, орлогын өөр бүлэг бүхий малчдын хувьд ялгаатай байна.

Дүрс 22. Танай өрх аливаа малчдын бүлгэм/хоршоо/холбоодод харьяалагддаг уу, байршлаар



Дүрс 23. Танай өрх аливаа малчдын бүлгэм/хоршоо/холбоодод харьяалагддаг уу, насны бүлгээр




Хөдөөгийн малчид болон ахимаг насны малчдын өрх нь ямар нэгэн холбоод элссэн хувь нь өндөр байна. Эдгээрээс гадна, өрхийн жилийн орлого нь 20 болон түүнээс дээш саяын орлоготой өрхийн

аливаа нэг холбоо, бүлэгт гишүүнчлэлтэй хувь (28%) нь бусад доогуур орлоготой өрхүүдээс хамгийн багадаа 7 пунктээр илүү байна.

Ямар нэгэн холбоонд гишүүнчлэлтэй байгаа нь мал ахуйтай холбоотой шийдвэр гаргалтад төдийлөн нөлөөгүй байна. Тухайлбал, нийт малчдын 70 хувь нь эхнэр эсвэл нөхөртэйгөө, 14 хувь нь эцэг эхтэйгээ, 7 хувь нь бие дааж өөрөө шийд гаргаж байна. Өөрөөр хэлбэл, нийт малчдын 80 гаруй хувь нь гэр бүлийн орчинд зөвлөлдөж, бие дааж шийдвэр гаргаж байна.


Дүрс 24. Мал аж ахуйтай холбоотой чухал шийдвэр гаргахаасаа өмнө хэнтэй зөвлөлддөг вэ?



Харин насны бүлгээр нь харьцуулан харвал, 24 хүртэлх насны залуу малчдын олонх нь эцэг эхтэйгээ зөвлөлдөж байгаа бол, 25-аас дээш насны малчдын хувьд эхнэр/нөхөртэйгөө зөвлөлдөн шийдвэр гаргаж байна.

Мал, малын гаралтай бүтээгдэхүүн нь өрхийн орлогын гол эх үүсвэр болдог гэж хариулсан малчид малаа даатгуулах нь илүү байгаа ба тэдний даатгал хийсэн хугацаа ч мөн урт байна. Гурван малчин тутмын нэг нь (31%) өөрийн малыг байгалийн гамшиг, хулгай болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс даатгуулсан байна. Байршлаар харвал, аймгийн төвд амьдардаг малчид илүүтэй (66%) малын даатгалд хамрагдаагүй байна. Хоршоо, холбооны гишүүн байх нь малын даатгалд хамрагдах магадлалыг бас нэмэгдүүлдэг байна. Гишүүнчлэлтэй хүмүүсийн 40 хувь нь даатгалтай. Малын даатгалд хамрагдах хугацааны хувьд малчид дунджаар 4.5 жил малаа даатгуулсан байна. Малчдын талаас илүү хувь нь (54%) малаа дөрвөн жилээс доош хугацаагаар даатгуулсан байна.

Дүрс 25. Та одоогийн байдлаар өөрийн малыг даатгалд хамруулсан уу? Өрхийн орлогын түвшингээр



Дээрх дүрсэд харуулсанчлан малын даатгал хийлгэх нь тухайн өрхийн орлого болон өрхөд харьяалагдах малчдын тооноос шалтгаалж байна. Тухайлбал, харьцангуй өндөр өрхийн орлоготой малчид илүү их малын даатгалд хамрагдсан байна. Түүнчлэн 'малчин өрх' буюу хоёр ба түүнээс дээш малчинтай өрх нь өөрийн малыг дөрөв ба түүнээс дээш жил даатгуулжээ. Эсрэгээрээ зөвхөн нэг малчинтай өрхүүдийн 70% нь өөрийн малыг гурав ба түүнээс бага жилээр даатгуулсан байна. Малын даатгалын хувь хэмжээ нь малын тоо толгойтой эерэг хамааралтай буюу малчид олон малтай байх тусан малын даатгалд хамрагдах байдал нь нэмэгдэж байна.

Малчдын хувьд малаа даатгуулах үндсэн шалтгаанууд нь банк, санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцэх болон зудад нэрвэгдэх магадлалаас хамаарч байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад банкнууд малчдад зээл олгохын тулд малчдыг малаа заавал даатгуулсан байх шаардлагыг тавьдаг байна. Малчид малаа даатгуулсан шалтгаан нь өөрийн сайн дурын үндсэн дээр биш зайлшгүй шаардлагын дагуу даатгуулсан байх тохиолдол өндөр байна. Малаа даатгалд хамруулах хоёр дахь гол шалтгаан нь тухайн жилд байгалийн гамшигт (зуд) нэрвэгдэх магадлалаас урьдчилан сэргийлэх зорилготой байсан. Харин ердөө 18% нь өөрийн малыг өөр бусад аюул буюу хулгай, халдварт өвчин гэх мэт зүйлсээс хамгаалах зорилгоор даатгуулдаг. Дээрх дүрсэд харуулсанчлан даатгалын талаарх мэдээлэл, даатгалын ашиг тус эсвэл эргэн тойрны хүмүүсээс ирэх ятгалга нь даатгалд хамрагдах хүсэлд нөлөөлдөггүй байна.


Дүрс 26. Ямар шалтгааны улмаас та малаа даатгуулж байсан/байна вэ?



5.2. Малчдын амьдралын мөчлөгийн эрсдэлүүд

Оролцогчдын дийлэнх нь (96%) нь гэж өөрийн эрүүл мэндийн байдлыг дундаж эсвэл түүнээс дээш үнэлсэн байна. Эрүүл мэндийн байдлын үнэлгээг насны бүлгээр харьцуулан харвал ахимаг насны оролцогчид (35-53 нас) өөрийн эрүүл мэндийг дундаж гэж үнэлсэн бол залуу хүмүүс (35-аас доош нас) өөрийн эрүүл мэндийг маш сайн, сайн гэж үнэлжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөрийн эрүүл мэндийг сайн гэжээ.

Дүрс 27. Эрүүл мэндийн байдал, насны бүлгээр



Эрүүл мэндийн байдлын үнэлгээг орлогын нийт бүлэгтэй харьцуулан харвал өөрийн эрүүл мэндийг сайн эсвэл маш сайн гэж үнэлсэн оролцогчид орлогын янз бүрийн түвшинтэй байна. Гэсэн хэдий ч өөрийн эрүүл мэндийг муу эсвэл маш муу гэж хариулсан малчдын ихэнх нь бага орлоготой байна.

Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог 1-ээс 10-ын хооронд үнэлүүлэхэд дунджаар 5.4 оноо авсан байна. Тус тогтолцоог чанаргүй болон огт чанаргүй гэж хариулсан оролцогчдын дийлэнх нь өөрийн эрүүл мэндийг муу, маш муу гэж үнэлсэн. Харин өөрийн эрүүл мэндийг дундаж эсвэл сайн гэж үнэлсэн оролцогчид дунджаар эрүүл мэндийн тогтолцооны чанарыг 10-аас 5 орчим оноогоор үнэлжээ. Харин нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх итгэлийг 1-10 оноогоор үнэлүүлэхэд дунджаар 5.8 оноо авсан байна. Өөрийн эрүүл мэндийг маш сайн гэж үнэлсэн оролцогчдын ихэнх нь тус тогтолцоонд хамгийн өндөр оноог өгсөн байна.

Дүрс 28. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо; Чанар болон Итгэлийн үнэлгээ, эрүүл мэндийн байдлаар




Судалгаанд хамрагдагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо харьцангуй бага байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэлээд хэсэг нь албан ёсоор бүртгэгдээгүйгээс шалтгаалан засгийн газар болон даатгалын ямар ч тэтгэмж авах боломжгүй байна. Хөгжлийн бэрхшээлийг төрлөөр ангилан харвал судалгаанд оролцогчдын 8% нь байнгын хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд тэдний 3% нь албан ёсоор бүртгэгдээгүй хүмүүс байна. Тиймээс байнгын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараг 40% нь бүртгэлгүй байгаа юм.

Дүрс 29. Хөгжлийн бэрхшээлтэй оролцогчид, хувиар



Дүрс 30. Өрхөд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг оролцогчид, хувиар



Түүнчлэн оролцогчдын 12% нь өөрийн гэр бүл дотор хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг гэж хариулсан ба эдгээр хүмүүсийн 2% нь албан ёсны бүртгэл хийлгээгүй байна. Тиймээс ойролцоогоор хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийн 20% нь албан ёсоор бүртгэлгүй байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй болсон малчдын хувьд олонх нь осол, гэмтлээс үүдэлтэй хөгжлийн бэрхшээлтэй байна. Судалгааны дүнгээс харахад малчдын хөгжлийн бэрхшээлийн гол шалтгаанууд нь осол, гэмтэл эзэлнэ; тухайлбал, нийт осол гэмтлийн 65% нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан байна. Түүнчлэн оролцогчдын 26%-ийг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна.

Дүрс 31. Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан




Ялангуяа, аж ахуй эрхлэх явцад гарсан осол гэмтлээс үүдэн хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн ихэнх нь эрэгтэй малчид байна. Тухайлбал, ХБ-тэй эрэгтэй малчдын 31 хувь, харин эмэгтэй малчдын 27 хувь нь аж ахуй эрхлэх явцад гарсан ослоос үүдэн ХБ-тэй болжээ. Мөн байршлын хувьд, ХБ-тэй хөдөө амьдардаг малчдын 31 хувь нь аж ахуй эрхлэх явцад үүссэн ослоос үүдэн ХБ-тэй болсон бол, аймгийн төвийн болон сумын төвийн малчдын 26 хүртэлх хувь л ижил хариулт өгчээ.

Судалгаанд оролцогч малчид болон тэдгээрийн гэр бүлийн орчинд эрүүл мэндтэй холбоотой тэтгэвэр, тэтгэмж авах нөхцөл байдалд нийтлэг тулгарч байгаа ч, зохих тэтгэмжээ авсан хувь бага байна. Тухайлбал, арван малчин тутмын нэгээс хоёрынх нь гэр бүлд нь хүнд өвчин туссан, жирэмсэн болсон эсвэл амаржсан, хэн нэг нь хүн өвчний улмаас гэнэтийн зардал гарсан гэх мэт тохиолдлууд сүүлийн 12 сарын хугацаанд нийтлэг гарсан байна. НД-аас тэтгэвэр тэтгэмж авах шаардлага хангаж буй эдгээр тохиолдлуудаас маш цөөн хувь нь л НД-с тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, нийт тэжээгчээ алдсан өрхийн дөнгөж 13 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэмж, өрхийн нэг гишүүн нь жирэмсэн болсон эсвэл амаржсан өрхийн 57 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байсан байна.


5.3. Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэг, ухамсар

Эрүүл мэндийн даатгалд хамрагдалт нь хүйс болон насны бүлгээс хамаарч мэдэгдэхүйц ялгаатай байна. Гурван малчин тутмын хоёр нь (66%) эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Доорх дүрсэд хүйсээр нь харьцуулан харуулсанчлан, эмэгтэй малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт эрэгтэй малчдаас даруй 12 пунктээр өндөр байна. Малчидтай хийсэн ярилцлагад дурдсанаар, эмэгтэй малчид жендерийн онцлог бүхий эрүүл мэндийн үйлчилгээ, тэтгэмжид илүү хамрагддаг нь эмэгтэй малчдын дунд эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь өндөр байхад нөлөөлдөг байна.

Дүрс 32. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, хүйсээр



Дүрс 33. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлгээр




Харин насны онцлогийн хувьд, 35 болон түүнээс дээш насныхны дунд эрүүл мэндийн даатгалд хамрагдалт өндөр болж байна. Ялангуяа, малчид болон орон нутгийн нийгмийн даатгалын байцаагчидтай хийсэн ярилцлагад тэтгэвэрт гарах нас ойртох тусам эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах сонирхол малчдын дунд ихэсгэдгийг онцлог дурдсан байдаг.

Малчдын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт нь эрүүл мэндийн даатгалд хамрагдалтад чухал нөлөөтэй байна. Тухайлбал, малчдын боловсролын түвшин, болон өрхийн орлого өндөр байх тусам эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь өндөр байна.

Дүрс 34. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, боловсролын түвшнээр



Дүрс 35. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, орлогоор



Дээд боловсролтой малчид болон өрхийн жилийн орлого нь 20 болон түүнээс дээш сая төгрөгийн орлоготой малчдын хувьд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хувь өндөр байна. Энэ нь нэг талаас боловсролын түвшин нэмэгдэх тусам эрүүл мэндийн даатгалын тухай мэдлэг ойлголт, мэдээлэлтэй байх, орлого нэмэгдэх тусам төлбөр төлөх чадамжтай байдагтай холбоотой юм.

Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан буй шалтгаан малчдын наснаас хамааран харилцан адилгүй байна. Малчдын хувьд, зайлшгүй даатгуулах шаардлагатай даатгал учраас (41%), мөн өөрийгөө болон гэр бүлээ өвдөх эрсдэлээс сэргийлэхийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан (36%) гэсэн нийтлэг хоёр хариултыг сонгожээ.

Хүснэгт 18. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гол шалтгаанууд

Шалтгаан:	Насны бүлэг				Нийт
	15-24	25-34	35-44	45-54	
Энэ нь заавал хамрагдах шаардлагатай зүйл учир	46%	45%	39%	39%	41%
Өөрийгөө болон өөрийн гэр бүлээ өвдөх эрсдэлээс хамгаалахын тулд	21%	32%	39%	40%	36%
Эрүүл мэндийн үйлчилгээг хямд өртгөөр авах боломжтой учир	19%	20%	26%	27%	24%
Өөрөө өвдсөн тохиолдолд өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахын тулд	28%	18%	22%	24%	22%
Өвдсөн тохиолдолд өөрийн санхүүгийн байдлыг хамгаалахын тулд	18%	11%	13%	12%	13%
Бусад	8%	9%	5%	4%	6%

Насны ангиллын хувьд, 15-34 насны буюу харьцангуй залуу малчид 'зайлшгүй даатгуулах шаардлагатай учраас' гэсэн хариултыг гол төлөв сонгосон бол 35-аас дээш насныхан "өөрийгөө болон өөрийн гэр бүлээ өвдөх эрсдэлээс хамгаалахын тулд" гэсэн байна. Энэхүү үр дүн нь нас ахих тусам малчид эрүүл мэнддээ илүү анхаарал хандуулж, эрсдэлээс сэргийлэн даатгуулах хандлагатай болдгийг харуулж байна.

Малчид эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байгаа гол шалтгааныг тодруулан асуухад эрүүл мэндийн даатгалын ач холбогдолгүй мөн үнэтэй гэсэн хариулт нийтлэг дурдагдаж байна. ЭМД-д тэдний хамрагдахгүй байгаа шалтгаан нь нас, хүйс, орлогын түвшин зэргээс хамаарч харилцан адилгүй байна. Одоогоор ЭМД-д хамрагдаагүй байгаа малчдын хувьд дурдагдсан хамгийн нийтлэг хоёр шалтгаан нь ЭМД чухал бус (27%), ЭМД үнэтэй (22%) гэсэн хариултауд байна.

Нийтлэг дурдагдсан шалтгаануудын хувьд, эрэгтэй малчид ЭМД-г чухал бус (30%) гэсэн хариулт өгч байгаа бол, эмэгтэй малчдын хувьд хэтэрхий үнэтэй гэсэн хариулт (28%) өгч байна. Эдгээр хариултаас дүгнэлт хийхэд эрчүүдийн дунд ЭМД-г үл тоох хандлага давамгайлж байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд хамрагдахыг хүссэн ч төлбөрийн чадамжгүй байдал нь хамрагдалтад нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

Хүснэгт 19. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй шалтгаан

Шалтгаан:	Насны бүлэг				Боловсролын түвшин						Нийт
	15-24	25-34	35-44	45-54	Боловсролгүй	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд	
Үүнийг чухал бус гэж үзэж байна	27%	26%	29%	28%	26%	34%	28%	26%	26%	27%	27%
Шимтгэл нь маш өндөр байдаг	10%	18%	23%	30%	22%	22%	26%	20%	26%	21%	22%
Үүнд хэрхэн хамрагдах талаар мэдэхгүй	19%	16%	14%	12%	28%	11%	15%	16%	9%	9%	15%
Надад хэрэггүй	10%	13%	15%	10%	10%	12%	13%	13%	23%	10%	13%
ЭМД-д заавал хамрагдах ёстойг би мэдээгүй	23%	18%	10%	8%	8%	12%	11%	14%	7%	21%	13%
Би ЭМД-д итгэдэггүй	3%	6%	7%	6%	10%	8%	4%	6%	5%	10%	6%
Би хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан	1%	1%	2%	1%	0%	2%	1%	1%	0%	1%	1%

Насны бүлгийн хувьд 34 хүртэлх насны малчин залуучууд 'ЭМД-д хэрхэн хамрагдах талаар мэддэггүй' гэсэн хариултыг нийтлэг өгсөн бол, 35 болон түүнээс дээш насны малчдын хувьд 'хэтэрхий үнэтэй' гэсэн хариулт мэдэгдэхүйц өндөр байна. Эдгээр тоонууд нь харьцангуй залуу малчдад зорилтот мэдээллийн аян илүү хүрэх боломжтойг илтгэх байна. Тэд эрүүл мэндийн даатгалд хэрхэн хамрагдах талаар мэдээлэл муутай байдаг байна. Мөн өрхийн орлогын түвшин ихсэх тусам ЭМД-г чухал биш гэж үзэх хувь өндөр байгаа бол, эсрэгээрээ өрхийн орлого буурах тусам 'ЭМД хэт үнэтэй' гэсэн хариулт давамгайлж байна. Малчид боловсролын түвшнээс хамаарч харилцан адилгүй хариулт өгсөн байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой малчдын хувьд 'ЭМД-д хэрхэн хамрагдах талаар мэдэхгүй' гэсэн хариулт давамгайлж байна. Энэ нь боловсролын түвшин багатай хүмүүсийг даатгалд хамруулахын тулд мэдээлэл хүргэх зорилго бүхий материал эсвэл олон нийтийн аян нь эдгээрийг тусгасан байдлаар бэлтгэгдэж, загварчлагдах ёстойг илтгэж байна.

Малчдын дунд НД-н тухай мэдлэг, ойлголт бага байгаа бөгөөд энэ нь НД-н хамрагдалтад мэдэгдэхүйц нөлөөтэй байна. Малчдын олонх нь НДШ-н талаар суурь ойлголтгүй байна.

Тухайлбал нийгмийн даатгалын талаар малчдын 35 хувь нь суурь ойлголт төдий мэдээлэлтэй байгаа бол 47 хувь нь тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлж болох тухай мэдэж байна. Харин нийт судалгаанд оролцсон малчдын 39 хувь нь НДШ төлж байгаа бөгөөд 29% нь сайн дураар, 9% нь албан журмаар хамрагдсан байна.


Дүрс 36. НДС-д нэгдэх, нөхөн даатгуулах боломжийн талаарх мэдлэг




Даатгалын талаар мэдээлэл бага байхын хэрээр малчдын НД-н хамрагдалт бага байна. Тухайлбал, НД-н тухай суурь ойлголттой гэж хариулсан малчдын 42 хувь нь НД-д одоо хамрагдаж байгаа бол, суурь ойлголтгүй иргэдийн 37 хувь нь хамрагдсан байна. Үүнтэй адилаар, нөхөн төлөлтийн тухай мэдээлэлтэй малчдын 46 хувь нь НД-д хамрагдсан бол, мэдээлэлгүй малчдын 32 хувь нь хамрагдаад байна. Даатгалын талаар харьцангуй мэдээлэл, ойлголттой малчдын хувьд хамрагдалт өндөр байгааг ч мэдээлэл сайтай боловч НД-д хамрагддаггүй малчид нэлээдгүй хувийг эзэлж байна.

НД-н тухай суурь мэдлэг, мэдээлэл нь малчдын нас, боловсролын түвшнээс хамааран өөр хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай байна. Тухайлбал, сумын төвийн, боловсролын түвшин өндөр, ахимаг насны малчдын хувьд НД-н тухай суурь ойлголт сайтай байна.

Дүрс 37. НДС-ийн талаарх мэдлэг, насны бүлгээр



Дүрс 38. Нөхөн даатгуулах болон хэрхэн даатгуулах талаарх мэдлэг, насны бүлгээр



Онцолбол, ахимаг насны малчдын дунд НД-н суурь ойлголттой малчдын эзлэх хувиас илүү тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн төлөлттэй холбоотой мэдээлэлтэй малчдын хувь өндөр байна. Энэ нь малчид залуу насандаа НД-н тухай суурь ойлголттой болсон ч НДШ-г төлж эхлэхээс

илүүтэйгээр, тэтгэврийн насанд дөхсөн үедээ нэмэлт боломж, нөхөн төлөлтөд тулгуурлан хамрагдах шийдвэр гаргаж байгааг харуулж байж болох юм.

НДШ-н хамрагдалт нь малчдын хүн ам зүйн байдлаас хамааран мэдэгдэхүйц ялгаатай байна. НДШ төлж байгаа болон төлөөгүй малчдыг хүн ам зүй үзүүлэлтүүдээр нь харьцуулахад, ахимаг насны, эмэгтэй малчдын хувьд НДШ төлж буй хувь өндөр байна. Доорх дүрсэд үзүүлсэнчлэн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчдын хувьтай адилаар НДШ-г эмэгтэйчүүд илүү төлж байна.

Дүрс 39. Малчдын НДШ төлж буй байдал



Нэн ялангуяа, эмэгтэйчүүд жирэмсний болон амаржсаны тэтгэмж гэх мэт хүйсийн онцлогоос хамаарсан нэмэлт тэтгэмж, тэтгэвэр авах боломжтой байдаг нь нэг сэдэлжүүлэгч хүчин зүйл байдгийг орон нутгийн нийгмийн даатгалын ажилтнууд болон эмэгтэй малчид дурдаж байсан. Түүнчлэн тэтгэвэрт гарах нас дөхөж байгаа малчид нийгмийн даатгалд хамрагдах идэвх нэмэгддэг байна. Малчидтай хийсэн ярилцлагаас харахад ахмад насны малчид цаашид Тэтгэврийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авах хүсэл эрмэлзэл өндөр байна.

Орлогын болон боловсролын түвшин ялгаатай малчдын бүлгүүдийн хувьд НДШ-г төлж буй хувь харилцан адилгүй байна. Тухайлбал НДШ төлж буй малчдын боловсролын болон орлогын түвшин харьцангуй өндөр байна.

Дүрс 40. Одоогийн хамрагдсан байдал, боловсролын түвшинээр



Дүрс 41. Одоогийн хамрагдсан байдал, өрхийн орлогоор



Сумын төвд оршин суугаа малчдын хувьд аймгийн төв болон хөдөө орон нутагт байрлах малчидтай харьцуулахад НД-д хамрагдалт өндөр байна. Энэ нь сумын төвийн малчдын дунд өндөр боловсролтой, орлогын түвшин өндөр, давхар ажил эрхэлдэг малчдын эзлэх хувь харьцангуй өндөр байгаатай холбоотой байна. Сумын төвийн малчдын хувьд, аймгийн төвийн болон сумын төвийн малчидтай харьцуулахад өндөр боловсролтой малчдын эзлэх хувь өндөр байдаг. Мөн сумын төвийн малчдын хувьд өрхийн орлого тогтвортой дундаж хэмжээнд байдаг бөгөөд мал маллахаас гадна давхар ажил эрхэлдэг бөгөөд тэдний эзлэх хувь (29%) байгаа бол аймгийн төвд оршин суугч малчдын эзлэх хувь (27%) байна. Харин хөдөөгийн малчдын эзлэх хувийн жин (11%) байна. Давхар ажил эрхлэлттэй холбоотойгоор сумын төвийн малчдын дунд албан журмаар даатгуулах малчдын хувь харьцангуй өндөр байна.

Дүрс 42. Одоогийн хамрагдсан байдал, байршлаар



Энэ мэт боловсрол болон ажил эрхлэлттэй холбоотой давуу талаас үүдэн, сумын төвийн малчдын хувьд НДШ-д хамрагдалт 44%-тай буюу аймгийн төв (38%) болон хөдөөгийн (37%) малчдаас хамгийн багадаа 6 пунктээр илүү байна.

НД-с ирээдүйд авах үр ашгийг чухалчлан үзсэн малчдын эзлэх хувь нь болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд НДШ төлж байгаа малчдын эзлэх хувиас даруй 6 дахин их байна. Одоо НДШ төлж байгаа малчдын олонх нь (67%) ирээдүйд тэтгэвэрт гарах хүсэлтэй учраас НДШ төлж байгаа гэсэн бол, удаах нийтлэг хариулт нь 'өөрт тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхийн тулд гэсэн хариултыг (11%) өгчээ.

Хүснэгт 20. НДС хамрагдалтын шалтгаан, насны бүлгээр

Шалтгаан:	15-24	25-34	35-44	45-54	Нийт
Би ирээдүйд тэтгэвэрт гарах хүсэлтэй байсан	40%	48%	69%	79%	67%
Би өөрт тохиолдож болох эрсдэлээс /жирэмсэн болсон, өвдсөн, осолд өртөх, гэнэт нас барсан зэрэг/ сэргийлж даатгуулахыг хүссэн	12%	14%	11%	10%	11%
Нийгмийн даатгалын байцаагч шаардсан	2%	4%	4%	3%	4%
Энэ миний эхнэр/нөхрийн гаргасан шийдвэр	0%	2%	3%	3%	3%
Энэ чиглэлийн мэдээллийн кампанит ажлууд явагдсан	0%	3%	2%	2%	2%
Энэхүү шийдвэрийг гаргахад хүргэсэн үйл явдалд манай гэр бүлд тохиолдсон	4%	2%	2%	2%	2%
Миний мэдэх нэг хүнд ийм шийдвэр гаргахад хүргэсэн үйл явдал тохиолдсон	2%	1%	1%	2%	1%
Надад манай бүлэг /хоршоо/ холбоо зөвлөсөн	0%	1%	1%	1%	1%

НДШ төлж буй гол шалтгаануудыг насны бүлгээр нь харьцуулан харвал мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, 35 болон түүнээс дээш насныхны 69 болон түүнээс дээш хувь нь ирээдүйд тэтгэвэрт гарах хүсэлтэй гэж хариулсан бол, 35 болон түүнээс доош насныхны 50-аас доош хувь нь дээрх хариултыг өгсөн байна. Мөн 34-өөс доош насныхны хувьд өөрт тохиолдож болох эрсдэлээс сэргийлэхийн тулд гэсэн хариулт өгсөн хувь нь ахимаг насныхантай харьцуулахад өндөр байна. Дээрх тоо мэдээллээс харахад малчдын нийгмийн даатгалд хамрагдалтад гэр бүл, найз нөхөд, сумын нийгмийн даатгалын байцаагч гэх мэт оролцогч талуудын нөлөөлөл, туршлага төдийлөн хүчтэй биш байгаа нь харагдаж байна.


НДШ огт төлөхгүй байгаа малчдын хувьд шалтгаан нь гол төлөв эдийн засгийн боломжтой холбоотой байна. Нэн ялангуяа, НД-н шимтгэлийг хэт өндөр (24%), НД-аас өөр чухал хэрэгцээ байдаг (13%) гэх мэт хариултауд хамгийн нийтлэг сонгогдсон байна. Харин НД-н тогтолцоо болон бусад үйлчилгээтэй холбоотой шалтгааныг дурдсан хувь маш бага байна. Энэ нь нэг талаас зайлшгүй төлөх НДШ-н хэмжээ болон иргэдийн санхүүгийн боломж нийцэхгүй байгааг харуулж байж болох юм.

Хүснэгт 21. НДС-д хамрагдахаа больсон шалтгаан (олон сонголттой), насны бүлгээр

	15-24	25-34	35-44	45-54	Total (n=1415)
НДС-ийн шимтгэл хэт үнэтэй	16%	17%	29%	26%	24%
Надад өөр илүү чухал хэрэгцээ байдаг	6%	10%	15%	14%	13%
Би тогтолцоонд нь итгэдэггүй	0%	4%	4%	3%	4%
Тэтгэвэр, тэтгэмжийн мөнгө хэт бага байдаг	0%	3%	4%	4%	4%
Төлбөрийн арга, систем хязгаарлагдмал	3%	2%	2%	1%	2%
Хөтөлбөр шаардлагагүй	6%	1%	1%	2%	2%
Надад шаардлагатай бичиг баримт байхгүй	0%	0%	1%	1%	1%
Надад бүтэн даатгалын багцыг авах ёстой гэдэг нь таалагддаггүй	0%	1%	1%	0%	1%
Би хувийн даатгалд даатгуулсан	0%	0%	1%	0%	0%

НДШ огт төлж байгаагүй малчдын хувьд харьцангуй олон шалтгаанаас үүдэлтэй байна. Нийтлэг дурдагдаж байгаа шалтгаан нь малчдын санхүүгийн боломж болон мэдлэг, мэдээлэлгүй байдал юм. Харин малчдын байршил, шимтгэл төлөх процесс, баримт бичгийн бүрдүүлэлт зэрэг нь төдийлөн бэрхшээлд тооцогдохгүй байна.

Дүрс 43. НДС-д хамрагдаагүй шалтгаан




НДШ огт төлж байгаагүй малчдын хувьд хүн ам зүйн байдал болон нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс хамаарсан ялгаа ажиглагдахгүй байна. Харин өгөгдсөн хариултаас гадна нэмэлт шалтгаан дурдсан малчдын хувьд 'НД-н талаар мэдээлэл хомс', 'өвлөгдөхгүй учраас', 'төлөх сонирхолгүй', 'санхүүгийн боломжгүй', 'хуримтлал үүсгэх нь илүү ашигтай', гэх мэт онцлог хариултуудыг дурджээ.

НД-д нөхөн даатгуулах тухай хуулийн давуу талыг ашиглан өмнөх хугацааны шимтгэлээ нөхөн төлсөн гурван малчин тутмын нэг нь НДШ-ээ төлөхөө зогсоож байна. Нийт малчдын 17 хувь нь хуулийн давуу талыг ашиглан НДШ-ээ нөхөн төлсөн байна. Нөхөн төлсөн малчдын талаас илүү хувь нь (62%) одоо НДШ-ээ үргэлжлүүлэн төлж байгаа бол бараг гуравны нэг нь одоогоор НДШ-ээ төлөхгүй байна. Энэ нь малчдын дунд хуулийн үр шимийг хүртсэн ч, цаашид тогтвортой төлөхгүй, үр ашиггүй байдалд хүргэж байгаа тохиолдлууд байгааг харуулж байна.

Дүрс 44. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, одоогийн хамрагдалтын байдлаар




Дүрс 45. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, насны ангилалаар



Мөн хуулийн онцлогтой холбоотойгоор, 35 болон түүнээс дээш насны малчдын хувьд өмнөх хугацааны НД-н шимтгэлээ нөхөн төлсөн хувь өндөр байна. НДШ-н төлөлтөд малчдын байршил, хүйс, боловсролын түвшин төдийлөн нөлөөгүй байна.

НДШ-г нөхөн төлөх хуулийн давуу талыг эдийн засгийн чадамжгүй иргэдээс илүүтэйгээр өндөр орлоготой, хадгаламжтай малчид илүү их хүртэж байна. Тухайлбал, өрхийн орлого өндөр, өрхдөө хадгаламж үүсгэх боломжтой малчдын хувьд уг хуулийн дагуу НДШ-ээ нөхөн төлсөн хувь өндөр байна.

Дүрс 46. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, өрхийн орлогоор



Дүрс 47. Хуулийн давуу талыг ашигласан малчдын хувь, хадгаламжийн байдлаар



Тухайлбал, 20 хүртэлх сая төгрөгийн орлоготой өрхийн малчдын 18 хүртэлх хувь нь НДШ-ээ нөхөн төлсөн бол 20 болон түүнээс дээш сая төгрөгийн жилийн орлоготой өрхийн малчдын 20 болон түүнээс дээш хувь нь НДШ-г нөхөн төлсөн байна. Мөн өрхдөө хадгаламж үүсгэх боломжтой байдаг гэж хариулсан малчдын дунд НДШ-ээ нөхөн төлсөн хувь харьцангуй өндөр байна.

Судалгаагаар малчид ирээдүйд тэтгэвэр авах сонирхол өндөр байгаа ч, малчдын дунд НДШ төлж буй хувь маш бага байна. Нийт малчдын 81 хувь нь ирээдүйд тэтгэвэр авахаар сонирхож, төлөвлөж байна. Нэн ялангуяа, эмэгтэй, ахимаг насны малчдын хувьд энэ сонирхол илүү өндөр байна. Амьдарч буй байршил, боловсролын түвшин, орлогын түвшний ялгаатай байдал төдийлөн нөлөөлөхөөргүй байгаа бөгөөд сонирхол нь жигд өндөр байна.


НД-д хамрагдахаар сонирхож буй малчдын 44 хувь нь НДШ төлж байгаа бол төдийлөн сонирхол бага малчдын 18 хувь нь НДШ төлж байна. Энэ нь нэг талаас НДШ төлөхгүй байгаа иргэдийн хувьд ирээдүйд тэтгэвэр авах төлөвлөгөөгүй малчид байгаа нь малчид санхүүгийн боломжгүй, нөгөө талаас НДШ-г нөхөн төлөх хуулийн давуу талыг ашиглахыг хүсэж буй малчид нэлээдгүй байж болохыг харуулж байна.

Малчдад нийгмийн даатгалын тухай мэдлэг олгох, санал болгох ажил дутмаг байгаа бөгөөд зөвхөн гэр бүлийн гишүүд нэгэндээ зөвлөх байдал нийтлэг байна. Нийт малчдын 40 орчим хувьд өмнө нь хэн нэгэн НД-д хамрагдахыг санал болгож байжээ. Ялангуяа, сумын төв болон хөдөөгийн малчдын дунд өмнө нь хэн нэгний санал, зөвлөгөөг авч байсан гэх хувь илүү өндөр байна.

Дүрс 48. Хэн нэгэн таны нийгмийн даатгалд хамрагдах тухай санал болгож байсан уу?



Дүрс 49. Хэн нэгэн таны нийгмийн даатгалд хамрагдах тухай санал болгож байсан уу?, байршлаар



Судалгаанд хамрагдсан малчдын 56 хувь нь НДШ-ээ төлж буй өөр бусад хүмүүсийг мэднэ гэж хариулжээ. Гэхдээ малчдын бараг тал хувьд нь НД-д хамрагдах тухай хэн нэгэн надад зөвлөөгүй, санал болгоогүй гэсэн хариулт өгснөөс үзвэл НД-ын байгууллагаас малчдад хүрч очих ажил дутмаг байгааг харуулж байна.

5.4. Эрсдэл, цаг хугацаа, итгэлцэл мөн аливаа зүйлийн үндсэн шалтгааныг үзэх хувь хүний ойлголт

Хувь хүний сонголт болон нийгмийн даатгалын зан үйлийн хоорондох харилцааны таамаглалд хариулт өгөх зорилгоор асуумжид эрсдэлээс зайлсхийлт, цаг хугацааны хөнгөлөлт (аливаа үр өгөөжийг цаг хугацаагаар хэмжих¹⁴ болон итгэлцлийг хэмжих гурван асуултыг оруулсан. Эдгээр асуултыг оруулсан өөр нэг үндэслэл нь малчдын сонголттой холбоотой бусад хүчин зүйлсийн харилцан хамаарлын үр нөлөөг тодорхойлох хяналтын хувьсагчдыг бий болгох явдал юм. Асуултуудыг эрсдэл ба цаг хугацааны сонголт, эерэг, сөрөг харилцан үйлчлэл, өгөөмөр сэтгэл, итгэлцэл зэрэг мэдээллийг агуулсан олон улсын өгөгдлийн бааз болох "Олон улсын сонголтын судалгаа" (ОУСС)-аас авсан (Фалк нар, 2018). Одоогоор Монгол Улс энэ мэдээллийн баазад ороогүй байна.

Өгөгдөл цуглуулахад компьютерын тусламжтай утсаар ярилцлага хийх аргыг (КТУЯХ) ашигласан бөгөөд КТУЯХ ярилцлагын цаг хугацаа, танин мэдэхүйн ачааллыг хөнгөвчлөх үүднээс ОУСС-ын асуултуудыг богиносгосон. Иймд энэ хэсгийн үр дүн нь зөвхөн Монгол Улсын малчдын түүврээр хязгаарлагдсан тул ОУСС-ын үр дүнтэй харьцуулагдах боломжгүй юм.

Эрсдэл, цаг хугацааны хөнгөлөлт (ирээдүйн үр дүнг өнөөгийн үр дүнгээс бага гэж үзэх) болон хүмүүсийн итгэлцэл гэсэн 3 үзүүлэлтэд хандах хандлагуудыг Ликертийн хэмжээс (1-10)-ээр хэмжсэн. Эрсдэлд хандах дундаж хандлага нь 4.92, стандарт хазайлт нь 3.0 байна. Цаг хугацааны хөнгөлөлт (аливаа үр өгөөжийг цаг хугацаагаар хэмжих)-д хандах хандлага нь дунджаар 5.64, стандарт хазайлт 3.38 байна.

¹⁴ Time discounting буюу цаг хугацааны хөнгөлөлт гэдгийг зан үйлийн эдийн засагт аливаа урамшуулал (мөнгө эсвэл бараа гэх мэт)-ын үнэлгээнд цаг хугацаанаас хамааран гарах зөрүүг ойлгоно.

Итгэлцэлд хандах дундаж хандлага нь 5.04, стандарт хэлбэлзэл 3.13 байна (Хүснэгт 14-ийг үзнэ үү). Ерөнхийдөө эдгээр дунджууд нь төв утга руугаа төвлөрсөн байгаа боловч хамгийн бага ба их утгууд руу мэдэгдэхүйц тархацтай байна.

Хүснэгт 22. Эрсдэл, цаг хугацааны хөнгөлөлт, итгэлцэлд хандах хандлага, хувиар

Хандлага	Дундаж	Стандарт хэлбэлзэл	Хамгийн бага	Хамгийн их
Эрсдэлд хандах хандлага	4.92	3.00	1.00	10.00
Цаг хугацаанд хандах хандлага	5.64	3.38	1.00	10.00
Итгэлцэлд хандах хандлага	5.04	3.13	1.00	10.00
Ажиглалт				4000

Тайлбар: Дунджийн ялгааны ач холбогдлын түвшнийг *t* тест (дундаж-харьцуулалтын тест) дээр үндэслэсэн бөгөөд "****" нь *p*-value <= 0.01, "***" нь *p*-value <= 0.05, ба "**" нь *p*-value <= 0.1

Эх сурвалж: Өөрсдийн тооцоолол

Асуумжид оролцсон эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол эрсдэлээс зайлсхийх хандлага нь хамаагүй илүү байна. Харин эсрэгээрээ эрэгтэйчүүд бусдад илүү итгэл хүлээлгэхүйц байр суурьтай байна. Судалгаанд оролцогчдын цаг хугацаанд хандах хандлага нь хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй байна. Насны хувьд аливаа хандлагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй байна. Ахмадууд залуу малчдыг бодвол бусдад илүү итгэл хүлээлгэдэг ба эрсдэлээс зайлсхийх нь арай бага байна. **(Error! Reference source not found.**-г үзнэ үү).

Боловсролын түшингээр нь ангилсан хандлагын хувьд бага боловсролтой малчид эрсдэлээс хамгийн их зайлсхийдэг ба ирээдүйд илүү их ашиг тус хүртэхийн тулд өнөөдөр ямар нэг зүйлээ алдах эрмэлзэл бага байна. Боловсролын түвшин өндөртэй малчдын хувьд илүү алсын хараатай байж өнөөдөр ямар нэг зүйлээс татгалзахад бэлэн боловч тэдний бусдад итгэх итгэл нь хамгийн бага байна.

Нийгмийн даатгалд даатгуулсан малчид цаг хугацааны хөнгөлөлтөд эергээр хандах хандлага өндөр байгаа нь гайхахаар зүйл биш юм. Гэсэн хэдий ч нийгмийн даатгалд хамрагдсан малчид даатгалд хамрагдаагүй малчидтай харьцуулахад эрсдэлтэй алхам хийхэд илүү бэлэн байна. Энэ үр дүн нь эрсдэлээс зайлсхийлт (эрсдэлийн аверз) нь даатгалд хамрагдалтыг таамаглах хувьсагчийн үүрэг гүйцэтгэнэ гэсэн таамаглалтай зөрчилдөж буй бөгөөд даатгагдсан малчид даатгалтай учраас эрсдэлтэй алхам хийх хандлага ихтэй болохыг харуулж байна. Үүний нэгэн адил эрүүл мэндийн даатгалд хамрагдсан малчид даатгалгүй малчдаас илүү эрсдэлтэй алхам хийх хандлагатай байна.

Хүснэгт 23. Эрсдэл, цаг хугацаа (аливаа үр өгөөжийг цаг хугацаагаар хэмжих) болон итгэлцэлд хандах хандлага, тодорхойлох статистик, хувиар

n=4000		Эрсдэл	Цаг хугацаа	Итгэлцэл
Оролцогчдын хүйс	Эмэгтэй	4.77***	5.66	4.69***
	Эрэгтэй	5.05***	5.62	5.34***
Нас (ангилал 10 жилээр)	15-25	5.07	5.72	4.97
	26-35	5.00	5.64	4.99
	36-45	4.82**	5.69	4.94*
	46-55	4.97	5.52	5.31***
Өрхийн тэргүүн эсвэл түүнтэй харилцаа холбоо	Өрхийн тэргүүн	5.00	5.60	5.30***
	Эхнэр/нөхөр	4.72***	5.70	4.72***
	Бусад хамаатан	5.41***	5.61	4.83
Гэрлэлтийн байдал	Гэрлэж байгаагүй	5.25**	5.54	4.94
	Гэрлэсэн (гэрлэлтийн гэрчилгээтэй)	4.92	5.66	5.07

	Хамтран амьдрагчтай	4.73	5.31	4.85
	Салсан/тусдаа амьдардаг	4.53	6.10	4.86
	Бэлэвсэн	4.08**	5.63	4.98
Боловсрол/мэргэшлийн хамгийн дээд түвшин	Байхгүй	4.65	5.25	5.05
	Бага	5.35***	5.17***	5.25
	Бүрэн бус дунд	4.95	5.46**	5.30***
	Бүрэн дунд	4.79***	5.75**	4.97
	Тусгай дунд	5.04	5.43	4.79
	Дээд	5.16	6.23***	4.60***
Хүүхдийн тоо	1 хүүхэд	5.06	5.72	5.06
	2-3 хүүхэд	4.86	5.65	5.02
	4-5 хүүхэд	4.90	5.60	5.09
	6+ хүүхэд	5.14	5.18	5.54
Малын даатгал	Даатгуулсан	5.63	5.02	4.85
	Даатгуулаагүй	5.66	5.09	4.96
Нийгмийн даатгал	Даатгуулсан	5.01**	5.44***	5.09
	Даатгуулаагүй	4.80**	4.96***	4.96
Эрүүл мэндийн даатгал	Даатгуулсан	5.11***	5.56	5.1*
	Даатгуулаагүй	4.83***	5.68	4.99*
Нийт дундаж		4.92	5.64	5.04

Тайлбар : Дунджийн ялгааны ач холбогдлын түвшнийг *t* тест (дундаж-харьцуулалтын тест) дээр үндэслэсэн бөгөөд "****" нь *p*-value <= 0.01, "***" нь *p*-value <= 0.05, ба "*" нь *p*-value <= 0.1

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

5.5. Нийгмийн даатгалд хамрагдах болон хамрагдахгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлс

Нийгмийн даатгалд хамрагдах болон хамрагдахгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлсийг тааварлахын тулд хоёртын (binary) хоёр загварыг тодорхойлсон (**Error! Reference source not found.**-г үзнэ үү). Загвар 1 нь нийгмийн даатгалын гишүүнчлэлтэй хамааралтай байж болох тайлбарлан хувьсагчдыг багтаасан. Тус загварт өрхийн баялаг (өрхийн нэг хүнд ногдох орлогын квинтил), малын даатгал, азад найдах байдал¹⁵, эрсдэлд хандах хандлага, цаг хугацаанд хандах хандлага, итгэлцэлд хандах хандлага, шийдвэр гаргахдаа хамгийн их зөвшилцдөг хүн, даатгалд хамрагдсан өөр малчдыг таньдаг эсэх, интернэт холболт зэргийг авч үзсэн. Загвар 2-ын хувьд малчны хүн ам зүйн байдал (хүйс, нас, боловсрол, өрхийн гишүүдийн тоо) болон аймгийг хяналтын хувьсагчаар авсан. Загваруудыг логистик регрессийн аргаар тодорхойлсон бөгөөд хамааран хувьсагч нь нийгмийн даатгалын санд хамрагдах байдлыг илэрхийлнэ (0 "Үгүй", 1 "Тийм").

Нэг өрхөд ногдох орлогын түвшин өндөр байх нь даатгалд хамрагдалттай өндөр эерэг хамааралтай болохыг үр дүн харуулж байна. Малын даатгалд хамрагдсан малчид нийгмийн даатгалд хамрагдах магадлал илүү өндөр байна. Цаг хугацааны сонголт мөн нийгмийн даатгалд хамрагдалтад тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Ирээдүйн ашиг тусын тулд өнөөдөр ямар нэг зүйлээ алдахад бэлэн байх нь даатгалд хамрагдалтад ач холбогдолтой, эерэг таамаглах хүчин зүйл байна. Нийгмийн хүрээлэл дотроо даатгагдсан малчдыг таньдаг байх нь даатгалд хамрагдах магадлалыг 1.9 дахин нэмэгдүүлдэг байна.

Хяналтын хувьсагчдын хувьд хүйс, нас, боловсрол, бүс нутаг нь даатгалд хамрагдалттай мэдэгдэхүйц уялдаатай байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд 1.43 дахин хамрагдах

¹⁵ Locus of control - Аливаа зүйлийн үндсэн шалтгааныг үзэх хувь хүний ойлголт буюу азад эсвэл өөртөө найдах хувь хүний хандлага.

магадлалтай байгаа бол нас ахих жил тутамд хамрагдалт 1.06 дахин их байна. Боловсролын түвшин ерөнхийдөө хамрагдалтад нөлөөлөхгүй байгаа хэдий ч хамгийн өндөр боловсролтой малчдын хамрагдалт нь боловсролгүй малчдынхаас 3.2 дахин их байна.

Түүвэрт хамрагдсан найман аймгийн ач холбогдлын түвшнийг логистик загварт суурь болгож авсан аймаг болох Баян-Өлгий аймагтай харьцуулна. Мөн Баян-Өлгий аймаг нь даатгалд хамгийн бага буюу 22.6%-ийн хамрагдалттай аймаг юм. Тиймээс Хөвсгөл, Төв аймгаас бусад аймгуудын коэффициентууд нь ач холбогдолтой ба 1-ээс их байна (хамрагдалтын магадлал нэмэгдсэн). Хөвсгөл, Төв аймгийн хувьд хамрагдалтын түвшин нь харгалзан 31.2% ба 33.6% байна. Энэ хоёр аймгийн магадлалын харьцаа нь ач холбогдол бага байна. Тиймээс эдгээр аймгуудын малчид нь Баян-Өлгий аймгийг хяналтын ковариаци (covariates)-аар авсантай адил хамрагдалттай байхаар байна.

Хүснэгт 24. НДС-ийн гишүүнчлэлийн хоёртын регрессийн загварууд, магадлалын харьцаан дахь коэффициентууд.

Хувьсагчид	Загвар 1	Загвар 2
Амьжиргаагаа залгуулах (1=Тийм)	1.233*	1.294**
Малын даатгалтай	1.557***	1.447***
Аливаа зүйлийн үндсэн шалтгааныг үзэх хувь хүний ойлголт (1-дотоод/5-хөндлөнгийн)	0.871*	0.886
Эрсдэлд хандах хандлага (1-10)	0.976*	0.991
Цаг хугацаанд хандах хандлага (1-10)	1.046***	1.032**
Бусдад итгэх итгэл (1-10)	0.985	0.984
НД-д хамрагдсан хүмүүсийг таньдаг (1=Тийм)	1.685***	1.604***
Интернет хэрэглээ (1=Тийм)		1.178*
Хүйс (эрэгтэй=1)		0.735***
Нас (жил)		1.058***
Боловсрол		
Боловсролгүй		(суурь)
Бага		1.150
Бүрэн бус дунд		1.417
Бүрэн дунд		1.487
Тусгай дунд		1.503
Дээд		3.376***
Өрхийн гишүүдийн тоо		1.037
Аймаг		
Баян-Өлгий		(суурь)
Завхан		2.439***
Өвөрхангай		2.563***
Хөвсгөл		1.262
Баянхонгор		2.444***
Төв		1.359
Өмнөговь		1.992***
Сүхбаатар		2.202***
Тогтмол	0.455***	0.018***
N	4000	4000

Тайлбар : Ач холбогдол "****" нь $p\text{-value} \leq 0.01$, "***" нь $p\text{-value} \leq 0.05$, ба "*" нь $p\text{-value} \leq 0.1$
Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгал хоорондоо уялдаа холбоотой байдаг тул (**Error! Reference source not found.**-г үзнэ үү) тэдгээрийн загварууд (Хүснэгт 24-г үзнэ үү) нь ойролцоо үр дүнг харуулж байна. Малын даатгал нь нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалтай нягт уялдаа холбоогүй. Нийгэм, эрүүл мэнд, малын даатгалд хамрагдах магадлалыг гурван тусдаа логистик регрессийн загвар (Хавсралт А)-аар урьдчилан таамаглав. Эдгээр 3 тооцооллын зорилго нь өөр өөр даатгалын тогтолцоонд хамрагдах сонирхлыг тооцоход ижил төрлийн таамаглан хувьсагчид ижил үйлчилж буй эсэхийг шалгах явдал юм.

Хүснэгт 25. Мал, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдах хос шугаман корреляцийн матриц

	Малын даатгал	Эрүүл мэндийн даатгал	Нийгмийн даатгал
Малын даатгал	1		
Эрүүл мэндийн даатгал	0.1394	1	
Нийгмийн даатгал	0.1719	0.5103	1

Тайлбар : Шугаман корреляцийн коэффициент нь Rho

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Дээрх судалгаанаас дүгнэхэд даатгалын хамрагдалтад нөлөөлж буй нийгэм, хүн ам зүйн гол хүчин зүйлс нь амьжиргаагаа залгуулах чадвар, малчдын нийгмийн сүлжээ, боловсрол, хүйс, нас, боловсролын түвшин, аймаг байна. Судалгаанд хамрагдагсдын 61.4% нь НДС-д хамрагдаагүй хэвээр байгаа бол 80% нь тэтгэвэрт гарахад хуримтлал үүсгэх нь чухал эсвэл маш чухал гэж хариулжээ. Мөн тэтгэвэрт гарахын тулд хуримтлал үүсгэх нь чухал эсвэл маш чухал гэж хариулсан хүмүүсийн 50 орчим хувь нь НДС-д хамрагдаагүй, өөр хэлбэрээр тэтгэвэрт гарах аливаа хуримтлал үүсгээгүй байна. Дараагийн хэсэгт малчид одоогоор НДС-д хамрагдаагүй гол шалтгаанууд болон НДС-д шимтгэл төлж эхлэх эрмэлзэл нь ямар хүчин зүйлээс шалтгаалж өндөр байж болохыг тодруулахад чиглэв.

5.6. Шийдвэр гаргах туршилт

Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь малчдад хүртээмжтэй мөн ээлтэй гэж үзэж болохоор бөгөөд 1994 оноос хойш үйлчилж эхэлжээ. Гэсэн хэдий ч нийт малчдын 40 хүрэхгүй хувь нь НДС-д шимтгэл төлж байгаа нь тааварлашгүй явдал юм. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтай холбоотой Чеминий (2018) хийсэн туршилтаас харахад малчдад чиглэсэн ээлтэй бодлого байгаа хэдий ч мэдээллийн дутмаг байдал, гүйлгээний зардал, зээлийн хязгаарлалт зэрэг нь хамрагдалт муу байгаагийн гол тайлбар болох ажээ. Эдгээр хүчин зүйлс дээр нэмээд малчид нийгмийн хамгааллын байгууллагуудад хэт нэг талыг барьсан хандлагатай буюу тухайн байгууллага үүрэг амлалтаа биелүүлнэ гэдэгт итгэх итгэл хангалтгүй (жишээ нь, өмнөх шимтгэлийн татаасыг 2022 онд дуусгавар болгох эсвэл сайн дурын тогтолцоог албан тогтолцоонд шилжүүлэх гэх мэт) байж болзошгүй хэмээн бид таамаглаж байна. НДС-д хамрагдсанаар гарах үр ашгийг таниулах арга хэлбэрийг өөрчилснөөр малчдын НДС-д хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжтой эсэхийг турших үүднээс үр ашиг-алдагдлын тэгш хэмийн үр нөлөөн дээр суурилсан туршилтыг хийв. Энэхүү туршилтын хүрээнд даатгалд хамрагдаагүй малчдыг амьдралын мөчлөгт тулгарах эрсдэлд хандах хандлагатай холбоотой, нэн ялангуяа тэтгэвэр, тахир дутуугийн асуудлыг хөндсөн янз бүрийн мэдээллүүдээр хангасан (informational nudges). Туршилт нь нийгэм-хүн ам зүй, зан үйл, мэдээллийн хувьсагчдыг ашиглан нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байгаа шалтгааныг тайлбарлах зорилготой юм.

Өгөгдөл цуглуулах судалгааны туршилтын хүрээнд бид судалгаанд оролцогчдын нийгмийн даатгал төлөх эрмэлзлийг *шийдвэр гаргах туршилт (framing experiment)*-аар шалгав. Атзмүллер, Штайнер

(2010) ба Чемин (2008) нарын судалгаанд дурдсаны дагуу бид бүх судалгаанд оролцогчдод эрсдэлийн нийтлэг таамаг хувилбаруудыг танилцуулж, дараа нь өөр өөр хувилбаруудыг санамсаргүй байдлаар танилцуулсан.

Түүврийг дөрвөн бүлэгт хуваасны үндсэн дээр *шийдвэр гаргах туршилтыг* боловсруулсан: (1) Туршилт 1, (2) Туршилт 2, (3) Идэвхтэй хяналт, (4) Плацебо. Туршилтын эхний бүлэг (эрсдэл эрэлхийлэх зан үйл) нь даатгалын үр өгөөжийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал байх нь хамрагдалтад хэрхэн нөлөөлж болохыг судалсан. Ялангуяа эхний бүлгийн туршилт нь даатгалд хамрагдахад ямар ашиг тустай болохыг тайлбарлахгүйгээр төлөх шаардлагатай шимтгэлийн талаар тайлбарлаж өгсөн. Хоёрдох туршилтын бүлэг нь эрсдэлээс зайлсхийх зан үйлийг бий болгох буюу оролцогчдод шимтгэлтэй холбоотой аливаа шаардлагын талаар мэдээлэл өгөлгүйгээр даатгалд хамрагдахын ашиг тусын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Гурав дахь бүлэг нь оролцогчдыг мэдээллийн бүрэн багцаар хангаж өгсөн. Туршилтын энэхүү гурав дахь бүлэг нь хамгийн бодитой, нээлттэй сценарын хувьд шимтгэл төлөх эрмэлзлийг (ШТЭ) бий болгох оролцогчдын зан үйлийг хянах зорилготой юм. Эцэст нь нэмэлт мэдээлэлгүй плацебо бүлэг юм. Өөрсдөд нь хуваарилагдсан сценарыг сонссоны дараа судалгаанд оролцогчдоос нийгмийн даатгалын тогтолцоонд хувь нэмрээ оруулах хүсэлтэй эсэхийг тодруулж асуусан ба, үгүй бол яагаад гэдэг асуулт тавьсан.

Дөрвөн бүлгийн зөвхөн даатгалд хамрагдаагүй хүмүүсийн хүрээнд хязгаарласан байдлаар шинжилгээг хийхэд НДС-ийн гишүүнчлэлд хамрагдах ШТЭ их байгааг харж болно (Хүснэгт 26-г үзнэ үү). Туршилтын дөрвөн бүлгийн дундаж ШТЭ нь 71.7% ба шийдвэр гаргаагүй оролцогчид 9.7% байна. Шимтгэл төлөх хүсэлгүй гэж хариулсан хүмүүс түүврийн 18.6%-ийг эзэлж байна. Гэсэн хэдий ч, асуумж нь нийгмийн даатгалын асуудалд ихээхэн анхаарал хандуулж байсан тул оролцогчдын зүгээс хэт нэг талыг барьсан хариулт өгсөн байж болох бөгөөд энэ нь НДС-ын хувьд ямар нэгэн үүрэг амлалт хүлээсэн гэсэн үг биш юм.

Хүснэгт 26. Даатгуулагчдын шимтгэл төлөх эрмэлзэл, туршилтын бүлгийн хувиар

	Шийдвэр гаргах туршилтын бүлэг				
	1	2	3	4	Нийт
Тийм	66.6	71.8	72.5	76.5	71.7
Үгүй	20.7	18.6	17.4	17.6	18.6
Мэдэхгүй	12.7	9.6	10.1	5.9	9.7
Оролцогчид	667	613	585	592	2,457

Тайлбар : Шугаман корреляцийн коэффициент нь Rho

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Санамсаргүй туршилтын хувьд хамгийн чухал төсөөлөл бол оролцогчдыг туршилтын бүлгүүдэд санамсаргүй байдлаар хуваарилах явдал юм. Туршилтын бүлгүүдийн хоорондын ковариациудын тэнцвэрийг хянах замаар энэ төсөөллийг баталгаажуулж болдог.

Туршилтын бүлгүүдийг тэнцвэржүүлэлтийг шалгасныг Хавсралт В-ээс үзэж болно. Дөрвөн бүлэгт тодорхойлсон ковариациуд нь тэнцвэржүүлэлтийн шинж чанаруудыг агуулаагүй байсан тул санамсаргүй хуваарилах үйл явцыг 0.05 давтамж бүхий kernel нийцүүлэх алгоритмыг ашиглан, хандлагын оноог нийцүүлэх (propensity score matching, PSM) аргаар гүйцэтгэсэн. Нийцүүлсний дараа туршилтын дундаж нөлөөг (ТДН) үнэлэх боломжтой. Уг үйл явцыг хосолсон байдлаар буюу хос бүлэг бүрээр ТДН-г шалгасан гэсэн үг юм. Ихэнх бүлгүүд шимтгэлээ төлж эхлэх магадлалын хувьд ач холбогдол бүхий нөлөөтэй байна (Хүснэгт 6-г үзнэ үү). Гэсэн хэдий ч хамгийн хамаарал бүхий үр дүн бол плацебо бүлгийн (Т4) хувьд 1-р Туршилт (Т1), 2-р Туршилт (Т2) болон Идэвхтэй

хяналт (Т3)-ын бүлгүүдээс хамаагүй өндөр ШТЭ-тэй байна. Туршилтын бүлгүүдийн хувьд ШТЭ байх магадлалын ач холбогдолтой байдал болон зөрүү нь дараах зүйлсийг санал болгож байна:

- Мэдээллийг зөвхөн нийгмийн даатгалын шимтгэлийн хүрээнд хязгаарлах (Т1) нь даатгалын үр өгөөжийн хүрээнд мэдээллийг хязгаарлахтай (Т2), шимтгэл, үр өгөөжтэй холбоотой бүрэн мэдээллийг өгсөнтэй (Т3) эсвэл ямар ч мэдээлэл өгөхгүй байгаа (Т4)-тай харьцуулахад бага ШТЭ-ийн магадлалд хүргэж байна.
- Мэдээллийг зөвхөн үр өгөөжийн хүрээнд хязгаарлах (Т2) нь шимтгэл, үр өгөөжтэй холбоотой бүрэн мэдээллийг өгсөнтэй (Т3) ижил түвшний ШТЭ-ийн магадлалыг үзүүлж буй боловч ямар ч мэдээлэл өгөхгүй байхаас бага (Т4) ШТЭ-ийн магадлалыг харуулж байна.
- Шимтгэл, үр өгөөжтэй холбоотой бүрэн мэдээллийг өгөх (Т3) нь ямар ч мэдээлэл өгөхгүй байснаас (Т4) бага ШТЭ-ийн магадлалыг үзүүлж байна.

Эдгээр үр дүн нь судалгаанд оролцогчдод өгсөн мэдээлэл нь хамрагдалтыг нэмэгдүүлэхэд бараг эсрэг нөлөө үзүүлж байгааг харуулж байгаа тул дараагийн догол мөрүүдэд судалгаанд оролцогчдын ШТЭ-ийг урьдчилан таамаглах боломжтой нэмэлт тайлбарлан хувьсагчдыг судаллаа.

Хүснэгт 27. Хандлагын оноог нийцүүлсний дараах хосолмол дундаж туршилтын үр нөлөө

Т(а)-ийг Т(б)-тэй харьцуулах нь	(а)	(б)	Ялгаа	С.А	T-stat	Ач холбогдол
Т1-ийг Т2-тэй харьцуулах нь	0.736	0.791	0.055	0.020	2.78	***
Т1-ийг Т3-тай харьцуулах нь	0.731	0.791	0.060	0.020	3.04	***
Т1-ийг Т4-тэй харьцуулах нь	0.732	0.826	0.094	0.019	4.92	***
Т2-ийг Т3-тай харьцуулах нь	0.791	0.791	0.000	0.019	0.02	-
Т2-ийг Т4-тэй харьцуулах нь	0.792	0.825	0.033	0.018	1.78	*
Т3-ийг Т4-тэй харьцуулах нь	0.788	0.825	0.037	0.018	2.05	**

Тайлбар : С.А стандарт алдаа. Ач холбогдол "****" нь $p\text{-value} \leq 0.01$, "****" нь $p\text{-value} \leq 0.05$, ба "*" нь $p\text{-value} \leq 0.1$. Т1 нь Туршилт 1, Т2 нь Туршилт 2, Т3 нь Идэвхтэй хяналт, Т4 нь плацебо бүлэг.

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Одоогоор хамрагдаагүй байгаа малчдын дунд НДС-д төлбөр төлөх хандлагыг тодорхойлох тайлбарлан хувьсагчдын урьдчилсан дүн шинжилгээг Хүснэгт 28-д үзүүлэв. Тайлбарлан хувьсагч бүрийн ач холбогдлыг хоёртын регрессийн загвараар доорх хэсэгт шалгаж үзэв.

Хүснэгт 28. Даатгуулаагүй хүмүүсийн шимтгэл төлөх эрмэлзэл, тайлбарлах хувьсагч, хувиар.

Хувьсагч	WTP %	
Нэг хүнд ногдох өрхийн орлогын квинтил	1	71.7
	2	70.3
	3	70.2
	4	74.1
	5	72.5
Өндөр насанд асрах хүн	Өөрөө	66.6
	Миний хүүхдүүд	72.9
	Миний хань	70.6
	Найзууд	74.1
	Улс	91.6
	Хэн ч биш	54.8
Чухал шийдвэр гаргахдаа хамгийн их зөвшилцдөг хүн	Бусад	74.7
	Эцэг эхтэйгээ	71.0
	Хань (эхнэр/нөхөр)	72.3

	Би өөрөө шийдвэр гаргадаг	63.0
	Эргэн тойрны малчидтайгаа зөвшилцдөг	79.3
	Би өөрийн харьяалагдах малчдын бүлгэм/хоршоо/холбоодын гишүүдтэй зөвшилцдөг	60.0
	Би орон нутгийн засаг дарга эсвэл төрийн албан тушаалтны тушаалыг дагаж мөрддөг	76.5
	Бусад	75.2
НДС-д даатгал төлөөгүй жилээ нөхөж даатгуулах боломжтой эсэх талаар мэдэх үү	Үгүй	68.3
	Тийм	76.5
НДС-д хувь нэмрээ оруулж буй бусад хүмүүсийг таньж мэдэх эсэх	Үгүй	67.6
	Тийм	75.6
Интернэт холболт	Үгүй	70.3
	Тийм	76.5
	Нийт	71.7

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Хоёртын регрессийн загварыг ШТЭ-ийн магадлалд нөлөөлж буй тайлбарлах хүчин зүйлсийн ач холбогдлыг үнэлэхэд ашигладаг. Хамааран хувьсагч нь туршилтын асуултыг асуусны дараа шимтгэл төлж эхлэхэд бэлэн байгаа эсэхийг тодорхойлдог. Хувьсагчийг хоёртын системээр кодлов (0 "Үгүй" ба "Мэдэхгүй", 1 "Тийм"). Ингэснээр уг загвар нь НДС-д гишүүнчлэлийн төлбөр төлөхөд бэлэн байх магадлалыг урьдчилан таамаглана гэсэн үг. Бие даасан тайлбарлан хувьсагчид (таамаглах хувьсагчид) нь туршилтын бүлэг, амьжиргаагаа залгуулах чадвар, өндөр насанд асрах хүнтэй эсэх, эрсдэл, цаг хугацаа, итгэлцэлд хандах хандлагууд, НД-ын байгууллагын чанар болон түүнд итгэх итгэл байна. Загварт мөн хяналтын хувьсагчдыг (давхар хөдөлмөр эрхэлдэг, өндөр боловсрол эзэмшсэн байдал, хүйс, нас, өрхийн гишүүдийн тоо, аймаг)-ыг багтаасан.

Уг загвар нь ярилцлага хийх үед НДС-д хамрагдаагүй оролцогчдоор хязгаарлагдсан. Тиймээс оролцогчдын тоо 2,457 байна. Хоёр загварыг нэг нь зөвхөн таамаглагч хувьсагчидтай байхаар, нөгөө нь таамаглагч болон хяналтын хувьсагчидтай байхаар тодорхойлсон (**Error! Reference source not found.**-г үзнэ үү). Коэффициентийг магадлалын харьцаагаар илэрхийлнэ.

Тооцоолсон үр дүн нь дараах зүйлсийг илэрхийлж байна:

- Хяналтын хувьсагчид (хүйс, нас, давхар хөдөлмөр эрхлэлт) нь тийм ч их ач холбогдолтой биш буюу **нийгэм-хүн ам зүйн шинж чанарын хувьд мэдэгдэхүйц ялгаа байхгүйг** харуулж байна.
- Аймгуудын хувьд мэдэгдэхүйц ялгаа байхгүй байгаа нь ШТЭ-д гаднын (экзоген) хүчин зүйлс нөлөөлдөг гэсэн таамаглалыг дэмжиж байна. Гэсэн хэдий ч Төв аймагт НДС-д ШТЭ өндөр байх магадлалын ач холбогдлын түвшин өндөр байна. Үүнийг тус аймгийн түвшинд хамрагдалттай холбоотой үр дүнтэй нэгтгэж үзэхэд **Төв аймагт даатгалд хамрагдахад орон нутгийн саад бэрхшээл байж болзошгүйг** илэрхийлж байна.
- Боловсролын түвшин нь ерөнхийдөө ШТЭ-д нөлөөлдөггүй ч боловсролын түвшин өндөртэй судалгаанд оролцогчид НДС-д хамрагдах магадлал илүү өндөр байна.
- **Амьжиргаагаа залгуулах чадвар нь ач холбогдолтой таамаглагч зүйл биш** бөгөөд энэ нь **Error! Reference source not found.**-ийн хамрагдалт бага байгаа нь санхүүгийн хязгаарлалтаас шалтгаална гэсэн таамаглалтай зөрчилдөж байна.

- Эрсдэл, **цаг хугацаа**, итгэлцэлд хандах хандлагууд нь **ач холбогдолтой урьдчилан таамаглагч зүйлс биш** бөгөөд энэ нь НД-д хамрагдах эсэх нь тухайн хүний дотоод хандлагаар, ялангуяа одоо цаг эсвэл ойрын ирээдүйг эергээр харах хандлагаар тодорхойлогддог гэсэн таамаглалтай зөрчилдөж байна.
- Хэдийгээр уг загвар нь даатгалд хамрагдаагүй малчдаар хязгаарлагдаж байгаа ч ШТЭ нь өндөр насанд төрийн хамгаалалтад орно гэсэн хүлээлттэй нягт уялдаатай болохыг харуулж байна. Энэхүү үр дүн нь **үнэ, хүртээмж, захиргааны саад бэрхшээл зэрэг гаднын бэрхшээлүүд хамрагдахад саад болж** байж магадгүйг илэрхийлж байна.
- НДС-ийн чанар, итгэлцлийн үнэлгээ нь маш өндөр ач холбогдолтой байна: **чанар, итгэлцэл нь өндөр түвшинтэй байвал ШТЭ-ийн магадлалыг** тус бүрийнх нь хувьд 1.08 дахин нэмэгдүүлэх боломжтой.
- **НДС нь өмнөх шимтгэлд татаас олгож санд нэгдэх сонголтыг санал болгодог гэдгийг мэддэг байх нь ШТЭ-ийн магадлалыг** мэдэгдэхүйцээр буюу 1.5 дахин нэмэгдүүлдэг.

Хүснэгт 29. НДС-д шимтгэл төлж эхлэх эрмэлзлийн логистик регрессийн загварууд, магадлалын харьцаагаар үр дүнг харуулав.

Хувьсагч	Загвар 3	Загвар 4
Туршилтын бүлэг		
Плацебо	(суурь)	(суурь)
T1 Эрсдэлийг эрэлхийлэх	0.601***	0.625***
T2 Эрсдэлээс зайлсхийх	0.757*	0.754*
T3 Идэвхтэй хяналт	0.789	0.797
Амьжиргаагаа залгуулах (1=Тийм)	1.121	1.091
Өндөр насанд асрах хүн		
Өөрөө	(суурь)	(суурь)
Миний хүүхдүүд	1.265	1.268
Миний хань	1.183	1.188
Найзууд	1.305	1.293
Улс	5.598***	5.718***
Хэн ч биш	0.756	0.782
Бусад	1.578	1.628
Эрсдэлд хандах хандлага (1-10)	0.972	0.978
Цаг хугацаанд хандах хандлага (1-10)	1.012	1.008
Бусдад итгэх итгэл (1-10)	0.991	0.997
НД-ийн системийн чанарын үнэлгээ	1.085***	1.086***
НДС-д итгэх итгэлийн үнэлгээ	1.081***	1.080***
НДС-д даатгал төлөөгүй жилээ нөхөж даатгуулах боломжтой эсэх талаар мэдэх үү	1.468***	1.532***
Давхар ажил		0.942
Боловсрол		
Байхгүй		(суурь)
Бага		0.764
Бүрэн бус дунд		0.829
Бүрэн дунд		0.897
Тусгай дунд		0.675
Дээд		0.767
Хүйс (эрэгтэй=1)		0.767**
Нас (жил)		0.995

Өрхийн гишүүдийн тоо		0.950
Аймаг		(суурь)
Баян-Өлгий		1.161
Завхан		1.131
Өвөрхангай		1.063
Хөвсгөл		1.003
Баянхонгор		1.599*
Төв		0.995
Өмнөговь		1.314
Сүхбаатар		1.568
Тогтмол	0.961	
N	2457	2457

Тайлбар : Ач холбогдол "****" нь $p\text{-value} \leq 0.01$, "***" нь $p\text{-value} \leq 0.05$, ба "*" нь $p\text{-value} \leq 0.1$

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Шимтгэл төлж эхлэх хүсэлгүй байгаа оролцогчид хоёр удаа хариулж болох олон сонголттой асуултад хариулж сонголтлоо нотлох боломжтой байсан. Эхний сонгосон гурван зүйлс нь "Нийгмийн даатгалын шимтгэл хэтэрхий үнэтэй" (21.4%), "Надад хэрэггүй" (21.0%), "Би хөтөлбөрийг ойлгодоггүй" (15.1%) байгааг Хүснэгт 30 **Error! Reference source not found.**-с үзнэ үү.

Хүснэгт 30. Шимтгэл төлж эхлэх эрмэлзэлгүй байгаа шалтгаан, хувиар

Шалтгаан	Эхний хариулт	Хоёр дахь хариулт
Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хувь хэт өндөр	21.4	6.0
Хөтөлбөр шаардлагагүй	21.0	10.5
Би хөтөлбөрийг ойлгодоггүй	15.1	8.2
Бусад	14.2	10.5
Би системд нь итгэдэггүй	9.2	9.7
Яаж бүртгүүлэхийг би мэдэхгүй	5.7	17.2
Бүртгэл, төлбөр болон нэхэмжлэх үйл явц нь хэт төвөгтэй	4.4	7.5
Би өөрийгөө авах эрхгүй гэж бодож байна	3.3	11.9
Надад өөр илүү чухал хэрэгцээ байдаг	3.1	11.2
Надад бүтэн даатгалын багцыг авах ёстой гэдэг нь таалагддаггүй	1.8	6.7
НДС-ийн оффис хэт хол байрладаг	0.4	0.8
Надад шаардлагатай бичиг баримт байхгүй	0.4	...
Би хувийн даатгалд даатгуулсан	0.2	...
Оролцогчид	458	134

Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Түүнчлэн төлбөр төлөх хүсэлтэй гэж мэдэгдсэнээр нь ангилан зөвхөн даатгалд хамрагдаагүй малчдын хүрээнд түүврийг хязгаарлаж малчид яагаад одоогоор шимтгэл төлөхгүй байгаад дүн шинжилгээ хийх боломжтой (Хүснэгт 31-ыг үзнэ үү). Даатгалд хамрагдаагүй малчдын 46.5% нь нийгмийн даатгалын шимтгэлийн түвшнээс шалтгаалж одоогоор хамрагдаагүй гэж мэдэгдсэн ч 75.6% нь төлж эхлэх хүсэлтэй байна. Эдгээрийн зөвхөн 48% нь "НДС нь санд нэгдэж, шимтгэл төлөөгүй жилүүдийн шимтгэлийг нөхөн төлөх боломжийг санал болгодог (*Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль*)" талаар мэддэг ажээ. Мөн малчдын 12.2% нь нээлттэй хариулттай асуултад хариулж, шимтгэл төлөхгүй байгаа гол шалтгаануудаа: *Би төлнө гэж бодож байна, Хэзээ ч төлж байгаагүй, Төлбөр төлнө гэж бодохгүй байгаа, Мэдэхгүй, Мэдээлэл хомс, Хөгшин биш эсвэл 21-с доош настай, Нийгмийн хамгааллын талаар ойлголтгүй, Ажлын байр байхгүй, Намайг ажлаас халсан учраас, Тогтмол орлогогүй* гэж тайлбарлав. Бусад гол шалтгаанууд нь хөтөлбөрүүдийн талаарх ойлголт дутмаг (11.7%) ба илүү чухал хэрэгцээ байгаа (10.4%) гэдгээр тайлбарлагдсан.

Хүснэгт 31. НДС-д одоогоор шимтгэл төлөхгүй байгаа гол шалтгаан, ШТЭ-ээр (мөр хувиар, Нийт багана хуваарилалтыг илэрхийлнэ)

Шалтгаан	ТТЭ-гүй	ТТЭ	Нийт
НДС-ийн шимтгэл хэт үнэтэй	24.5	75.6	46.5
Бусад	24.7	75.3	12.2
Би хөтөлбөрийг ойлгодоггүй	32.4	67.6	11.7
Надад өөр илүү чухал хэрэгцээ байдаг	29.3	70.7	10.4
Яаж бүртгүүлэхийг би мэдэхгүй	24.8	75.2	5.3
Тэтгэвэр, тэтгэмжийн мөнгө хэт бага байдаг	47.8	52.2	3.7
Би системд нь итгэдэггүй	51.6	48.4	2.5
Төлбөрийн арга, систем хязгаарлагдмал	25.5	74.5	1.9
Бүртгэл, төлбөр болон нэхэмжлэх үйл явц нь хэт төвөгтэй	34.2	65.9	1.7
Би өөрийгөө авах эрхгүй гэж бодож байна	38.5	61.5	1.6
Хөтөлбөр шаардлагагүй	54.3	45.7	1.4
НДС-ийн оффис хэт хол байрладаг	23.1	76.9	0.5
Надад шаардлагатай бичиг баримт байхгүй	16.7	83.3	0.5
Надад бүтэн даатгалын багцыг авах ёстой гэдэг нь таалагддаггүй	75.0	25.0	0.2
Нийт	696	1,760	2,456 (100%)

6. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЗӨВЛӨМЖ

6.1. Эрэлттэй холбоотой сорилтууд

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахад нөлөөлөх хүчин зүйлс тулгарч буй сорил бэрхшээлийг тодорхойлох зорилгоор малчин хүн амын төлөөллийн түүвэрт судалгаа явуулсан. Судалгааны явцад малчдыг нийгмийн хамгааллын тогтолцоонд анх удаа хамрагдах эсвэл үргэлжлүүлэн хамрагдахад саад болж буй ойлголт, зан үйл, хүртээмжтэй байдал, хэрэгцээ шаардлага, бэрхшээл, шалтгаануудын талаар мэдээлэл цуглуулан өргөн хүрээнд шинжилгээ хийж, дараах чиглэлээр мөрүүдэд гол дүгнэлтүүдийг нэгтгэн тоймлов.

6.1.1. Нийгмийн хамгааллын тогтолцоонд шимтгэл төлөхийн ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэг

Малчдын дийлэнх нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаар бүрэн ойлголтгүй байгаа нь даатгалын хамрагдалтад гол нөлөө үзүүлэх нэгдүгээр хүчин зүйл юм. Эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байх гол шалтгаануудын хувьд хүн ам зүйн бүлгүүдийн өгсөн нийтлэг хариулт бол эрүүл мэндийн даатгал тэдний хувьд чухал биш гэх хариулт байлаа. Нийгмийн даатгал түүний ач холбогдлын талаар ойлголт багатай байх нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байх эхний гурван шалтгааны хоёрт багтаж байна. Бодит байдал дээр “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох тухай хууль” (2012), “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль” (2017)-удын талаар ойлголттой байх нь шимтгэл төлж эхлэх магадлалыг ихээхэн нэмэгдүүлжээ. Нөгөөтээгүүр хүмүүсийн нас ахих тусам даатгалд ач холбогдол өгөх байдал, хамрагдалтын түвшин нэмэгдэхээс гадна хадгаламжид өндөр ач холбогдол өгч байгаа нь тийм ч гайхмаар зүйл биш юм. Даатгалын хамрагдалтад нөлөөлөл үзүүлэгч өөр нэгэн хүчин зүйл бол хүмүүсийн боловсролын түвшин юм. Боловсролын түвшин өндөр бол даатгалд хамрагдалт өндөр байх бөгөөд даатгалд хамрагдаагүй малчдын дунд зөвхөн өндөр боловсролтой малчид шимтгэл төлж эхлэх хүсэл сонирхлоо илэрхийлсэн байна.

6.1.2. Хандлага ба хүлээлт

Одоогийн байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй малчдын хувьд нийгмийн даатгалын санд итгэх итгэл сул байх, чанарыг нь муу гэж үзэх үзэл мэдэгдэхүйц бага байна. Харин шимтгэл төлж эхлэх гэж буй малчдын хувьд эд чанар, итгэл үнэмшил нэмэгдэж байна.

Малчдын дийлэнх нь өндөр насандаа гэр бүлийн гишүүдийн зүгээс буюу ялангуяа үр хүүхэд нь тэднийг асран хамгаална гэсэн хүлээлттэй байна. Эдгээр гэр бүлдээ найдаж буй малчдын даатгалд хамрагдалтын түвшин нь төр засгаас тэднийг дэмжинэ гэж боддог малчдынхаас хамаагүй бага байна. Үүнтэй адилаар, одоогоор даатгалд хамрагдаагүй байгаа малчдыг сонгон авч үзэхэд, тэдгээрээс төр засгийн дэмжлэгт найдаж буй малчдын дунд шимтгэл төлж эхлэх сонирхол нь өндөр байгаа нь харагдаж байна. Энэхүү үр дүн нь зарим тодорхой бүлгийн хувьд даатгалд хамрагдах эсэх нь нийлүүлэлттэй холбоотой бэрхшээл байж болзошгүйг илтгэж байна.

Цаашилбал, малчдын алс холын ирээдүйд гарах үр өгөөжийг илүүд үзэх хандлага (жишээ нь: урт хугацааны үр өгөөж бүхий хувилбаруудыг сонгох чадвар) нь нийгмийн даатгалд хамрагдахад эергээр нөлөөлдөг. Гэвч шимтгэл төлж эхлэх хүсэл эрмэлзэл нь цаг хугацааны сонголтоор тодорхойлогддоггүй байна.

6.1.3. Санхүүгийн чадавх

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын түвшин өндөр байх нь аль алиных нь хувьд өрхийн орлоготой эерэг хамааралтай. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөхгүй байх, мөн өнгөрсөн хугацаанд шимтгэлээ цуцалсныг тайлбарлах нэн тэргүүний хүчин зүйл бол өндөр өртөг юм. Гэсэн хэдий ч бусад бүх хүчин зүйлийг тогтмол гэж үзвэл амьжиргаагаа залгуулах чадвар нь НДС-д шимтгэл төлж эхлэх эрмэлзэлд нөлөөлөхгүй. Нэг үгээр хэлбэл санхүүгийн чадавх хамрагдалтын өнөөгийн түвшнийг тайлбарлаж чадах боловч даатгалд хамрагдаагүй байгаа хүмүүсийг даатгалд хамрагдахад саад болж байгаа цорын ганц зүйл биш гэсэн юм.

6.1.4. Газарзүйн байршил

Судалгаа явуулсан найман аймгаас Баян-Өлгий, Хөвсгөл, Төв аймгуудын хамрагдалтын түвшин харьцангуй доогуур байна. Сумын төвд амьдардаг малчдын хувьд аймгийн төв болон хөдөө орон нутгаас илүү хамрагдалттай байна. Төв аймагт шимтгэл төлж эхлэх хүсэл эрмэлзэл бусад аймгуудаас өндөр магадлалтай байна. Энэ нь тус аймагт даатгалд хамрагдахад орон нутгийн онцлогтой байж болзошгүй.

6.2. Нийлүүлэлт талын сорилтууд

Хууль эрх зүйн дүн шинжилгээ, оролцогч талуудын дүн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлагын үр дүнд үндэслэн дараах сул тал болон бэрхшээлүүдийг тодорхойллоо.

6.2.1. Малчдын нийгмийн даатгалд хамрагдахад хууль эрх зүйн орчинд тулгарч буй сорил бэрхшээлүүд

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн гэрээгүйгээр хөдөлмөр эрхэлж буй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, чөлөөт уран бүтээлчдийг нийгмийн даатгалд албан журмаар хамрагдахгүй байхыг зөвшөөрсөн.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Сайн дурын даатгуулагч (малчид) нь Тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ-ий даатгалыг багцаар нь сонгох ба аль нэгийг нь сонгох боломжгүй гэж заасан. Өөрөөр хэлбэл, сайн дураараа даатгуулах хүсэлтэй иргэд хөдөлмөр эрхэлдэггүй байсан ч ҮОМШӨ-ий даатгалд хамрагдах ёстой. Мөн энэхүү зүйлд “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад иргэн сайн дураар даатгуулж болно” гэж заасан нь албан журмаар даатгуулагч сайн дураар нэмэлт даатгал хийлгэх эрхийг хязгаарласан. Уг заалтын сул тал нь хөдөлмөрийн гэрээний хүрээнд бага цалинтай ажиллаж буй хүмүүс нэмэлт даатгалд хамрагдах боломжгүй гэсэн үг. Улмаар албан журмаар даатгагдсан бага орлоготой иргэн бага тэтгэвэр тогтоолгож насаараа ядуу амьдрах зохицуулалттай тулгарч байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж буй иргэд албан журмын даатгалд хамрагдаж тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авна хэмээн заасан байдаг. Хэрэв даатгуулагч үйлдвэрийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол "НДС-аас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай хууль"-иар тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох эрх үүснэ. Гэтэл энэ эрх нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйл түүнийг тайлбарласан Улсын Дээд Шүүхийн 2008 оны 47 дугаар тогтоолын 1.3-д зааснаар хязгаарлагдаж буй бөгөөд үүсч буй эрсдэлийг нөхөхгүй даатгалд албан журмаар даатгуулах нь утгагүй юм. Уг хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь даатгалын гэрээний эрх зүйг зөрчих давуу эрхийг даатгагчид олгосон.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1.4-т "нийгмийн даатгалын шимтгэл" гэдэг нь нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг" хэлнэ гэж тодорхойлжээ. Гэсэн хэдий ч "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль" нь уг заалттай зөрчилдөж байгаа ба шимтгэлээ нөхөн төлөх боломж олгосон. Энэхүү заалтын бас нэг сул тал нь залуу малчдын дунд хэзээ нэгэн цагт шимтгэлээ нөхөн төлөх боломжтой гэсэн хүлээлт үүсгэж байна.

"Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль"-иар тэтгэврийн насанд ойртож буй малчдад нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлөх боломж олгосон нь залуу малчдын дунд нийгмийн даатгалд хамрагдахад саад болсноос гадна уг боломжийг ирээдүйд ашиглаж болно гэсэн хүлээлтийг бий болгосон. Нөхөн төлөлт хийх хууль нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4, 21.1.5 дугаар заалтуудтай тус тус зөрчилдөж байна.

6.2.2. Үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд

Малчдыг нийгмийн даатгалын талаар мэдлэг мэдээлэлтэй болгож, НДШ төлөх эрмэлзлийг нэмэгдүүлэхэд урт хугацааны хүчин чармайлт хэрэгтэй. Орон нутгийн нийгмийн даатгалын байцаагч нар орон зай, цаг хугацаанаас шалтгаалан хангалттай төсөв мөнгөгүй зэрэг хязгаарлалтуудаас хамаарч малчдад хүрч үйлчилж чаддаггүй байна.

Хөдөө сумын нийгмийн даатгалын нэг байцаагч дунджаар 662 малчинд жил бүр хүрч үйлчлэх ажлын ачаалалтай. Сумын нийгмийн даатгалын байцаагч унааны боломж гарсан үедээ хөдөө малчидтай уулзахаар очиход тэдний зарим нь гэртээ байхгүй байх тохиолдол ихээхэн гардаг учраас байцаагч нар бүх малчидтай холбоо тогтоож, тэдэнтэй тулж ажиллах боломжгүй байдаг.

Хөдөөгийн сумдын нийгмийн даатгалын байцаагчид болон банкны салбарын ажилтнууд зөвхөн ажлын өдрүүдэд үйл ажиллагаагаа явуулдаг. Төвөөс алслагдсан нутагт оршин суугаа малчид сумын төв рүү өдөр бүр ирэх боломжгүй тул шаардлагатай үйлчилгээг авч чадахгүй байна. Улмаар малчид төлөх ёстой шимтгэлийн талаар мэдээлэл авах боломжгүйгээс гадна орлогын хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хүссэн үедээ шимтгэлээ төлөх боломжгүй байдаг. Үйлчилгээний хүртээмжгүй байдал

болоод төлбөрийн хэлбэр/сонголт хязгаарлагдмал учраас малчид хот суурин газар очих үедээ шимтгэлээ төлж чадахгүй тохиолдол гардаг байна.

Орон нутгийн төрийн албан хаагчид нэг нэгнийхээ ажил үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байж, нэгнээ орлох чадвартай байх шаардлагатай байна. Малчид багийн хурлаас мэдээлэл их авдаг байна. Сумын ЗДТГ-ын албан тушаалтан багийн хурал, уг уулзалтад очихдоо нийгмийн даатгал, нийгмийн халамж үйлчилгээ, татвар гэх мэт бүх үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх мэдлэгтэй байвал зохино.

6.3. Зөвлөмж

Нийгмийн даатгалын тухай хуулиар малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сайн дурын даатгалд хамрагдахыг зөвшөөрсөн. Монгол Улсын хүн амын бүх бүлгийг нийгмийн хамгаалалд хамруулах нь тэднийг болзошгүй эрсдэлээс хамгаалахад туслах болно. Гэсэн хэдий ч сайн дурын даатгал нь тавьсан зорилгодоо хүрэхгүй байгаа нь нотлогдсон бөгөөд энэ нь хүмүүсийг даатгалд хамрагдалгүй төрийн нийгмийн хамгааллын гадна үлдэх эрсдэлд оруулж байна. Олон улсын туршлагаас харахад хамрагдалтыг өргөжүүлж, хүний аятай тухтай амьдрах зохистой байдалд нийцсэн хамрагдах хэлбэрийг бүрдүүлэхийн тулд сайн дурын механизмаас илүүтэй албан журмын тогтолцоо нь илүү үр дүнтэй болох нь батлагдсан. **Тиймээс, энэ нь сайн дурын даатгалаас малчдын онцлог шинжүүдийг тусгасан албан журмын нийгмийн даатгалд шилжих шаардлагатай байгааг илтгэж байна.** Даатгуулагчдыг дэмжих бодлогын орчныг бүрдүүлэх, хэрэгжүүлэх механизмыг бий болгох гэх мэт хэд хэдэн дэд зөвлөмж бүхий цогц стратегийн нэн түрүүний ажил нь Монголын малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан журмын даатгалын тогтолцоонд шилжүүлэх ажил байж болох юм. Эдгээр зорилгод хүрэхийн тулд дараах зөвлөмжүүдийг санал болгож байна.

Зөвлөмж 1: Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх заалтыг түдгэлзүүлэх

Нийгмийн даатгалын тухай хуульд тусгасан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх заалтыг түдгэлзүүлснээр залуу малчдыг эртнээс, цаг тухайд нь нийгмийн даатгалын шимтгэлээ тууштай төлөхөд түлхэц болох юм.

Зөвлөмж 2: Малчдын нийгмийн даатгалын харилцааг зохицуулах хууль эрх зүйн тогтолцоог бий болгох

Монголд нүүдлийн мал аж ахуй зонхилдог тул *Малчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль* буюу өнөөгийн нөхцөл байдалд тохирсон эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй. Ийм төрлийн зохицуулалт нь малчдыг НДС-д гишүүнээр элсэхийг дэмжсэн, тэдний онцлогт нийцсэн шимтгэл, тэтгэврийн тогтолцоог бий болгох хэрэгтэй ба энэ нь хувиараа хөдөлмөр эрхлэгч гэх үндсэн тодорхойлолтоос тусдаа ангилалд байх нь зохилтой. Энэхүү тогтолцоо нь малчдын онцлогт нийцсэн байх хэдий ч, хөдөлмөр эрхлэгчид ажиллаж буй салбараа өөрчилсөн тохиолдолд сангийн хуримтлалыг хангах, эрхээ шилжүүлэх боломжийг олгох зорилгоор ашиглагдах тусдаа тогтолцоо биш болохыг анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж 3: Малчдын санхүүгийн чадавхад нийцсэн шимтгэлийг бий болгох

Өнөөгийн нийгмийн даатгалын хууль эрх зүйн хүрээнд даатгуулах нөхцөл болзол малчдын хувьд уян хатан бус шимтгэлийн хувь хэмжээ харьцангуй өндөр байгааг судалгаанд оролцогчдын олонх баталж байна. Иймд, малчдын шимтгэл төлөх аргачлалыг уян хатан болгож, өөрөө төлөх хуваариа гаргах, улирлын чанартай олох орлоготой нийцсэн хуваарь гаргахыг зөвшөөрөх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллагсад нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах бөгөөд тэдний төлөх шимтгэлийн нэг хэсгийг (50%) ажил олгогч хариуцан төлдөг. Малчдын хувьд тэтгэврийн даатгалын шимтгэл хуримтлалд хувь нэмэр оруулах хуулийн этгээд байхгүйг анхаарч төрөөс тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг хийж өгөх. Өөрөөр хэлбэл: "Ажил олгогч"-оос төлөх шимтгэлд зориулан 50 хүртэлх хувийн татаасыг төрөөс олгох (олон улсын жишгээр)

байдлаар тэдний хуримтлалыг нэмэгдүүлэх боломжийг зөвлөж байна. Хамрагдалтыг өргөтгөж гэдэг нь засгийн газарт санхүүгийн хөрөнгө оруулалт болох бөгөөд шимтгэлийг нөхөн төлүүлэх заалтыг түдгэлзүүлж хэсэгчилсэн байдлаар алдагдлаа нөхөхөд дэмжлэг болж болзошгүй. Сайн дурын гишүүнчлэлтэй холбоотой үйлчилж буй заалтын хүрээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд тооцсон хамгийн багаар төлөх шимтгэлийн хувь хэмжээг тодорхойлсон байдаг. Ирээдүйд өндөр насны тэтгэвэр авах хүсэлтэй малчид сайн дурын үндсэн дээр өндөр шимтгэл төлж болно. Албан журмын даатгалын хувьд шимтгэлийн хувь хэмжээг тогтоох зохих үндэслэлийг боловсруулах чадвартай системийг бий болгох нь зүйтэй. Энэхүү систем нь жишээлбэл, тухайн жилийн эсвэл өнгөрсөн жилийн мал аж ахуйн (бүтээгдэхүүний) борлуулалт дээр үндэслэн малчдын шимтгэл төлөх бодит чадавхыг тодорхойлно. Ингэснээр малчдын орлогыг баялгийн хэмжүүрээр нь ангилж, орлогыг шимтгэл тооцох үндэслэл болгоно. Үүнийг малын даатгалын тогтолцоотой уялдуулж, мал хорогдсон тохиолдолд малчдаас нэмэлт зардал гаргахгүй байхаар зохицуулах боломжтой. НДС-аас тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй болсны дараа баримт бичиг (мөн нөхөн олговор авахад шаардагдах нотлох баримт) бүрдүүлэх эцсийн хугацааг сунгахаас гадна тасралтгүй шимтгэлээ төлсөн бол зохих журмын дагуу нөхөн олговрыг нэмэгдүүлэхийг зөвшөөрөх нь зүйтэй.

Зөвлөмж 4: Шимтгэлийг бууруулах замаар залуучуудын гишүүнчлэлийг урамшуулах

Залуу малчдын гишүүнчлэлийн урамшууллыг илүү хүчтэй татаас олгох замаар хийж болно. Энэ хүрээнд залуу наснаас нь гишүүнчлэлд оруулахын тулд залуучуудын насны ангилалд (жишээлбэл, 15-24) зориулан шимтгэлийн хувь хэмжээг бууруулж болно.

Зөвлөмж 5: Шимтгэл хураах, тасралтгүй төлөх нөхцөлийг бүрдүүлж, урамшуулах

НДС нь шимтгэл төлөлтийн зөрчилтэй холбоотой нээлттэй, ил тод дүрэм боловсруулж аливаа зөрчлийг мэдээлэх ёстой. Тухайлбал, малчдын борлуулалтаас хамаарах шимтгэлийн дүнгийн үндэслэлийг тогтмол шинэчлэн тодорхойлох үйл явцыг хэрэгжүүлснээр орлогоо дутуу мэдүүлэх асуудал үүсэхгүй. Мал өмчлөх эрх, үйлдвэрлэлийн үйл явц дээр үндэслэсэн тооцоолол нь орлогын дутуу тайлагналд хүргэж болох тул үүнийг нийгмийн даатгалын байцаагч нарын хяналт шалгалттай уялдуулах боломжтой. Мөн хууль тогтоомжийг дагаж мөрдөх, шимтгэл цуглуулах талаар хөндлөнгийн байгууллагуудтай (эрүүл мэндийн даатгалын сан, татварын алба, арилжааны банкнууд, харилцаа холбооны түншүүд гэх мэт) хамтран ажиллах нь шимтгэл төлөгчидтэй холбоотой мэдээллийг нягталж, олж авах боломжийг гаргаж өгнө. Ийм төрлийн хамтын ажиллагааны гол элементүүд нь (i) холбогдох байгууллагууд хоорондын гэрээ, (ii) мэдээлэл солилцох хяналтын механизм (iii) маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл юм.

Олон улсын жишгийг судалж үзэхэд янз бүрийн хөшүүргийг ашиглан НДС-ийн гишүүнчлэл, тасралтгүй шимтгэл төлөхийг дэмждэг байна. Тухайлбал, шимтгэл төлөх шаардлагагүй элементийг тэтгэмжид нэмэлтээр оруулж өгөх, бусад эрсдэлийг үнэ төлбөргүй даатгалд хамруулах, нэрийн дансанд хуримтлагдсан хадгаламжийн хүүг инфляцаас хамгаалах баталгаа гаргаж өгөх гэх мэт. MNS 6926:2021 - Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндэсний стандарт гэх мэт баталгаажуулалтын үйл явцад малчдын нийгмийн даатгалын бүртгэлийг нэмэлтээр оруулж өгөх эсвэл "Ногоон бэлчээр төсөл-Хариуцлагатай нүүдэлчид" хөтөлбөрийг үндэсний хэмжээнд өргөжүүлэх замаар малчдын НДС-д оруулж буй шимтгэлийг мөшгөж, орлогоо зөв мэдүүлэх хөшүүргийг бий болгож болно. Төрийн өмчийн газарт мал маллахад тусгай зөвшөөрлийн тогтолцоог хэрэгжүүлж

болох бөгөөд ингэхдээ хэд хэдэн удаа зөрчил гаргасан тохиолдолд зөвшөөрлийг цуцалж хүчингүй болгох шийтгэлийн тогтолцоог нэвтрүүлэх боломжтой.

Зөвлөмж 6: Нийгмийн даатгалын боловсон хүчнийг нэмэгдүүлэх, сургах

Нийгмийн даатгалын байцаагч ба малчдын тооны харьцаа хэтэрхий зөрүүтэй байна. Нийгмийн даатгалын нэг байцаагч жилд дунджаар 662 малчин бүхий газар нутгийг хариуцаж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай тулгарч байна. Сумын нийгмийн даатгалын байцаагчийн орон тоог мал сүргийн болон малчдын тоотой уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай. Нэг талаас шимтгэл цуглуулах, нөгөө талд тэтгэмжийн төлбөр авах зэрэг тодорхой үйлчилгээг аль болох цахимжуулах нь зүйтэй. Мөн түүнчлэн байцаагч нар мэдлэг түгээж, малчид даатгалын үйлчилгээнд итгэл төгс сэтгэл ханамжтай байхад нь нөлөөлөх гол төлөөлөгч юм. Тиймээс, малчдын тоо нь байцаагчдын тооноос хэт давсан байгаа газар шинээр сургагч багш, сургалт хариуцсан ажилтнууд авч ажлын ачааллыг тэнцвэржүүлэх замаар ачааллаас үүдэлтэй асуудлуудыг шийдэж болно.

Зөвлөмж 7: Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

Е-Монголиа платформоор дамжуулан цахимаар материал илгээх, баталгаажуулах, лавлагаа авах боломж мөн төлбөрийн хэмжээ, нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээг сунгах хүсэлт гаргах гэх зэрэг асуудлыг малчдад илүү хүртээмжтэй болгох нь зүйтэй. Ердийн банкны үйлчилгээ нь дээр нэмээд малчдад нийгмийн даатгалын шимтгэлээ цахимаар эсвэл мобайл банкаар (цагийн хязгаарлалтгүйгээр иргэний үнэмлэхээ ашиглан) төлөх боломж бүхий төлбөрийн үйлчилгээг нэвтрүүлэх нь оновчтой.

Жил бүрийн мал тооллогын үеэр нийгмийн даатгалын байцаагч нар сумын Засаг дарга болон бусад албан хаагчдын хамт хөдөө орон нутгийн малчин өрхүүдэд зочилж, нийгмийн даатгалд хамрагдах ажлыг сурталчлах нь зүйтэй. Сургалт, сурталчилгаа явуулах үүрэг бүхий туслах байцаагчийн орон тоог бий болгосноор алслагдсан малчдад мэдээллийг хүртээмжтэй түгээх боломжтой болно. Малчдын нэгдсэн мэдээллийн санд түшиглэн НДШ-ын талаар лавлах, шаардлагатай бусад мэдээлэл болон зөвлөгөө авах, нийгмийн даатгалын гэрээгээ сунгах гэх мэт бололцоог бүрдүүлж өгөх, малчдад зориулсан улсын болон орон нутгийн (нийгмийн даатгалын газрын дэргэд) хэмжээнд байнгын ажиллагаатай, шууд холбогдох утасны үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгтэй. Хаврын улиралд малын гаралтай бүтээгдэхүүний зах дээр малчид малын гаралтай бүтээгдэхүүн, тэр дундаа арьс, шир, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүнээ борлуулахаар цугларах үед НД-ийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулахаас гадна төлбөр хураамжийг бүртгэх, цуглуулах нь нэн тохиромжтой. Хөдөө орон нутгийн малчдын өндөр орлого, нийгмийн даатгалын шимтгэл төлөх хүсэл эрмэлзэлтэй байгааг харгалзан үзэж тэдний ирж очих унааны зардал болон жолоочийн асуудлыг орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын төсөвт тусгах нь тус байгууллагын ажлыг эрчимжүүлж болох юм.

Зөвлөмж 8: Нийгмийн хамгааллын тогтолцооны талаарх мэдлэг, түүнд хандах хандлагыг сайжруулах.

Малчдын нэлээд хэсэг нь нас, боловсролын түвшнээсээ хамааран нийгмийн хамгааллыг (ач холбогдол) ойлгоход хэцүү байдаг ба төрөл төрөгсөд нь (ялангуяа охин, хөвгүүд нь) нас өндөр болсон үед нь эсвэл осолд өртсөн тохиолдолд асарч халамжилна гэж итгэдэг. Харилцаа холбоо, мэдээлэл түгээх

кампанит ажлыг олон нийтийн сүлжээ болон уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан дамжуулах, мэдээлэл хүлээн авах зорилгод бүлэгт тусгайлан зориулсан мессежийг өгөх боломжтой.

Олон нийтийн сүлжээгээр дамжуулан залуу малчдад өндөр насны хуримтлал эсвэл гэнэтийн ослын даатгалд хамрагдах нь чухал гэдгийг ойлгуулж болно. Гэсэн хэдий ч нийгмийн даатгалын сангийн оролцоог зөвхөн залуу малчдад чиглэсэн цахим хэлбэрээр хязгаарлаж болохгүй. Багийн түвшинд (боломжит) даатгуулагчид болон НДС-ийн хооронд харилцааг бий болгох үүднээс ээлжит уулзалтуудыг зохион байгуулж болно.

Олон нийтийн сүлжээ болон уламжлалт мэдээллийн хэрэгслээр дамжуулан ахмад насны малчдад улс орны хүн ам зүй болоод ажиллах хүчний өөрчлөлттэй холбоотой үнэн зөв мэдээлэл хүргэхийн зэрэгцээ нийгмийн хамгааллын шинэчлэлийн талаарх төрөөс авч хэрэгжүүлж буй зохицуулалтын бодит байдлын талаар мэдээлж болно. Түүнчлэн ахмад насны малчидтай тогтмол утсаар холбогдож шимтгэл төлөх хугацаа, даатгалын сонголт, даатгалд хийхээр төлөвлөж буй шинэчлэлийн талаар мэдээлэх боломжтой. Үүний тулд сумын нийгмийн даатгалын байцаагчтай биечлэн уулзаж танилцан, итгэлцэл бүхий харилцаа бий болсон байх шаардлагатай.

7. ДҮГНЭЛТҮҮД

1. Малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны талаарх ойлголт, зан үйлийг судлах ажлын хүрээнд

- Малчид нийгмийн даатгалд хамрагдах насыг 40-өөс дээш гэж үзэх нь элбэг байна. Энэ нь нэг талаас нийгмийн даатгалын талаар анхан шатны мэдлэггүй байгаатай холбоотой. Нөгөө талаас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль-ийн тодорхой заалттай холбоотой. Тухайлбал, тэтгэвэрт гарах насыг 55, 60 гэж тогтоосон бол харин шимтгэл төлсөн байх хугацааг 20-иос доошгүй жил байхаар хуульчилсан нь залуучуудад 40 нас хүрсэн хойноо нийгмийн даатгалын шимтгэлээ төлж эхэлбэл энэ шаардлагыг хангаж чадна гэсэн ойлголтыг төрүүлж байна.
- Малчдын нийгмийн даатгалын талаарх анхан шатны ойлголт дутмаг байгаагаас нийгмийн даатгалд хамрагдахгүй, шимтгэлээ тогтмол төлөхгүй, төлөхөө зогсоох эсвэл даатгалын тэтгэмжээ авах эрхтэй байсан ч нэхэмжлэхгүй байхад хүргэж байна.
- Чанарын ярилцлагаас харахад монголчууд уламжлалынхаа хувьд ирээдүйн үр өгөөж гэхээсээ илүүтэй одоогийн болон ойрын асуудалд илүү ач холбогдол өгдөг. Энэ хандлага нь малчдын нийгмийн даатгалд хандах хандлагад сөргөөр нөлөөлж байна.

2. Өнөөгийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын тогтолцооны малчдад хүртээмжтэй байдал ба уг тогтолцоотой холбоотой малчдын хэрэгцээ шаардлага, саад бэрхшээлийг судлах ажлын хүрээнд

- Малчдын хувьд осол, гэмтэлд өртөх нь их байгаа боловч даатгуулсан малчид мэдлэггүйн улмаас шаардлагатай бичиг баримтаа бүрдүүлж нөхөн төлбөр (эсвэл тэтгэмж) авах боломжоо алдаж байна. Энэ нь эргээд даатгалд үл итгэх байдлыг бий болгож, хамрагдалтыг бууруулдаг.
- Уламжлал ёсоор малчид өндөр насанд хүрсний дараа нийгмийн даатгал гэхээсээ илүү гэр бүлдээ (эхнэр, үр хүүхэд гэх мэт) итгэж найддаг. Тиймээс тэд өндөр настай болсон үедээ авч болох тэтгэвэртээ төдийлөн ач холбогдол өгдөггүй.
- Малчид нийгмийн даатгалд хамрагдах сонирхол бага, тогтмол орлогогүйн улмаас нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадахгүй, хот сууринаас алслагдсан байх эсвэл байнга тохиолдох байгалийн гамшигт үзэгдэл зэрэг нь нийгмийн даатгалд хамрагдахад сөргөөр нөлөөлж байна.
- Малчид тэтгэврийн насанд хүрсэн ч бай, үгүй ч бай мал аж ахуй эрхэлсээр байгаа нь гэнэтийн эрсдэлийг даван туулах хандлагад нөлөөлж байна (мал эсвэл малын гаралтай бүтээгдэхүүнээ борлуулах замаар).
- Малчид янз бүрийн түвшний боловсролтой, тогтсон ажлын цагийн хуваарьгүй байдаг. Тэд тараасан мэдээлэл, сурталчилгааны материалыг уншдаггүй, ойлгодоггүй /эсвэл амархан мартдаг (хэрэв уншсан бол). Нийгмийн даатгалын байцаагч нараас мэдээлэл сонсохгүй л бол мэдээлэлд итгэдэггүй. Мөн байцаагч нар гэрт нь очиход малчид эзгүй байсан тохиолдол цөөнгүй гарчээ. Малчид нийгмийн даатгалын талаарх мэдлэг дутмаг байгаагийн гол шалтгаан нь дээрх шалтгаанууд гэж нийгмийн даатгалын байцаагчид үздэг байна.

3. Малчдыг нийгмийн хамгааллын тогтолцоонд хамруулах, үргэлжлүүлэн хамрагдахад саад болж буй шалтгаанууд.

- Малчдын нийгмийн даатгалд хамрагдах хувь хэмжээ нь хүн ам зүй, хүйс, боловсролын түвшин, байршил, орлого зэрэг нийгмийн үзүүлэлтүүдээс хамаарч өөр өөр байна. Мэдлэгтэй, өрхийн орлоготой хүрэлцээтэй малчид нийгмийн даатгалын талаар харьцангуй сайн ойлголтой байдаг учир шимтгэл төлөх эрмэлзэлтэй байна.
- Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр нэмэлт тэтгэмж эдлэх боломжтой малчин эмэгтэйчүүд хүйсийн онцлогоосоо хамааран нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдах сонирхолтой байдаг.
- Эсрэгээрээ мэдээлэл багатай, алслагдсан газар нутагт амьдардаг эсвэл давхар ажил хөдөлмөр эрхэлдэг эрэгтэй малчид нийгмийн даатгалын шимтгэл төлөх нь (эсвэл ирээдүйд төлөх) бага байна. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт бага, нийгмийн даатгалын шимтгэлийг өвлүүлэх боломжгүй эсвэл мал маллаж олсон орлогоороо өөрсдөө амьжиргаагаа залгуулдагтай холбоотой.
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөө больсон үндсэн шалтгаануудын хувьд малчдын дийлэнх нь нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өндөр, бусад хэрэгцээгээ хангах шаардлагатай гэсэн өгүүлэмжтэй байна. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хувьд наад захын хэрэгцээгээ хангах нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

4. Чанартай үйлчилгээ үзүүлэхэд Монгол Улсын өнөөгийн чадавх

- Малчдын нийгмийн даатгалд хамрагдах эсэх нь тэдний орлогын хэмжээ, газар нутгийн байршил, цаг хугацаа, шимтгэлээ төлөх техник технологийн боломж, суурин газар луу ирж очих давтамж, орон нутгийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн ажлын цаг зэргээс ихээхэн хамаарч байна.
- Нийгмийн даатгалд хамрагдаагүй байгаа малчид ихэвчлэн алслагдсан хөдөө орон нутгийн иргэд байдаг тул тэдэнд хүрч ажиллан, мэдээлэл өгч, нийгмийн даатгалыг сурталчлах хэрэгцээ шаардлага байна. Мөн сумдын нийгмийн даатгалын байцаагч нарт тээврийн хэрэгсэл, санхүүгийн боломж хязгаарлагдмал байна.
- Монгол Улс 355 сумтай бөгөөд судлаачдын тооцоолж буйгаар 1 сая км.кв хэмжээ бүхий нутаг дэвсгэрт тархан суурьшсан 233 мянган малчид нь нийгмийн даатгалд хамрагдах шаардлагатай малчид байна. Монгол Улсад орон нутгийн 352 нийгмийн даатгалын байцаагч ажиллаж байгаа бөгөөд нэг байцаагчид 662 малчин оногдож байна. Тиймээс, эдгээр бүх малчдад үйлчилгээ үзүүлэх, сургалт, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулахад санхүүгийн, хүний нөөцийн болон тээврийн зардал маш хязгаарлагдмал байна.

5. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд малчдын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хууль, эрх зүйн орчноос үүдсэн бэрхшээлүүдийг тодорхойлох зорилтын хүрээнд

- Хууль эрх зүйн орчны хувьд малчдыг сайн дураар НД-д хамрагдах тухай заасан нь НД-д хамрагдахгүй байх боломжийг “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн хүрээнд зөвшөөрсөн нь сөргөөр нөлөөлж буй суурь хүчин зүйл болж байна.
- Нүүдлийн мал аж ахуйн зөвхөн Монгол улсад байдаг. Энэ өвөрмөц онцлогт тохирсон “Малчдын тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль”, эрх зүйн орчинг бүрдүүлбэл зохилтой.
- “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”, “Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль” гэсэн хоёр хууль нь залуу малчдад нийгмийн даатгалд хамрагдахгүй түр хүлээлт үүсгэх, төрөөс биднийг тэтгэврийн нас дөхсөн үед арга хэмжээ авч өгнө гэсэн ойлголтыг төрүүлж байна

6. Малчдад НД, ЭМД-г хүргэж буй байгууллагын болон технологийн тогтолцоог шинжлэх

- НДС-аас нөхөн төлбөр авах тохиолдолд, тулгарсан эрсдэлээ богино хугацаанд баримтжуулж, илгээсэн байхыг шаарддаг бөгөөд олгогдох нөхөн төлбөрийн хэмжээ нь хэт бага, нөхөн төлбөр эрсдэл өнгөрсний дараа олгогддог зэрэг нь малчдыг шаардлагатай үр шимээ хүртэхгүй байх нөхцөлд хүргэж байна. Жишээлбэл: гэнэтийн осолд өртсөн тохиолдолд эрүүл мэндийн байдлаас шалтгаалан түүнийгээ баримтжуулж, НД-ын байгууллагад хүргэх боломж хязгаарлагдмал байх бөгөөд баримт хүргэх явцад гарах зардал нь авах нөхөн төлбөрийн хэмжээнээс давах тохиолдол ч зарим үед байдаг. Энэ нь малчдыг нөхөн төлбөр хөөцөлдөхөөс төвөгшөөх авахгүй байх нөхцөлд байдалд хүргэж байна.
- Малчид төрийн байгууллагын ажиллах цаг, байршлаас үл хамааран дурын цагт НД-н гэрээгээ сунгах, шимтгэлийн хэмжээгээ лавлах, НДШ-ээ онлайн, мобайл банкаар төлөх, баталгаажуулах, мэдээлэл, зөвлөгөөг алсын зайнаас авах боломж хязгаарлагдмал байна. Эдгээр нөхцөл байдал нь нийгмийн даатгалын хамрагдалт үйлчилгээний хүртээмжинд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл юм.

Хавсралт

Хавсралт А. Ижил ковариациуд, магадлалын коэффициентуудыг ашигласан нийгэм, эрүүл мэнд, малын даатгалд хамрагдах магадлалын логистик регрессийн загварууд

Хувьсагч	Нийгмийн даатгал	Эрүүл мэндийн даатгал	Малын даатгал
Амьжиргаагаа залгуулах (1=Тийм)	1.353***	1.319***	1.091
Амьдралд тохиолдож буй үйл явдлын үндсэн шалтгаануудын талаарх хувь хүний ойлголт (1-дотоод/5-гадаад)	0.855*	0.784***	1.097
Эрсдэлд хандах хандлага (1-10)	0.987	0.978	0.982
Цаг хугацаанд хандах хандлага (1-10)	1.033**	1.001	0.991
Бусдад итгэх итгэл (1-10)	0.983	0.989	1.011
Чухал шийдвэр гаргахдаа хамгийн их зөвшилцдөг хүн			
Эцэг эхтэйгээ	(base)	(base)	(base)
Хань (эхнэр/нөхөр)	0.759*	0.868	0.997
Би өөрөө шийдвэр гаргадаг	0.584**	0.716*	0.738
Эргэн тойрны малчидтайгаа зөвшилцдөг	1.026	0.823	0.525*
Би өөрийн харьяалагдах малчдын бүлгэм/хоршоо/холбоодын гишүүдтэй зөвшилцдөг	0.629	1.316	0.649
Би орон нутгийн засаг дарга эсвэл төрийн албан тушаалтны тушаалыг дагаж мөрддөг	0.912	0.556	1.259
Бусад	0.696	0.832	1.066
Аливаа малчдын бүлэг/хоршоо/холбоонд харьяалагддаг (1=Тийм)	0.655***	0.783**	0.605***
Хүйс (эрэгтэй=1)	0.707***	0.549***	0.762***
Нас (жил)	1.062***	1.027***	1.005
Боловсрол			
Боловсролгүй	(суурь)	(суурь)	(суурь)

Бага	1.180	1.105	1.031
Бүрэн бус дунд	1.486	1.510	1.037
Бүрэн дунд	1.585	1.471	1.103
Тусгай дунд	1.615	1.323	0.953
Дээд	3.852***	2.384***	1.346
Өрхийн гишүүдийн тоо	1.036	0.964	1.038
Аймаг			
Баян-Өлгий	(суурь)	(суурь)	(суурь)
Завхан	2.533***	1.186	1.370*
Өвөрхангай	2.689***	1.682***	0.534***
Хөвсгөл	1.274	1.345*	0.766
Баянхонгор	2.704***	1.522**	2.265***
Төв	1.357	1.141	0.957
Өмнөговь	2.033***	1.367*	0.951
Сүхбаатар	2.272***	1.909***	1.342*
Тогтмол	0.067***	1.724	0.640
N	4000	4000	4000

Тайлбар : Ач холбогдол "****" нь $p\text{-value} \leq 0.01$, "***" нь $p\text{-value} \leq 0.05$, ба "**" нь $p\text{-value} \leq 0.1$
Эх сурвалж : Өөрсдийн тооцоолол

Хавсралт В. Түршилтын бүлгүүдийн хоорондох тэнцвэрийг шалгах (хэрэв ялгаа нь мэдэгдэхүйц бол тодоор, p -хувьсагч < 0.05)

Хувьсагч	Дундаж				P-value					
	T1	T2	T3	T4	D/1-2	D/1-3	D/1-4	D/2-3	D/2-4	D/3-4
Хүйс	0.60	0.47	0.55	0.57	0.000	0.013	0.123	0.001	0.000	0.345
Нас	38.28	38.34	38.83	37.77	0.893	0.155	0.198	0.187	0.147	0.006
Хүүхдийн тоо	1.89	1.78	1.89	1.76	0.063	0.935	0.039	0.074	0.831	0.046
Өрхийн гишүүдийн тоо	2.94	2.87	2.94	2.83	0.047	0.953	0.003	0.042	0.313	0.002
Малын даатгал	0.31	0.31	0.31	0.30	1.000	0.923	0.808	0.923	0.808	0.884
Нийгмийн даатгал	0.33	0.39	0.41	0.41	0.012	0.000	0.000	0.201	0.337	0.751
Эрүүл мэндийн даатгал	0.66	0.66	0.65	0.69	0.962	0.742	0.127	0.707	0.139	0.064
Ухрийн тоо	3.22	2.83	4.64	5.08	0.669	0.129	0.044	0.085	0.030	0.682
Адууны тоо	22.80	23.17	22.90	23.45	0.852	0.965	0.799	0.886	0.907	0.825
Тэмээний тоо	20.81	24.39	21.63	21.07	0.020	0.578	0.861	0.081	0.036	0.711
Хоньний тоо	165.39	192.60	183.85	170.36	0.022	0.057	0.558	0.501	0.067	0.175
Ямааны тоо	159.10	156.36	199.97	181.38	0.703	0.001	0.002	0.001	0.001	0.150
Нэг хүнд ногдох өрхийн орлого (сая)	5.47	5.64	5.61	5.64	0.638	0.707	0.628	0.903	1.000	0.898
Боловсрол 1	0.03	0.02	0.02	0.03	0.012	0.185	0.802	0.204	0.022	0.280
Боловсрол 2	0.11	0.15	0.11	0.07	0.016	0.772	0.007	0.007	0.000	0.016
Боловсрол 3	0.24	0.23	0.26	0.21	0.493	0.353	0.135	0.106	0.419	0.016
Боловсрол 4	0.51	0.49	0.51	0.56	0.502	0.788	0.028	0.348	0.004	0.054
Боловсрол 5	0.03	0.03	0.03	0.03	0.786	0.786	0.606	1.000	0.432	0.432

Боловсрол 6	0.08	0.09	0.07	0.09	0.339	0.500	0.339	0.104	1.000	0.104
Боловсролын хувьд нийт					0.026	0.707	0.038	0.026	0.000	0.008
Өрхийн тэргүүн 1	0.59	0.49	0.56	0.54	0.000	0.175	0.015	0.003	0.054	0.281
Өрхийн тэргүүн 2	0.33	0.43	0.37	0.37	0.000	0.049	0.035	0.005	0.007	0.890
Өрхийн тэргүүн 3	0.08	0.08	0.07	0.09	0.563	0.315	0.477	0.668	0.198	0.087
Өрхийн тэргүүний хувьд нийт					0.000	0.120	0.051	0.010	0.022	0.199
Бүс нутаг 1	0.27	0.25	0.25	0.24	0.306	0.414	0.199	0.836	0.795	0.641
Бүс нутаг 2	0.27	0.28	0.27	0.30	0.653	0.802	0.216	0.484	0.431	0.137
Бүс нутаг 3	0.22	0.27	0.26	0.23	0.013	0.047	0.668	0.612	0.039	0.118
Бүс нутаг 4	0.24	0.20	0.22	0.23	0.046	0.367	0.673	0.274	0.116	0.631
Бүс нутгийн хувьд нийт					0.033	0.243	0.458	0.678	0.130	0.287
Ажиглалт	1,000	1,000	1,000	1,000						

Хавсралт С. Тоон судалгааны асуумж

Оршил

Сайн байна уу. Сайхан зусаж байна уу? Миний нэрийг [судлаач өөрийн нэрээ хэлнэ] гэдэг. Би бол Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг "Хараат бус судалгааны хүрээлэн" /IRIM/ болон Нидерландын Маастрихтын их сургуулийн судалгааны багтай хамтран ажилладаг судлаач хүн.

Бид олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Монгол улсын малчдын дунд судалгаа хийж байгаа юм. Манай судалгааны ажлын гол зорилго бол малчдыг нийгмийн даатгалд хамруулж ирээдүйн тэтгэвэр тэтгэмжийг баталгаажуулахад чиглэгдэж байгаа юм. Бид судалгаандаа танайхыг оролцуулахаар сонгож байна. Та бидний ажилд тусалж, оновчтой үнэн зөв мэдээллийг өгнө гэдэгт итгэж байна. Таны өгөх мэдээлэл нь малчдыг нийгмийн даатгалд хамруулахад тулгамдаж байгаа бэрхшээлийг оновчтой шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр болох юм.

Та бидний судалгаанд хамрагдахыг хүсэж байна уу? ТИЙМ/ҮГҮЙ

Бидний хүсэлтийг хүлээн авсан танд баярлаж байна. Таны бидэнд өгсөн аливаа мэдээллийг нууцалж зөвхөн судалгааны ажлын дүгнэлтэд ашиглах болно. Энэхүү судалгаанд хамрагдсаны улмаас таны ажил амьдралд ямар нэгэн сөрөг үр дагавар учрахгүй гэдгийг бид баталж байна

Энэхүү судалгаанд оролцох нь та бидний сайн дурын үндсэн дээр явагдах асуудал юм. Иймд та ярилцлагад бүрэн болон хэсэгчлэн оролцох, татгалзах боломжтой. Хэрэв танд хариулахыг хүсэхгүй асуултууд байвал та надад мэдэгдэн шууд дараагийн асуулт руу шилжих боломжтой.

Бидний судалгааны ажилд хүндэтгэлтэй хандаж, идэвхтэй оролцож, үнэн зөв мэдээлэл өгсөн танд талархсанаа илэрхийлэн зохих урамшууллыг өгөх боломжтой.

АСУУМЖ

БҮЛЭГ 0. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Утасны дуудлагын дугаар
2. Дуудлага хийсэн ОН/САР/ӨДӨР
3. Өрх нь дараах бүрэлдэхүүнүүдийн алинд хамаарах вэ?
 1. Туршилтын бүлэг 1
 2. Туршилтын бүлэг 2
 3. Туршилтын бүлэг 3
 4. Хяналтын бүлэг 4
4. Үр дүн
 1. Бүрэн
 2. Оролцогч байгаагүй
 3. Түр зуур байхгүй
 4. Хойшлуулсан
 5. Татгалзсан
5. Та яг одоо хаана байрлаж байна вэ?
 1. Улаанбаатар
 2. Аймгийн төв
 3. Сумын төв
 4. Хөдөө орон нутаг
6. Таны зуслангаас сумын төв хүртэл ойролцоогоор хэдэн км вэ?
 1. [...] км
7. Танай өвөлжөөнөөс нь сумын төв хүртэл ойролцоогоор хэдэн км вэ?
 1. [...] км

БҮЛЭГ 1 ХУВИЙН БОЛОН ӨРХИЙН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

8. Хүйс
 1. Эрэгтэй
 2. Эмэгтэй
9. Та хэдэн настай вэ? (жилээр)
10. Та өрхийн тэргүүлэгч үү?
 1. Тийм, асуулт 12-руу шилжинэ үү.
 2. Үгүй
11. Хэрэв биш бол, та өрхийн гишүүний аль ангилалд хамаарах вэ?
 1. Эхнэр/нөхөр
 2. Хүү/охин
 3. Аав/ээж
 4. Ах/эгч/дүү
 5. Хадам аав/ээж

6. Хадам ах/эгч
7. Өвөө/эмээ
8. Ач/зээ
9. Бусад хамаатан
10. Бусад
12. Таны гэрлэлтийн байдал
 1. Гэрлэж байгаагүй
 2. Гэрлэсэн (гэрлэлтийн гэрчилгээтэй)
 3. Хамтран амьдрагчтай
 4. Салсан/тусдаа амьдардаг
 5. Бэлэвсэн
13. Таны эзэмшсэн боловсролын түвшин?
 1. Боловсролгүй
 2. Бага
 3. Бүрэн бус дунд боловсролтой
 4. Бүрэн дунд боловсролтой
 5. Тусгай дунд боловсрол / МСҮТ, хуучнаар техникум/
 6. Дээд боловсролтой
14. Та хүүхэдтэй юу (нас хамаарахгүй)? (тэмдэглэл: нас барсан хүүхдийг тооцохгүй)
 1. Тийм
 2. Үгүй, асуулт 16-руу шилжинэ үү.
15. Хэрвээ хүүхэдтэй бол, хүүхдүүдийн нас, хүйсийн мэдээллийг оруулна уу?

15.1	15.2 Нас	15.3 Хүйс 1. Эрэгтэй 2. Эмэгтэй	15.4 Энэ хүүхэд нь хаана амьдардаг вэ? 1. Нэг гэрт 2. Нэг сумд 3. Өөр сум, гэхдээ нэг аймагт, 4. Өөр аймагт 5. Улаанбаатарт
1			
2			
3			
4			
5			
6			
7			

16. Эцэг эхийг тань хэн асарч байгаа вэ?
 1. Асрамж шаардлагагүй
 2. Би
 3. Өөр хүмүүс
 4. Хамаарахгүй (Эцэг эх нас барсан)
17. Та хэдэн жил мал маллаж байгаа вэ? жилээр
18. Танай өрх туслах малчинтай юу?

1. Тийм
 2. Үгүй
19. Та малаа маллахаас гадна өөр давхар ажил эрхэлдэг үү?
1. Тийм
 2. Үгүй, асуулт 21-рүү шилжинэ үү.
20. Таны эрхэлдэг давхар ажил аль бүлэгт хамаарах вэ?
1. Цалинтай ажил
 2. Хувиараа бизнес эрхлэгч
 3. Цалингүй гэр бүлийн ажил
 4. Бусад.....

2. ӨРХИЙН БҮТЭЦ, СУУЦ, ӨМЧЛӨЛ

21. Танай өрхөд одоогоор хэдэн хүн амьдарч байна вэ?
